



Увс аймгийн Завхан сум

ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2012-2021 он)




Шарбулаг

2012 он

Завхан сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Засаг дарга Б.Пүрэвгончиг ахлагчтай сумын Төлөвлөлт, хяналтын хороо, ЗДТГ-ын дарга Т.Тамир ахлагчтай ажлын хэсэг хамтран 2012 оны 5 дугаар сард сумын төв Шарбулагт боловсруулав.

Төлөвлөгөөг сумын Төлөвлөлт, хяналтын хороо, Ажлын хэсгийн хамтарсан үр дүнгийн семинараар 2012 оны 05 дугаар сарын 24-нд хэлэлцэж сайшаав.

Хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2012 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж батлав. **Тогтоолын дугаар 10\01**



УВС аймгийн ЗАВХАН сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө нь тус сумын төр, нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн хамтын бүтээл бөгөөд өмчлөх, зохиогчийн эрх тус суманд хадгалагдана.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төлөвлөлт, хяналтын хороо жил бүр хэлэлцэж, төлөвлөгөөний явцыг үнэлэх, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох байдлаар сайжруулж байна.

ЗАВХАН сумын хөгжлийн энэхүү төлөвлөгөөг Мерси Кор олон улсын байгууллагын Хөдөөгийн агробизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тус байгууллагын арга зүй, зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулав.

Зөвлөх баг: Г.Маналжав

Ч.Чимид Мерси Кор ОУБ-ын Увс аймаг дахь төлөөлөгч



Энэхүү хөгжлийн стратеги төлөвлөгөөг
Завхан сумын Засаг даргын орлогч
С.ЭНХЦАЦРАЛ эмхэтгэж,
хянан тохиолдуулав.



УВС АЙМГИЙН ЗАВХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 05 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 10\01

Шарбулаг


Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” дахь хэсгийн заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийг хөгжүүлэх “Завхан сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө” (2012-2021 он)-г баталсугай.

Хоёр. Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг сурталчлах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт үнэлгээ хийх, тодотгон сайжруулж ажиллахыг сумын Төлөвлөлт Хяналтын Хороонддаалгасугай.

Гурав. Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг жил бүрийн сумын нийгэм эдийн засгийн зорилтонд тусган хэрэгжилт, үр дүнг тооцон ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг ИТХ-ын тэргүүлэгчид, сумын Засаг дарга нартүүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МИДЭР

НУТГИЙНХАА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ИРГЭН БҮР ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЖ ЧАДВААС ТӨЛӨВЛӨСӨН БҮХЭН ХЭРЭГЖИХ УЧИРТАЙ

Төрөлх нутгийг минь хөгжүүлэх “Сумын стратеги хөгжлийн төлөвлөгөө” \2012-2021 он\ боловсруулагдан гарч байгаад сумын жирийн иргэний хувьд талархалтай байна. Сум орны түүх, өнөө цагийн чадавхи, ирээдүйн боломжийг тооцоолон судалж хөгжлийн гарцаа тодорхойлж байгаа нь энэхүү хөтөлбөрийн гол үндэс юм.

Өнгөрсөн үед босоо тогтолцоо зонхилж, тэдний заавар, чиг шугамаар ажлаа төлөвлөн, гүйцэтгэгч маягаар ажиллаж ирсэн нь сум орон дорвитой хөгжих, өөрийн нөөц боломжоо тооцоолон дайчлах бололцоо хомс байлаа.



Орон нутгийн эрх мэдлийг нэмсэн, иргэдийн оролцоог эрхэмлэсэн, төрийн бодлого орон нутаг руу чиглэсэн, бие даан хөгжих боломжийн эхлэл нээгдэж буй цаг үед энэхүү хөгжлийн хөтөлбөр нь ард иргэд, сум орноо гэсэн сэтгэл зүтгэлтэй хүмүүсийн өргөн оролцоотойгоор боловсрогдож байгаагаараа онцлог юм.

Төлөвлөсөн бүхнээ хэрэгжүүлэх, нийгмийн хөгжилтэй уялдуулах, баяжуулах, тухайн он, оны зорилтондоо тусган хэрэгжүүлэх ажлыг ИТХ, Засаг дарга, холбогдох хүмүүс зохион байгуулан иргэн бүхний оролцоо дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй.

Завхан сум нь байгалийн баялаг, газар эх дэлхийгээ хөндөөгүй, онгон дагшинаар нь хадгалж ирсэн цөөхөн ард түмний нэг бөгөөд сонирхол татсан өвөрмөц, үзэсгэлэнт газар нутгаа түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, говь нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн МАА, түүн дотроо өвөг дээдсээс уламжлуулан өсгөж ирсэн тэмээн сүргээ өсгөн үржүүлж, Хүний хөгжлөө дээдэлсэн, Бие даан хөгжих чадамжтай, Байгаль эх дэлхийдээ ээлтэй сум болж хөгжих зорилго, чин хүсэл эрмэлзлийг хүлээн авч буй унаган нутгийн иргэд, гадаад дотоодын хүмүүс та бүхний өмнө хөгжлийн төлөвлөгөөгөө танилцуулж хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулан гаргахад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Мерси-Кор олон улсын байгууллага, хөтөлбөрийг гардан боловсруулсан сумын Төлөвлөлт Хяналтын Хороо, Ажлын хэсэг, оюун санааны хувь нэмэр оруулсан бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ПҮРЭВГОНЧИГ

ИРГЭДИЙН САНАА БОДОЛД БОДЛОГОО ТУЛГУУРЛАЯ

Завхан-энэ нэр Монгол улсын хөгжлийн түүхэнд 1925 оны эхээр тодорч өнөөдөр хүн бүхний мэдэх Завхан сум болсон билээ. Завхан зогсоо гэх энэ сум нар мандаж, шингэх тэр орон зайд оршин тогтнож ажил амьдралын өрнүүн хөдөлгөөн, халуун дулаан уур амьсгал оргилуулан, олон жилийг элээсээр өнөөдөртэй золгож байна. Энэ хугацаанд бид бүхнийг маань уламжлан удирдаж ирсэн үе үеийн удирдлагууд, ажил амьдралынхаа түүхээр холбогдсон бүх хүмүүс, Завханаар овоглосон сумынхаа



хөгжлийн түүхийг бүтээлцэж яваа эрхэм та бүхэндээ сумын ИТХ-ын нэрийн өмнөөс болон хувиасаа мэндчилгээ хүргэж чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Сумын 2012-2021 он хүртэлх хөгжлийн зорилго нь: Хүний хөгжилд тулгуурласан нийгэм эдийн засгийг хослуулан амьжиргааны түвшинг тууштай дээшлүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай өндөр технологид суурилсан тэргүүлэгч чиглэл бүхий хөгжлийн төв болох явдал юм.


Төлөвлөгөө нь амьдралын явцад боловсронгуй болж, баяжигдах баримт бичиг бөгөөд тусгагдсан хөтөлбөр төслүүдийг бүх хүн, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд хамтран бодит үр дүнтэй хөрөнгө оруулалтын ажил болгож хэрэгжүүлсэнээр иргэдийн амьдрал ахуй, амьжиргааны түвшинд өөрчлөлт гарч бүтээн байгуулалтууд болж үлдэх ёстой.

Уг төлөвлөгөөг боловсруулах ажлыг хариуцан ажилласан Төлөвлөлт Хяналтын Хороо, Ажлын хэсэг зохион байгуулж, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн Мерси Кор Олон Улсын Байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Завханчууд та бүхнийг нутгийн сүлд хийморь номын цагаан буян ивээх болтугай.

ЗАВХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА Ж.МИДЭР



ЗАВХАНЧУУДЫН ХӨГЖЛИЙН САНААЧИЛГЫГ АЙМАГ ДЭМЖИНЭ

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн залгамж чанарыг хангах зорилгоор хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийг сумынхаа онцлогт тохируулан боловсруулах нь нутгийн удирдлага, төрийн байгууллагын тулгамдсан асуудлын нэг болж байна. Энэ цаг үед Завхан сумын ИТХ, ЗДТГ, ард иргэд хамтран сумынхаа “Хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулан гаргаж байгаа нь ихээхэн ач холбогдолтой юм.

Өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагийн хөгжлийг бодитойгоор судлан үнэлэлт, дүгнэлт өгч сумынхаа хөгжлийн гарц, алсын хараа, тэргүүлэх чиглэлээ тодорхойлон хөтөлбөр төслүүдээр томъёолон гаргасан нь Хөгжлийн төлөвлөгөөг илүү ойлгомжтой, хэрэгжих үндэслэлтэй болохыг харуулж байна.

Сумын хөгжил айл өрхөөс, Аймаг, Улсын хөгжил сумаас эхтэй учраас Завханчуудын энэхүү хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг бодитой ажил болгоход Увс аймгийн төрийн байгууллагууд, олон нийт дэмжин ажиллана гэдгээ илэрхийлж байна.

Байгалийн үзэсгэлэнт газар нутаг, таван эрдэнийн нэг тэмээн сүргээрээ манлайлдаг Завхан нутгийн ард түмэн та бүхэнд өөрсдийн боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөөг бодит ажил болгоход нэгдмэл хүч санаа бодолтой, нэгэн үзүүрт сэтгэлээр хамтран ажиллаж амжилтанд хүрэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ГАРЧИГ

Д/Д	Бүлэг, сэдвийн нэр, агуулга	Хуудасны дугаар
1	УДИРТГАЛ	
2	СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ	
3	Төлөвлөгөө боловсруулсан үндэслэл	
4	Төлөвлөгөөний зорилго, зорилтууд	
5	Хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулсан арга зүй	
6	Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын зохион байгуулалт, зарчим, үйл явц	
7	Төлөвлөгөө боловсруулсан бүрэлдэхүүн	
8	СУМЫН ХӨГЖЛИЙН ОДООГИЙН БАЙДАЛ	
9	Сумын товч танилцуулга	
10	Нутгийн удирдлагын зохион байгуулалт	
11	Эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд	
12	Эдийн засгийн салбаруудын хөгжил	
13	Нийгмийн салбарын хөгжлийн байдал	
14	Байгаль орчны салбарын хөгжил	
15	Сумын эдийн засгийн чадавхийн үнэлгээ	
16	Сумын бизнесийн орчны судалгааны үр дүн ба дүгнэлтүүдийн тойм	
17	СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
18	СУМЫН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	
19	Сумын хөгжлийн зорилго, зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн тойм	
20	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамаарах талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг	
21	Хөгжлийн төсөл хөтөлбөрт оролцох хөрш зэргэлдээ сумдтай хамтран ажиллах	
22	ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ	
23	ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ	
24	ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТУУД	

УДИРТГАЛ.

Бид 2009 онд Сум хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байсан боловч өнөөдөр цаг үеийн шаардлагад нийцэхгүй болжээ.

Төр засгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого шийдвэрийг үндэслэн, орон нутгийн нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг хойшлуулшгүй шийдвэрлэх шаардлага чухлаар тавигдаж байгаа энэ үед Мерси Кор Монгол Олон Улсын байгууллагын зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр сумаа хөгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөг шинэчлэн боловсрууллаа.

Төлөвлөгөө боловсруулах үйл явцыг сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан Төлөвлөлт Хяналтын Хороо, Ажлын хэсэг тусгай ажлын чиглэл гарган зохион байгуулав.

Үүнд иргэд, олон нийтийг оролцуулан, тэдний санаа бодол, санаачлага, хэлэлцүүлэгт үндэслэн хөгжлийн алсын хараа, зорилго, зорилтууд, хөгжлийг хангахад чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг тодорхойллоо.

Төлөвлөгөөг боловсруулахдаа санал асуулгын хуудсаар хайрцгаар, дэвтрээр санал авах, бизнес орчны судалгаа, фокус бүлгийн ярилцлага хийх, зохион бичлэг, гар зургийн уралдааныг дунд сургуулийн сурагчдын дунд явуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, ганцаарчилсан уулзалт ярилцлага, чадавхийн үнэлгээ хийх зэрэг аргуудаар нийт 981 хүн оролцуулан тэднээс гарсан үр нөлөө бүхий саналуудыг 12 зорилт, 33 хөтөлбөр, 148 төсөл болгон боловсруулж, нийт 80107.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгав.

Хөгжлийн төлөвлөгөөнд сумын нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн салбар болох МАА-н салбар, үйлдвэрлэл үйлчилгээ, бизнесийн орчин, нийгмийн үйлчилгээ, байгаль орчны салбаруудад дүн шинжилгээ хийж онцлог болон давуу, сул талыг тодорхойлон олон нийтийн санал санаачлагад үндэслэн, хөтөлбөр төсөл, төсөв тооцооллыг тусгасан болно.

Төлөвлөгөөг 3 үе шаттай хэрэгжүүлсэнээр эрчимжсэн МАА тогтвортой өсөж, орон нутгийн нөөцөд суурилсан, байгаль орчинд ээлтэй байдлаар үйлдвэрлэл үйлчилгээ хөгжиж, иргэдийн орлого нэмэгдэх, иргэн бүр эрүүл, аюулгүй, таатай орчинд ажиллаж амьдрах нөхцөл бүрдэх юм.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнгийн талаар жил бүр тайлагнан ярилцаж, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, цаг хугацааны хүчин зүйлийн нөлөөллийг тусгаж байх юм.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

ЗАВХАН СУМЫН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ
“ТӨЛӨВЛӨЛТ,ХЯНАЛТЫН ХОРОО” “АЖЛЫН ХЭСЭГ”

Нэг. СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ**Төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага**

Монгол улс нь улс, аймаг, бүс, сум, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж ирсэн арвин туршлагатай ард түмэн юм.

Завхан сум 2009-2015 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Гэвч энэхүү хөтөлбөр нь иргэдийн оролцоо бага, тооцоо судалгаа хомс боловсруулагдсан учир өнөөгийн хурдацтай хөгжлийн явцад шаардлага хангахгүй байна. Иймд төрийн бодлого шийдвэртэй уялдуулан олон нийтийн оролцоон дээр тулгуурлан, тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Сумын ИТХ, Засаг даргын санаачлага, Мерси-Кор Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж байна.

Хөгжлийн төлөвлөгөөнд сумын хөгжлийг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, ая тухтай ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлэх ажил үйлчилгээг эрэмбэлэн нэрлэж, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, хэрэгцээт санхүүг тооцоолон, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, иргэдийн оролцоог бүх талаар хангах хөтөлбөр төслүүд тусгагдах юм.

Төлөвлөгөөний зорилго:

Сумынхаа онцлог давуу тал, нөөц боломжинд түшиглэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бие даасан байдлыг хангаж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, ая тухтай, амар тайван ажиллаж амьдрах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг урьдчилан төлөвлөхөд оршино.

Төлөвлөгөөний зорилтууд:

- ❖ Төрийн бодлого шийдвэр, улс, аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлог, давуу талд түшиглэсэн хөгжлийн хэтийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох
- ❖ Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон МАА-н тогтвортой өсөлтийг хангах, орон нутгийн нөөцөд суурилсан ЖДҮ-ийг хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх.
- ❖ Төрийн удирдлагын залгамж чанар, ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлж, төр, иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэх.
- ❖ Эрүүл, оюунлаг, бүтээлч сэтгэлгээтэй, өв соёлоо дээдэлсэн иргэнийг төлөвшүүлэх.
- ❖ Гадаад, дотоод хамтын ажиллагааг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээ болон бусад чиглэлээр хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх.
- ❖ Байгалийн нөөц баялгийг хайрлан хамгаалах, зүй зохистой хязгаарлалттай ашиглах, ээлтэй үйл ажиллагааг дэмжих.

Төлөвлөгөөний хамрах үе шат

Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2012-2021 оны хугацаанд хамран хэрэгжих бөгөөд хугацааны хувьд гурван үе шаттай байна.

- | | |
|-------------------|---------------|
| • Эхний үе шат | -2012-2015 он |
| • Хоёр дах үе шат | -2016-2018 он |
| • Гуравдах үе шат | -2019-2021 он |

Төлөвлөгөө боловсруулсан үйл явц, зохион байгуулалт

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулахад төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, нийгмийн бүхий л салбар, бүлгийн төлөөллүүдээс бүрдсэн Төлөвлөлт Хяналтын Хороо, Ажлын хэсэг гэсэн 2 бүрэлдэхүүнийг байгуулж, Мерси-Кор ОУБ-ын дэмжлэгтэйгээр мэргэжлийн зөвлөх багшаар удирдуулан ажиллалаа.

Төлөвлөгөөнд сумын хөгжлийн өнөөгийн түвшинг тодорхойлон, судалсны үндсэн дээр хэрэгцээ шаардлагаа тодорхойлон гаргаж, хөгжлийн алсын хараа, зорилго, зорилтууд тэдгээрийг хангахад чиглэсэн хэрэгжих боломжтой хөтөлбөр, төслүүдийг тодорхойлон тусгасан болно.

Төлөвлөгөөнд олон нийтийн оролцоог хангах, тэдний санал санаачлагыг тусгах, сумын хөгжлийн гарцыг хамтдаа эрэлхийлэх зорилгоор нийтдээ 981 хүний санал сэтгэгдлийг сонсож гол гол саналуудыг төлөвлөгөөнд тусгасан болно.

Олон нийтийн оролцоог хангасан байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Оролцооны үнэлгээ	Хэдэн удаа	Хамрагдсан хүн
1	Фокус бүлгийн ярилцлага	8	127
2	БОС	1	50
3	SWOT шинжилгээ	12	147
4	Олон нийтийн хэлэлцүүлэг	4	218
5	Санал асуулгын хуудас	1	100
6	Сумын чадавхийн үнэлгээ	1	50
7	Ганцаарчилсан ярилцлага	1	9
8	Мэдээллийн самбар	2	Тооцох боломжгүй
9	ЕБС-ийн зохион бичлэг	1	41
10	ИТХ-ын төлөөлөгч сонгогчидтой уулзах	1	50
11	Багийн засаг дарга айл өрхөөр явж санал авах	1	87
12	Саналын хайрцаг	2	13
13	Санал авах дэвтэр	1	14
14	Гар зургийн уралдаан	1	75
Д У Н			981

Эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөний онцлог

Сумын стратеги хөгжлийн төлөвлөгөө \2012-2021\ нь сумын өнөөгийн түвшиний тооцоо судалгааны үндсэн дээр тодорхойлогдож, олон нийтийн оролцоог ханган, тэдний санаа бодлыг тусгаж, МУ-ын хэмжээнд мөрдөж байгаа стандартын дагуу мэргэжлийн баг, зөвлөх багшийн арга зүйн дэмжлэгтэйгээр хөгжлийн алсын хараа, зорилго, зорилтууд тэдгээрийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг нэг бүрчлэн нэрлэж, хамрах хүрээ, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах төсөв санхүүг нарийвчлан тооцож боловсруулснаараа онцлог, хэрэгжих үндэслэлтэйг батлан харуулж байна.

Төлөвлөгөө боловсруулсан бүрэлдэхүүн:**Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:**

Дарга:	-Т.Тамир	-ЗДТГ-ын дарга
Гишүүд:	-Н.Цэвээн	-Төрийн сангийн дарга
	-Б.Мөнхцэцэг	-МЭҮТ-ийн менежер
	-Н.Эрдэнэцэцэг	-Улсын бүртгэгч
	-Ч.Давааням	-Сумын нийгмийн ажилтан
	-М.Даваасүрэн	-Архив, бичиг хэргийн эрхлэгч
	-Ж.Самдан	-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүн:

Дарга:	-Б.Пүрэвгончиг	-Сумын Засаг дарга
--------	----------------	--------------------

Эдийн засгийн хөгжлийн ажлын бүлэг

С.Өлзийдэмбэрэл	-Ажлын бүлгийн ахлагч, сумын ИТХ-ын тэргүүлэгч
Б.Баярсайхан	-Татварын улсын байцаагч, Сумын эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн
Н.Цэвээн	-Төрийн сангийн төлөөлөгч
Б.Мөнхцэцэг	-ЗДТГ-ын МЭҮТ-ийн менежер
Ц.Лхагважав	-ИТХ-ын нарийн бичгийн дарга
Ч.Лхагвацэцэг	-Тогтвортой амьжиргаа төслийн зохицуулагч
А.Ягаан	-Хувиараа бизнес эрхлэгч

Бизнес орчны хөгжлийн ажлын бүлэг

С.Энхцацрал	-Ажлын бүлгийн ахлагч, Засаг даргын орлогч
Б.Чулуунбат	-“Сүлд уул” ХХК-ийн захирал
Т.Эрдэнэ-Очир	-БИНХ-ын дарга
Ж.Баярхүү	-Хувиараа бизнес эрхлэгч

Төр, нийгмийн үйлчилгээний ажлын бүлэг

Т.Тамир	-Ажлын бүлгийн ахлагч, ЗДТГ-ын дарга
М.Энхтуяа	- Сургуулийн захирал
Г.Отгонсүрэн	- Цэцэрлэгийн эрхлэгч
Н.Пагмадулам	-Хүн эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан
Н.Эрдэнэцэцэг	- Улсын бүртгэгч
Х.Цэнджав	- Соёлын төвийн эрхлэгч
Ч.Давааням	- Сумын нийгмийн ажилтан

Байгаль орчны ажлын бүлэг

Ж.Самдан	-Ажлын бүлгийн ахлагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Б.Батмөнх	- Байгаль хамгаалагч
Н.Уламбаяр	- Цаг уурын өртөөний дарга
З.Туяацэцэг	- БГТЖДҮХХ мэргэжилтэн
Ц.Оюун-Эрдэнэ	-Газрын даамал
Г.Шагдарсүрэн	- Малчин



Хоёр. СУМЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сумын түүхэн товчоо Төрсөн нутгаас эх орон эхтэй, төрсөн нутгаа мэдэхээс танин мэдэх их үйлс эхлэлтэй. Монгол оронд ардын хувьсгал ялсны дараа Монгол Ард Улсын Засгийн Газрын 1923 оны 10-р сарын 19 –ний өдрийн хурлын 39-р тогтоолоор аймгуудын нэрийг өөрчлөхөд Засагт хан аймгийн Сартуул цэцэн вангийн хошууг Хантайшир уулын аймгийн Цэцэн сартуулын хошуу гэж өөрчлөн нэрлэжээ. Манай сумынхан Хантайшир уулын аймгийн Цэцэн сартуулын хошуу, Чандмань уулын аймгийн Баянчандмань хошууны ард олны удам хойч юм.



1924.06.06-нд Сартуулын цэцэн вангийн хошууны төлөөлөгчдийн анхдугаар хурлаар газар усны нэрээр нэрлэгдсэн 16 сум байгуулсны нэг нь “Зогсоо уул” сум байв. Энэ үеэс одоогийн Завхан сумын суурь тавигджээ. 1930-аад оны үеэс засаг захиргааны хуваарийг өөрчилж 13 аймагт хуваах зорилт тавих болсон.

1930 оны 8-р сарын 5-аар өдөрлөсөн бичигт “Зогсоо уул” сумын захиргааны газар тус хошууны газраас нутгийн захиргаа байгуулахаар тусгай томилогдсон комиссын гишүүн Намжил хүрэлцэн ирж, сумын дарга Гүрцоо харьяат сумын ардуудыг зохих газраас зарлан хуралдуулав. Хурлын тогтоолд : <<Тус сумыг Увсын ангид үндсэн нутгаар идээшлийг тохируулан эцсийн хөгжлийг бататган буй хэмээн тогтоов >> гэжээ. Ийнхүү засаг захиргааны хуваарийг бүрэн шинэчлэхэд Увс аймаг байгуулагдаж “Зогсоо уул” сум бүрэлдэхүүнд нь багтаж, 1932 оноос Завхан сум хэмээн нэрлэгдэх болсон түүхтэй. Сумын төв нь Гуугийн сайр, Зогсоогийн ар зэрэг газруудаар нүүдэллэн байрлаж байгаад 1945 оны хавар Шар булагт төвлөрчээ.

Монгол орон даяар өрнөсөн нэгдэлжих хөдөлгөөнд тус сумын иргэд идэвхитэй оролцож, анх 1954 онд “Айраг нуур” нэгдэл, 1958 онд “Сандалай нэгдэл”, 1959 онд “Ардын зориг” нэгдэл тус тус байгуулагдаж удалгүй 1959 онд эдгээр жижиг нэгдлүүд нэгдэн “Сан далай” нэгдлийг байгуулж байсан түүхтэй юм. Төр засгаас явуулж буй бодлого, хөдөлмөрч түмний зүтгэл бүтээлээр нэгдэл нь аж ахуйн хувьд өргөжин хөгжиж, малын тоо толгой нэмэгдэн ард олны амьдрал ахуй сайжирч 1973, 1989 онуудад сумын болон нэгдлийн “Түмэн тэмээний баяр” хийсэн нь улсын нийт малын дотор тэмээн сүргийн тоо толгой өсөхөд чухал ач холбогдол болсон юмаа. Тус сумын хөдөлмөрчид социалист бүтээн байгуулалтандаа гарамгай амжилт гарган 1954 онд БНМАУ-ын ЗГ-ын “Хүндэт үнэмлэх”, 1964 онд ЗГ-ын “Хүндэт жуух”-аар тус тус шагнагдаж байжээ.

Өнөөгийн байдлаар тус сум нь 500 гаруй өрхтэй, 2000 гаруй хүн амтай. Засаг захиргааны 4 багтай. Төсөвт байгууллага – 6, төрийн мал эмнэлэг үржлийн тасаг – 1, хувийн мал эмнэлэг – 2, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага – 15, банк санхүүгийн тооцооны салбар – 2, ахуйн үйлдвэрлэл үйлчилгээний нэгдсэн цэг – 1, талх нарийн боов үйлдвэрлэлийн цех – 2, худалдаа үйлчилгээний газар, дэлгүүр – 15, хоолны газар, кафе, халуун ус, үсчин, компьютер, каноны үйлчилгээ, гэр ахуйн модон эдлэлийн цех, ингэний фермер тус тус үйл ажиллагаа явуулж иргэд хөдөлмөрчдөд үйлчилж байна.

Нутаг дэвсгэр, хил хязгаарЗавхан сум нь Монгол орны баруун хойд хэсэгт их нууруудын хотгорт хойд өргөрөгийн 48 градус, 49 минут 24 секунд, зүүн уртрагийн 93 градус 07 минут 03 секундэд оршдог. 682,9 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй. Хамгийн өндөр цэг нь Гилбэн уулын “Дарцагт – Оргил” далайн түвшинээс дээш 1551 метр, хамгийн нам цэг нь Хяргас нуурын эрэгт 1028 метрт оршдог. Сумын нутгийн баруун зах нь Аравжуулын худаг, зүүн зах нь өндөр Харын уулс, хойд зах нь Хөх нурууны худаг, өмнөд зах нь Дарга уул юм. Нийслэл Улаанбаатар хотоос - 1350 км, аймгийн төвөөс-176 км алслагдсан. Тус сум нь хойд талаараа Увс аймгийн Наранбулаг, Малчин, зүүн болон зүүн хойд талаараа Хяргас, Цагаанхайрхан, баруун болон баруун хойд талаараа Өлгий, Ховд аймгийн Мянгад, баруун урд болон урд талаараа Ховд аймгийн Дөргөн, Завхан аймгийн Дөрвөлжин, зүүн урд талаараа Завхан аймгийн Ургамал сумуудтай тус тус хиллэдэг. Сумын нутаг нь газарзүйн мужлалтаар говийн мужид хамаарах ба бүхэлдээ Хяргас нуурын хотгорт оршино.

Газрын гадарга, хөрсний бүтэцГазрын гадарга нь цав толгод, намхан уулс, ухаа гүвээ, хотгор бүхий талархаг байдалтай. Завхан, Хүнгүйн голуудын орчмоор элсэрхэг хөрстэй. Манай суманд Тас хайрхан, Зогсоо хайрхан, Гилбэн, Толбин, Үнэгт, Зайсангийн уулс, Цэнхэрийн хөндий, Улаан уулын болон Сангийн далайн хөдөө, Цагаан түнгэ зэрэг нүд алдам уудам тал хөндий олон бий.



Геологийн тогтоц, ашигт малтмал Манай сумын нутаг нь геологийн тогтцын хувьд нутгийн ихэнх хэсгээр элс хайрга, элсэнцэр, шавранцар, хурдас түгээмэл тархсан бөгөөд Завхан голын хөндийгөөр ихээхэн байдаг. Хяргас нуурын өмнөд захаар уулын бялхмаг чулуулаг, Улаан дэл уул орчмоор эртний төрмөлийн гүний гаралтай чулуулаг элбэгтэй. Айраг нуур, Хүнгүйн голын зүүн талаархи нутагт Цахиурлаг занар, Хас, Шаварлаг занар, Элсэн чулуу түгээмэл байхад Зайсан уул орчмоор дунд төрмөлийн галавын их газрын тунамал чулуу тархмал байдаг. Манай сумын нутаг хэвлийдээ болон хөрсөн дээрээ металл ба металл бус ашигт малтмалын багагүй баялагтай. Тухайлбал: Улаан дэл, Шар толгой орчимд химийн ховор элемент, Айраг нуурын зүүн талд зэс, баруун хөдөөд хүхэр, Зогсоо хайрхан, Урд хөдөөд чулуун нүүрсний илэрцүүд ажиглагддаг ба цагаан давс, хужир, наанги шороо, гялтгануур, боржин чулуу, зос элбэг бий. Ашигт малтмалын хувьд судлагдан шинжлэгдсэн тодорхой нөөцтэй илэрцүүдтэй боловч эдийн засгийн эргэлтэнд оруулж, ашиглахгүй байгаа нь сүүлийн жилүүдэд уул уурхайн чиглэлээр ашиглалтын болон хайгуулын зөвшөөрлийн эрхийг олгоогүйтэй холбоотой бөгөөд байгалиа унаган төрхөөр нь хадгалах боломж бүрдсэн болно.

Цаг агаарын нөхцөл байдалСумын нутаг нь бүхэлдээ говийн бүсэд багтдаг. Эрс тэс хуурай уур амьсгалтай. Зундаа гандуу, өвөлдөө хахир хатуу хүйтэн болдог, хавар, намар салхи шуурганы давтамж ойр ойрхон байдаг онцлогтой нутаг юмаа. Газар зүйн бүсийн хувьд Их нууруудын хотгорт нам доор хонхорт оршдог учир агаарын уруудах урсгал зонхилж эсрэг циклон үүсэн тогтвортой байрладаг. Өвлийн улиралд эсрэг циклон тогтвортой байрласнаар цаг агаар тогтуун салхигүй болж, шөнөдөө ихээхэн хүйтэрдэг учир тус суманд жилд дунджаар 90-110 хоног хүйтэн хадгалагдаж байдаг. Харин дулааны улиралд их хэмжээгээр халж жил бүрийн 6-8-р сард халуун хадгалагддаг. Өвөл, хаврын улирал үргэлжлэх хугацаа харьцангуй урт, зуны улиралд

хур тундас бага унадаг учраас ерөнхийдөө хуурай уур амьсгалтай. Жилд орох хур тундасны хэмжээ дунджаар 33.1-87.4 мм байх бөгөөд дийлэнх нь 7,8,12-р сард ордог. Тус сумын нутагт цас харьцангуй бага орох бөгөөд өвлийн улиралд хүйтэн жиндүү байх хугацаа урт байдаг учраас цасан бүрхүүлтэй хоногийн тоо жилд дунджаар 70.4 хоног байна.

3-11 сарыг хүртэл хугацаанд салхи шуурганы давтамж ихсэж 15 м/с –ээс дээш салхи шуургатай хоног жилд дунджаар 45-60 хоног байна. Жилийн дундаж хамгийн хүйтэн нь -22°C , хамгийн дулаан нь сарын дундаж 20°C байдаг.

Гадаргын болон гүний усны нөөц Нутаг дэвсгэрийн 1/3-ийг ус эзэлдэг. Монгол оронд усны нөөцөөр 2-т ордог Хяргас нуур, Айраг нуур, Завхан, Хүнгүйн голуудтай.


Завхан гол: Хангайн нурууны ноён оргил Отгон тэнгэр уулнаас эх авч баруун хойд зүг Завхан аймгийн нутгийг дамжин 808 км урссаар манай сумын нутагт орж ирж 62 км урсаж айраг нуурт цутгадаг. Сав газрын талбай 57514 ам км, хэвгий 2,3 хувь болно. Завхан гол айраг нуурт цутгахдаа Сэтэртийн гол, Улаан сайр, Хүрэн бураа, Шонт, Овоот гэсэн 5 салаа гол болж урсдаг байсан.



Сүүлийн жилүүдэд байгаль цаг уурын өөрчлөлт, хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас хамааран Завхан голын ус татарч ширгэх, улмаар 2 нуурын усны түвшин багч, салаа голуудын голидрол алдагдаж элсэн хэв үүсэх, загас жараахай ихээр устаж үгүй болох аюул нүүрлээд байсанд нутгийн удирдлагууд сэтгэл зовинон УИХ,ЗГ, холбогдох дээд шатны байгууллагууд, гол мөрний хөдөлгөөн, хэвлэл мэдээлэл, радио телевизүүдийг орон нутагт газар дээр нь урин ажиллуулж, Телевизийн тусгай нэвтрүүлэг, хэвлэл мэдээллээр асуудал дэвшүүлэн тодорхой тэмцэл хийж хамтран ажилласны үр дүнд тайширын усан цахилгаан станцыг тавиулж Завхан гол ирсэнээр байгаль экологи сэргэж, хэвийн нөхцөл бүрдээд байна.

Хүнгүйн гол: нь Бор хярын элснээс эх авч Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Завхан мандал, Ургамал сумын нутгийг дайран урсаж Айраг нуурт цутгадаг. Хүнгүйн гол нь 196 км урсагаас 25 км нь манай нутаг дээгүүр урсдаг.

Айраг нуур нь: 143 ам км талбайтай, 16 км урт, 13 км өргөн, их гүн 11 м, дундаж гүн нь 5.7 м, 1030 метрийн үнэмлэхүй өндөрт оршдог, цэнгэг устай нуур юм. Хангайн нуруунаас эх авсан Завхан, Хүнгүй хоёр гол цутгана. Уртаараа 5 км, өргөнөөрөө 200-300 метр усан хоолойгоор Хяргас нууртай холбогдоно. Айраг нуур нь



олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай “PAMSAR”-ын конвенцид 1999 онд бүртгэгдсэн байдаг. Зуны улиралд олон төрлийн шувууд нүүдэллэн ирж үр төлөө бойжуулна. Энэ нуур нь алтайн сугас, давжаа ба нохойн сугас, осман, монгол хадран, хайруус, шар загас зэрэг хүнсний төрлийн загастай. 1985

онд доктор А.Дулмаагийн хийсэн нөөцийн тодорхойлолтоор Хяргас нуураас 250 тн, Айраг нуураас 150 тн загасыг жилдээ ашиглах боломжтой гэсэн судалгаа байдаг.



Хяргас нуур: Увс аймгийн 2 дахь том нуур Хяргас нуур нь Айраг нуураар дамжин Завхан, Хүнгүйн голын усаар тэжээгддэг. Хяргас нуур нь 1407 ам км талбайтай, 75 км урт, 19 км өргөн, 80 метр гүн, усны мандал нь 1028 м-ийн үнэмлэхүй өндөрт оршдог, давстай \1литр усанд 7.54 гр\ тогтмол нуур юм. Айраг, Хяргас нуур нь 2000 онд байгалийн цогцолбор газар болж Улсын тусгай хамгаалалтанд орсон. Айраг Хяргас нуурын байгалийн цогцолборт газар нь Увс аймгийн Завхан, Наранбулаг, Хяргас, Малчин сумуудын зарим хэсгийг хамарсан 332.8 мянган га

талбайг эзэлдэг.

Ургамал, амьтны аймаг Говь нутгийн тачир сийрэг ургамал голлох боловч хонь, тэмээн сүрэгт нэн тохиоромжтой түнгэ, шаваг, шарилж, тэсэг, таана, хөмүүл, бахлуур, бударгана, хялгана, хамхуул, цахилдаг, харгана, агъ, дэрс зэрэг 100 гаруй нэр төрлийн малын тэжээлийн, чихэр өвс, гоёо, тарваган шийр, дэрс, тэмээн хөх зэрэг 10 гаруй төрлийн эмийн ургамал ургана. Суль, сулхир, хармагны буурцаг зэрэг хүнсний ургамлууд ургадаг. Сульхирыг бөөр, нуруу, ядаргааны эмчилгээнд мөн гурил хийж хүнсэнд хэрэглэж байна. Сулийг мөн гурил хийж хүнсэнд хэрэглэдэг. Ан амьтдаас үнэг, чоно, хярс, дорго, заарт харх, туулай, мануул, өмхий хүрэн, цагаан зээр, янгир байдаг бөгөөд дээр үед зэгсний гахай, хулан, хар сүүлт бөхөн цөөнгүй байсан гэлцдэг. Зуны сард хун галуу\ хар, бор\ ангир, нугас, цахлай \саарал, мөнгөлөг\ зуун хурга, тогоруу, тоодог, хотон зэрэг жигүүртэн шувууд нуур усанд нь чуулж, бүргэд ёл, тас уулын орой дамжин хүүглэнэ. Мөн хадны тагтаа, болжмор, улаан хошуут,



монгол хулан жороо, харцага, шаазгай, шар шувуу, сарьсан багваахай, өөлжин, хөх цэцэг, бор бялзуухай, хүн уйл, оронгийн бор ногтруу, ятуу зэрэг 30 гаруй төрлийн шувууд, 2 нутагтан мөлхөгчдөөс хонин ба могой гүрвэл амьдардаг.

Байгалийн үзэсгэлэнт болон дүрсгалт газрууд Тус суманд Хэцүү хад, Нуурын хоолой, Цахир хошуу, Хайчийн агуй, хавтгай цагаан манх зэрэг байгалийн үзэсгэлэнт газар олонтой, аялал жуулчлал хөгжих өргөн боломж бий.

Хэцүү хад: Хяргас нуурын баруун урд хэсэгт орших, уртаашаа 2-3 км үргэлжлэх хадан хясаатай байгалийн онц сонин тогтоцтой, элсэрхэг, тачир өвс ургамал ихтэй нутаг юм. Энд 10 гаруй эгц ханан хад, өндөр нь 2.5 м, урт нь 4 м, өргөн нь 3 м орчим агуй бий. Үүнийг “Хүний агуй” гэж нэрлэдэг. Хэцүү хадны тухай Оросын жуулчин судлаач А.В.Бурдуков “Хэцүү хад бол байгалийн гойд сонин тогтоц, үзэсгэлэнт сайхнаараа монголд хоёрдогч нь юм” гэж онцлон тэмдэглэсэн байдаг. 2007 оноос нутгийн уугуул С.Хийморсан “Хэцүү хад” аялал жуулчлалын бааз байгуулан үйл ажиллагаа явуулж гадаад, дотоодын амрагчдад үйлчилж байна.

Нуурын хоолой: Айраг, Хяргас нуурыг холбосон 5000 метрийн урттай, 200-300 метрийн өргөнтэй, 8 метрийн гүн усан хоолойг нуурын хоолой буюу Гурван нуурын сэлгээ гэж нэрлэдэг. Энд аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой юм.



“Сангийн далай”-н давсны орд газар: Манай сумын төвөөс баруун зүгт 30 км-т орших, 250 га талбай бүхий Улаан давстай нуур юм. Өргөн нь 2.2 км, урт нь 7.9 км, нийт талбай нь 12.1 ам км бүхий улаан давсны томоохон уурхай бүхий орд газар юм. Давсны найрлага нь хлорит натри-89.6-89.0 %, хоолны II зэргийн давстай гэж тогтоожээ. Нөөц нь – 197874 тн. Сангийн далайн давсны үеийн зузаан дунджаар 15-20 см, давс нь улаан өнгөтэй, жижиг дунд талстаас тогтдог. Давсны уусмалтай тогооны талбай нь 3000-6000 м² гэж тогтоожээ. Мөн Цайдам, Сэнсий зэрэг нутагт цагаан давс, хужирын нөөцтэй.

Сумын бахархал: Унаган нутгаас минь төрөн гарсан эх оронч, эрдэмтэн, гавьяат, хөдөлмөрийн сайчуудаараа бид бахархана.

Эх орныхоо төлөө тулалдаж явсан ахмад дайчид :

**1911оны ҮЭЧХөдөлгөөнд оролцож
Ховдыг чөлөөлөх тулаанд оролцож явсан
дайчид**

1. Гарваагийн Сэднамжил
2. Наджавын Бадамдоо
3. Ранаа Гэвш
4. Луугийн Вамба
5. Буянбал
6. Буяндүүрэн

**1939 оны халх голын дайн, 1945 оны
чөлөөлөх дайнд оролцогчид :**

1. Тогоохүүгийн Содномдаржаа
2. Ажаахүүгийн Ойдов
3. Дондогийн Ойдов
4. Лхамын Базаржав

5. Лхамын найданхүү
6. Цагааны Халтмай
7. Бат-Очирын Жамбаахүү
8. Ламжавын Сосор
9. Жанжинхүүгийн Авархүү
10. Дондовын Наянхүү
11. Дорлигийн Намжиг
12. Дорлигийн Бадайхүү
13. Ёндонгийн Дэмбэрэл
14. Булганы Даваажав
15. Баянбайн Түвдэн
16. Баянбилэгийн Зоноров
17. Өлзий-Очирын Магсаржав
18. Сайнхүүгийн Зодов
19. Нацагийн Жүгдэр

20. Чулууны Даш
21. Баярмагнайн Баасанжав
22. Нацагийн Мавган
23. Балганы Цэрэндорж
24. Вандангийн Гэдэнжав

**1947-1949 онд баруун хязгаарыг
хамгаалах тулаанд оролцогчид :**

1. Гомбын Сандав
2. Тасрангийн Цэрэндорж
3. Лхамын Найданхүү

4. Мэрэгийн Жамба
5. Луйсын Оригжав
6. Мөнөөжавын Самдан
7. Охины Өлзийтогтох
8. Довчингийн Гантогтох
9. Совдын Зундуй
10. Булганы Жамсрандорж
11. Бүрнээбаатарын Жамсран
12. Намжилын Самбуу

АИХ-ын депутатууд :

1. Хөтгөрийн Сайнхүү – 1935
2. Нанзадын Бүрэн - 1940
3. Маажавын Булган – 1949
4. Машийн Ням – 1949

5. Хайнзангийн Норов – 1961
6. Галдандаваа Шагдарсүрэн - 1966
7. Жалцавын Энэбиш – 1973
8. Балдангийн Бадарч – 1977
9. Галдандаваагийн Бямбаа – 1991

МУ-ын хөдөлмөрийн баатар, аварга малчин, гавьяатууд

1. Галдандаваагийн Шагдарсүрэн – Хөдөлмөрийн баатар 1963 он

Улсын аварга малчид :

1. Гозгорын Бааст – 1963
2. Цэвэлийн Чулуун – 1968
3. Бүрнээбаатарын Жасран – 1983
4. Шархүүгийн Надмид – 1985
5. Шархүүгийн Бааст – 1987
6. Хамбын Жадамба – 1987

7. Тавхийн Бааяа – 1988
8. Галдандаваагийн Бямбаа – 1988
9. Жодовын Эрдэнэ – 1989
10. Баянтөрийн Чулуун – 2004
11. Т.Цэвэгмид – Улсын аварга тариаланч

Гавьяат цолтнууд :

1. Балдангийн Бадарч – Гавьяат хуульч 1976
2. Рэнцэнгийн Авирмэд - Гавьяат хуульч 1981
3. Баярын Равсал – Соёлын гавьяат зүтгэлтэн
4. Сүрэнжавын Тамир – Гавьяат нисгэгч 1985
5. Галдангийн Совд - Гавьяат хуульч 1991
6. Гончигийн Жанчив – МУГЖ 1993
7. Тамирын Батбаяр – Гавьяат нисгэгч
8. Ойдовын Лхагва – ШУ-ы гавьяат зүтгэлтэн 2002
9. Ш.Ган-Очир – Хүний гавьяат эмч
10. Г.Вандандагва – Төмөр замын гавьяат ажилтан
11. Цэрэнгийн Дэмбэрэл – Гавьяат багш

Эрдэмтэн, доктор, профессорууд :

1. Ойдовын Лхагва – ШУ-ы доктор, профессор
2. Галдангийн Галбадрах – ЭЗ-ийн ухааны дэд эрдэмтэн
3. Сосорын Ишдорж – Түүхийн ухааны дэд эрдэмтэн

4. Цэндийн Гомбодорж – Техникийн ухааны дэд эрдэмтэн
5. Ламжавын Баттулга – Физикийн ухааны дэд эрдэмтэн, дэд профессор
6. Пүрэвийн Зузаан – Физик, математикийн ухааны доктор, дэд профессор
7. Доржийн Баатар – Хууль зүйн ухааны дэд эрдэмтэн
8. Сэндрэгчийн Мягмар – Философийн ухааны дэд эрдэмтэн
9. Цэрэнгийн Дэмбэрэл – ЭЗ-ийн ухааны дэд эрдэмтэн, профессор
10. Ойдовын Бат-Эрдэнэ – Биологийн ухааны дэд эрдэмтэн
11. Чойжилжавын Чойсамба – Доктор Ph D
12. Мөнхийн Оюун – Техникийн ухааны доктор Ph D
13. Адьяагийн Алтанхуяг - доктор Ph D
14. Зузааны Бороо - ЭЗ-ийн ухааны доктор Ph D
15. Бямбаагийн Энхцэцэг - доктор Ph D
16. Зодовын Мягмар – Удирдахуйн ухааны доктор Ph D

Спортын алдартнууд :

1. Монломын Мижиддорж – Самбо бөхийн спортын мастер, МУ-ын начин
2. Жанжинхүүгийн Хулгана – Шатрын спортын мастер
3. Аюурзаны Оюунгэрэл - Шатрын спортын мастер
4. Аюурзаны Баатар – Хоккейн спортын мастер
5. Аюурзаны Болдбаатар - Хоккейн спортын мастер
6. Мидэрийн Энхболд – Шатрын дэд мастер
7. Батхүүгийн Пүрэвгончиг – Чөлөөт бөхийн спортын дэд мастер, Аймгийн начин
8. Шархүүгийн Бааст – Эмнэг сургалтын спортын мастер
9. Жамбалжавын Чулуунбаатар – Эмнэг сургалтын спортын мастер
10. Чанаравын Цулдган– Эмнэг сургалтын спортын мастер
11. Жамсрангийн Чулуунбат – Эмнэг сургалтын спортын мастер
12. Мандалын Батмөнх – Эмнэг сургалтын спортын мастер
13. Бямбын Басан – Эмнэг сургалтын спортын мастер
14. Раашийн Басанхүү – Эмнэг сургалтын спортын мастер
15. Сандагжавын Даваасамбуу – Эмнэг сургалтын спортын мастер
16. Рагчаагийн Халтар – Эмнэг сургалтын спортын мастер
17. Шагдарсүрэнгийн Цог – Эмнэг сургалтын спортын мастер
18. Чулууны Батсуурь – Эмнэг сургалтын спортын мастер
19. Раашийн Дамба – Эмнэг сургалтын спортын мастер
20. Дамбын Доржсүрэн – Эмнэг сургалтын спортын мастер
21. Аюурзаны Оюундэлгэр – спортын мастер
22. Уртнасангийн Анхбаяр – Сагсан бөмбөгийн спортын мастер
23. Зинагийн Чулуун – Уран гимнастикийн спортын мастер
24. Пүрвээгийн Бат-Очир – спортын мастер

Хүчний байгууллагаас төрөн гарсан алдартнууд :

1. Алтангэрэлийн Думбарай – Хошууч генерал
2. Баярын Равсал – хурандаа
3. Гойровын Чимэд – хурандаа

4. Гомбын Сандав – хурандаа
5. Жамбын ширэндэв – хурандаа
6. Хүрэлийн Гиваа – хурандаа
7. Тогоогийн Содномдорж – хурандаа
8. Түхэрийн Рэнцэн-Очир – хурандаа
9. Дэлэгжавын Санжаахүү – хурандаа
10. Балдангийн Ванган – хурандаа
11. Санжаахүүгийн Уранцэцэг – хурандаа
12. Сүхбаатарын Залуухүү – хурандаа
13. Чимэдийн Лутаа – Дэд хурандаа
14. Тулгын Торгууд – Дэд хурандаа
15. Гүрсэдийн Баасай – Дэд хурандаа
16. Батцэндийн Дашцэрэн – Дэд хурандаа
17. Пүрэвийн Зогсоосүрэн – Дэд хурандаа
18. Цоохүүгийн Доноров – Дэд хурандаа
19. Төмөрбаатарын Сундуйжав – Дэд хурандаа
20. Норовсамбуугийн Бямбажав – Дэд хурандаа
21. Довчингийн Даваа – Дэд хурандаа
22. Галдангийн Даваасамбуу – Дэд хурандаа

Хүн ам зүйТус сум нь 2012 оны эхний байдлаар 500 гаруй өрхийн 2000 гаруй хүн амтай. Үүнээс эрэгтэй- 917, эмэгтэй- 960 байна. 0-15 насны хүүхэд – 681, хөдөлмөрийн насны -1063, өндөр настан-133, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн – 86, бүтэн өнчин хүүхэд – 2, хагас өнчин хүүхэд – 38 байна. Нийт хүн амын 35 % нь дөрвөд, 53.3 % нь сартуул, 11.7 %-ийг халх, баяд болон бусад ястан эзэлж байна. Ажилгүйдлийн түвшин 1. 3 %-тай байгаа нь аймгийн түвшнээс 1.3 хувиар доогуур, улсын дунджаас 0.9 хувиар дээгүүр байна. Амьжиргааны түвшний судалгааг багуудаар гаргавал :

№	Баг	Нэн ядуу өрх		Ядуу өрх		Дундаж өрх		Чинээлэг өрх	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Айраг нуур	2	1.8	51	47.2	55	50.9	0	0
2	Хармагт	1	0.9	65	60.7	41	38.3	0	0
3	Хяргас нуур	4	4.2	67	69.7	25	26	0	0
4	Шар булаг	5	2.8	102	57.3	71	39.8	0	0
Сумын дүн		12	2.4	285	58.7	192	38.8	0	0

Сумын нийт өрхийн 60 % нь ядуу байгаа нь сүүлийн жилүүдэд байгалийн эрсдэл ган зудын давтамж ойртсон, тус суманд үйлдвэрлэл үйлчилгээ, ЖДҮ-лэлийн хөгжил эхлэлийн шатандаа байгаа, ажлын байр хангалтгүй байгаатай холбоотой юм.

Эдийн засгийн салбарын хөгжил**Сумын хөгжлийн зарим үзүүлэлтүүд****а. Ерөнхий мэдээлэл**

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Байршлын үзүүлэлтүүд		
Аймгийн төвөөс зай	км	176
Улсын нийслэлээс	км	1350
Хүн ам төвлөрсөн зах зээл	км	176
Хилийн гарц	км	500
Бүсийн төв	км	160
Нийт нутаг дэвсгэр	га	682.9 мянга
ХАА-н эдэлбэр газар	га	526.0 мянга
Бэлчээр	га	350.1 мянга
Тариалангийн талбай	га	1.5
Үүнээс: Тариалдаг талбай	га	1.3
Усны эдэлбэр газар	га	0
Тусгай хамгаалалттай газар	га	332.8 мянга
Зам, шугам сүлжээний газар	га	10
Далайн түвшинээс дээш хэдэн метр өндөр	м	1551
Байгалийн ямар бүсэд хамардаг		Говийн бүсэд
Жилийн дундаж температур	градус	0.2-0.4 ⁰ С
Зуны дулааны температур дунджаар	градус	20 ⁰ С
Өвлийн хүйтний температур дунджаар	градус	-22 ⁰ С
Жилийн дундаж хур тундас ОЖД	мм	33.1-87.4
Хуртай жилийн хур тундас тах	мм	60
Нөхөрлөл	тоо	3
Компани	тоо	11
Хоршоо	тоо	3
Улсын үйлдвэрийн газар	тоо	0
Төсөвт байгууллага	тоо	7
Төрийн бус байгууллага	тоо	5
Шашны байгууллага	тоо	1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	тоо	651

б. Хүн ам, зүй, нийгмийн хөгжлийн зарим үзүүлэлтүүд

	2007	2008	2009	2010	2011
Сумын нийт хүн ам	2042	1935	1934	1753	1677
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	1070	951	895	823	803
Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид	1050	929	876	806	791
Ажиллагчид, үйлдвэрлэлийн салбараар:					
Мал аж ахуй	899	788	734	653	622
Цахилгаан дулаан	1	2	2	2	2
Холбоо , тээвэр	13	11	11	12	13
Худалдаа үйлчилгээ	22	12	14	16	29
Төрийн байгууллага	28	28	27	32	32

Боловсрол	61	60	59	61	59
Эрүүл мэнд	20	22	23	23	23
Бусад	6	6	6	7	11
Хөдөлмөрийн насны хүн ам:	1196	1104	1217	1111	1058
Ажилгүйчүүдийн тоо	20	22	19	17	15
Үүнээс: эмэгтэй	9	12	10	9	8
Ажилгүйдлийн түвшин, %	1.6%	1.9%	1.5%	1.5%	1.4%
Сумын өрхийн тоо	536	528	531	499	489
Ядуу	136	134	151	148	285
Нэн ядуу	11	9	9	13	12
Малтай өрхийн тоо бүгд, үүнээс:	492	490	485	443	433
50 хүртэл малтай	87	83	94	115	105
51-100 малтай	79	85	86	126	83
101-200 малтай	171	175	169	180	148
201-500 малтай	140	130	124	17	87
501-ээс дээш малтай	15	17	12	5	10
Малчин өрхийн тоо	412	408	402	368	333
Малчдын тоо	402	787	799	730	685

в. Мал аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2007	2008	2009	2010	2011
Малын нийт тоо	85253	85804	78271	47731	62008
Тэмээ	4709	5053	5133	4170	4700
Адуу	4372	4251	3698	2413	2924
Үхэр	1205	1214	878	427	541
Хонь	23541	24922	23691	13453	15855
Ямаа	51426	50364	44871	27268	37988
Цэвэр. Эрлийз малын тоо	8000	9000	12000	10000	10000
Ямаа	8000	9000	12000	10000	10000
Малын хашааны тоо			197		
Бэлчээрийн усан хангамжийн хувь	85 %	87%	90 %	90%	93%
Тэжээл бэлтгэл, тн\тэжээл нэгжээр	90 тн	100 тн	108 тн	350 тн	450 тн
Үүнээс: Хадсан өвс	80 тн	90 тн	85 тн	250 тн	400 тн

г. Газар тариалангийн салбарын хөгжлийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2007	2008	2009	2010	2011
Тариалсан талбай, га	0	0	0	0.9 м ²	0.48 м ²
Төмс	0	0	0	0.2 м ²	0.18 м ²
Хүнсний ногоо	0	0	0	0.7 м ²	0.30 м ²
Хураасан ургац, тн	0	0	0	0.50 тн	0.45 тн
Төмс	0	0	0	0.35тн	0.15тн
Хүнсний ногоо	0	0	0	0.15тн	0.30тн

д. Орон нутгийн төсөв, сая төгрөг

Үзүүлэлтүүд	2007	2008	2009	2010	2011	2012
Орон нутгийн төсвийн орлого	12522,5	33560,1	7910,6	6160,2	11627,1	7772.9
Хүн амын орлогын албан татвар	4210,3	9683,7	3713,9	2297,2	4402,0	2700
Бууны албан татвар	28,0	28,0	28,0	36,0	52,0	50
Ойн гоожин	0	0	0	0	0	0
Газрын төлбөр	853,4	800,0	808,4	1073,8	1019,5	1222.9
Ус ашигласны төлбөр	10,0	10,0	50,0	70,0	150,0	200
Хүү торгууль	100,0	100,0	153,4	34,0	1005,1	1200

Бусад орлого	7320,8	22938,4	3156,9	2649,2	4998,5	2400
Орон нутгийн төсвийн зарлага		111850,8	112690,3	142052,8	175986,3	223054.9
Цалин		70216,4	73309,9	87597,6	115090,9	150558.2
НДШ, ЭМД		7127,6	8437,1	9429,6	12496,3	16561.4
Гэрэл цахилгаан		813,3	471,9	1402,2	637,5	655.4
Тээвэр шатахуун		8362,8	5290,4	7469,0	12200,4	13859.8
Шуудан холбоо		236,2	543,2	1143,1	1384,0	1578.2
Албан томилолт		822,9	2529,9	4459,4	5722,6	8616.3
Бусад зарлага		2421,6	22107,9	30551,9	28454,6	31225.6
Төсвийн санхүүжилт	Аймгаас	111495,6	102081,9	141564,8	172718,5	223054.9

Дээрхи тоон үзүүлэлтээс харахад 2007 оноос хойш 6 жилийн хугацаанд сумын төсвийн нийт зардал 2 дахин өссөн байна. Орон нутгийн төсвийн зарлагад орлого нь дунджаар 4-7 хувийг эзэлдэг. Орон нутгийн төсвийн орлого сүүлийн жилүүдэд буурч байгаа нь зарим татварыг аймгийн болон улсын төсөвт төвлөрүүлэх болсон, МАА-н татварыг чөлөөлсөн явдал нөлөөлж байна.

УВС АЙМГИЙН ЗАВХАН СУМЫН ЕРӨНХИЙ SWOT ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
- Аялал жуулчлал хөгжүүлэхэд боломжтой байгалийн үзэсгэлэнт газрууд, олон нуур голуудтай, говийн өвөрмөц байгалийн тогтоцтой, сувилал байгуулах боломжтой - МАА, түүн дотроо тэмээн сүргийг түлхүү өсгөх боломжтой - Ашигт малтмалын зохих нөөцтэй, унаган байдлаараа хадгалагдаж байгаа - Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон байнгын эрчим хүчний эх үүсвэртэй. - Төсөвт газрууд, сумын төвийн барилга байгууламжууд сүүлийн үед баригдсан, үйлчилгээний тав тухтай орчин бүрдсэн - Боловсон хүчний хангалт сайжирч байгаа - Нутгийн иргэдийн орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтанд оруулах, хөрөнгө оруулалт нэмэгдэх хандлагатай байна - ЖДҮ, бизнес эрхлэх, хөдөлмөр эрхлэх иргэдийн санал санаачлага идэвхжиж байна - Бэлчээрийн өвөрмөц ургамал нь онцлогтой	- Газар тариалан хөгжөөгүй - Хүн ам цөөн, шилжилт хөдөлгөөнтэй - Зах зээлээс алслагдмал, өртөг өндөр - Дэд бүтцийн салбар тэр дундаа зам, харилцаа холбооны хөгжил муу - Интернэт мэдээллийн сүлжээнд холбогдоогүй. - ЖДҮйлдвэр, үйлчилгээний хөгжил сул, эхлэлийн шатанд байгаа - Өөрийн орлогын эх үүсвэр бага, төсөв санхүүгийн эрх мэдэл хязгаарлагдмал - Ажилгүйдэл, ядуурал дорвитой буурахгүй, иргэдийн амжиргааны түвшин доогуур, амиа аргацаасан байдалтай - Иргэдийн ажиллах сонирхол дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс салаагүй - Бэлчээр нутаг хязгаарлагдмал - Аялал жуулчлал хөгжөөгүй - Гадаад болон бүс, сум хоорондын харилцаа, хамтын ажиллагаа муу - Сум, багийн ерөнхий төлөвлөгөөгүй
Боломж	Саад бэрхшээл
- Байгалийн үзэсгэлэн бүрдсэн газруудыг түшиглэн аялал жуулчлал, гадаад харилцаа хөгжих боломжтой. - Төвлөрөл саарч орон нутагт эрх мэдэл нэмэгдэж байгаа. - МАА-г хөгжүүлэх мэргэшсэн ажиллах хүч, материаллаг бааз бүрдсэн. - Хяргас нуур багийн нутгаар хатуу хучилттай зам баригдаж байгаа - Тооноос илүү чанарт анхаарсан эрчимжсэн МАА-г хөгжүүлэх сонирхол идэвхжиж байгаа	- Байгалийн эрсдэл, ган зудын давтамж ойртож байгаа нь ХАА-н салбарт сөргөөр нөлөөлж байна - Цөлжилт, элсний нүүдэл, байгаль экологийн доройтол нүүрэлж байгаа - МАА-н салбараас бусад эдийн засгийн салбарууд хөгжих нөхцөл бүрдээгүй. - Худалдан авах чадвар, борлуулах зах зээлийн багтаамж бага - Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, өртөг өндөр

Нутгийн удирдлагын зохион байгуулалт***Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал***

Монгол Улсын шинэ ардчилсан үндсэн хууль батлагдсанаар 1992 онд тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгуулагдаж тухайн нутаг дэвсгэрийнхээ ойрын болон хэтийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн бодлого чиглэлийг улс, аймгийн бодлого шийдвэр, орон нутгийн иргэдийн ашиг сонирхолтой уялдуулан тодорхойлж, шийдвэр гарган түүнийхээ хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн.

Тус сумын ИТХ нь төлөөллийн зарчмыг хангасан тухайн нутгийн иргэдийн өөрсдөө сонгож байгуулдаг Үндсэн хуулийн статустай Нутгийн Өөрөө Удирдах байгууллага юм.




Сумын ИТХ-ын эрхэм зорилго нь: Ардчиллыг бэхжүүлж, НӨУЁсыг төлөвшүүлэх, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэх, нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой, тэнцвэртэй, хөгжлийг хангах явдал юм.

Сумын ИТХ-ын удирдлагын талаарх мэдээлэл: 1992-1994 онд ИТХ-ын анхны орон тооны бус даргаар М.Галбадрах, 1994-1996 онд Ж.Зоригоо, 1996-2000 онд орон тооны даргаар М.Цолмон, 2000-2004 онд Б.Пүрэвгончиг, 2004-2008 онд М.Цолмон сонгогдон ажиллаж байсан.

2006 онд батлагдсан Монгол улсын ЗЗНДНТУ-ын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ өөрчлөлтөөр 2008 оны сумын ИТХ-ыг сонгох 5 дахь удаагийн сонгуулиар 21 төлөөлөгч сонгогдож энэ удаагийн Хурлын даргаар Ж.Мидэр сонгогдон ажиллаж байна. Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Г.Адъяа, М.Цолмон нар ажиллаж байсан бөгөөд 2004 оноос одоог хүртэл Ц.Лхагважав ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Хурал нь нутаг дэвсгэртээ хууль эрх зүйн хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоох, орон нутгийн хөгжлийн ирээдүйн төлөв, дэд бүтэц, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчноо хамгаалах, хүний нөөцийн талаар тодорхойлогч чиглүүлэгч байж, ядуурлыг бууруулах, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, иргэдийн нийгмийн асуудал зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд орон нутгийн нөөц боломж онцлогийг тусган бодлого боловсруулж хэрэгжүүлэгч байх зорилтыг өмнөө тавин ажиллаж байна.



Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
• Үндсэн хуулийн статустай • Ажиллах нөхцөл бүрдсэн өрөө танхимтай • Мэргэшсэн цомхон бүтэцтэй.	• Байгууллагын төсвийн хүрэлцээ муу • ИТХ-ын төлөөлөгчдийн мэдлэг чадвар харилцан адилгүй • ИТХ-ын төлөөлөгчдийг ажиллуулах эдийн засгийн хөшүүрэг байхгүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
• Орон нутгийн төсөв, татварын орлогыг зохицуулах • Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх • Байгалийн баялагаа ашиглан эдийн засгийн хөгжлийг тодорхойлох	• Орон нутгийн иргэдийн шилжилт хөдөлгөөн их, хүн амын сууршил муу • Байгууллагын төсвийн хүрэлцээ муу тул иргэдэд төдийлөн сайн хүрч ажиллаж чаддаггүй • Өөрийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан хуралдааны танхимгүй.

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
ИТХ-ын төлөөлөгчдийг чадвар, мэдлэг боловсролын дутмаг байдал	Сургалт мэдээллийг олон хэлбэрээр зохион байгуулах Туршлага судлах
Төлөөлөгчдийн нийгмийн асуудал, ажиллах нөхцөл боломж дутмаг	Санал боловсруулж хүргүүлэх замаар ИХТөлөөлөгч, ИНХ-ын ажиллах нөхцөл боломж урамшууллын механизмыг бий болгох
ИНХ-ын дарга нарын ажиллах нөхцөл боломж муу	Төсөл хөтөлбөрт хамрагдах, хандивлагч татах замаар ажиллах орон байр, техник хэрэгслээр хангах
Төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдал	Орон нутаг, улсын төсөв, төсөл хөтөлбөрүүдийг зөвзохистой зарцуулах, хэрэгжүүлэх

Сумын Засаг даргын Тамгын газар


1990-ээд оноос эхлэн ардчилал шинэчлэлийн он жилүүдэд төрийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл үндсээрээ өөрчлөгдөж нам төрийн ажлаас ангид байж, цэвэр төрийн ажлаа дагнан гүйцэтгэх чиг үүрэгтэй болж ирсэн түүхтэй. 1992 онд МУЗЗНДНТУТХууль батлагдан гарч энэ хуулиар Нутгийн Өөрөө Удирдах Ёсны Байгууллага болох ИТХ, Засаг дарга түүний тамгын газар гэсэн шинэ зохион байгуулалтанд шилжсэнээр сумын ИТХ, Захиргаа хоёр төрийн эрх барьдаг орон нутгийн нэгдмэл байгууллага болон хөгжсөн. Одоогийн байдлаар сумын ЗДТГ нь төрийн захиргааны ажилтан – 12, төрийн улс төрийн албан тушаалтан – 6, төрийн тусгай албаны ажилтан – 2, төрийн үйлчилгээний ажилтан – 8 гэсэн бүтэц орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

1992 оноос хойших сумын удирдлагууд :

№	Ажилласан жил	Засаг дарга	Орлогч дарга	Тамгын газрын дарга
1	1992-1996	П.Цэдэн-Иш	Ж.Мидэр	Ж.Самдан
2	1996- 2000	Г.Адьяа	М.Энхболд	Р.Даваа
3	2000-2004	М.Энхболд	Б.Дэмчиг	Ж.Дорждэрэм
4	2004-2008	С.Өлзийдэмбэрэл	Б.Дэмчиг	Т.Тамир
5	2008 оноос	Б.Пүрэвгончиг	С.Энхцацрал	Т.Тамир

Сумын ЗДТГ нь төрийн албаны шинэтгэлийг улам гүнзгийрүүлэн, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг

сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төрийн захиргааны үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна. Засаг даргын дэргэд түүнийг цаг үеэ олсон шуурхай шийдвэр гаргахад нь туслах, мэргэжлийн удирдлагаа тасралтгүй ханган ажиллах, зөвлөх үүрэг бүхий 9 хүний бүрэлдэхүүнтэй Засаг даргын зөвлөл ажилладаг.





Сумын ЗДТГазрын SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
• Эвсэг найрсаг хамт олон бүрдсэн. • Мэргэжлийн, мэргэшсэн боловсон хүчнээр хангагдсан • Ажиллах орчин нөхцөл, техник хэрэгслээр хангагдсан. • Төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажилладаг. • Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хамтын сан бүрдүүлж, зөв зүйтэй ашиглаж байна.	• Нутгийн захиргааны ордонгүй, байр ажлын өрөөний хүрэлцээ муу • Хөдөөгийн багууд сумын төвөөс алслагдмал, нуур голуудтай учир төрийн үйлчилгээ хүргэхэд зардал өндөр гардаг, хугацаа алдах тохиолдол гарч болзошгүй • Багийн төвүүдийн хөгжил сул • Халаалтын нэгдсэн системгүй, гар галалгаатай, өртөг өндөр • Интернэт мэдээллийн сүлжээнд холбогдоогүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
• Төрийн бодлого шийдвэр хөдөөд түлхүү чиглэгдэж байна • Ажилчид ажлын байран дээр мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх боломжтой.	• Төсөв санхүүгийн дутмаг байдал • Байгууллагын өөрийн орлого бүрдүүлэх боломж муу. • Төсөл хөтөлбөрт хамрагдах боломж хязгаарлагдмал. • Төрийн үйлчилгээ авах иргэд тархай бутархай, өртөг өндөр

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Нутгийн захиргааны ордон бариулах	Санал хүсэлтээ уламжилж улсын төсөвт суулгах
Ажилчдын нийгмийн асуудалд анхаарах, мэдлэг боловсрол доогуур	Сургалтын олон хэлбэрээр сургаж мэргэшүүлэх Туршлага судлуулах
Ажиллах нөхцөл боломж, ажлыг байрны тав тух хангалтгүй	Засвар хийх, байр өрөө нэмэгдүүлэх, багийн төвүүдийг ашиглалтанд оруулах зэргээр орчин бүрдүүлэх
Орчин үеийн техник хэрэгсэл дутмаг	Төсөл хөтөлбөрт хамрагдах, төсөв нэмэгдүүлэх, хандивлагч татах зэргээр санхүүгийн асуудлыг шийдвэрлэж техник хэрэгслээр хангах
Багийн төвүүдийн байнгын ажиллагаахангагдаагүй	Багийн төвүүдийг стандартын дагуу чанартай бариулах, Багийн Засаг дарга нар баг дээр ажиллах нөхцөл, техник хэрэгслээр хангах

“Айраг нуур” баг

Тус баг нь анх Бор үзүүр гэдэг газар гэр контортойгоор Чулуунбаатар, Жанжинхүү, Хороочуул, Цөөхөр, Өлзий-Очирынхны отог ах дүүсээс бүрэлдэж байгуулагдсан байна. Тус багийн нутагт Алаг адуу, Булган, Гэлэн, Тайж, Цөөхөр, Хороочууд овог ястнууд ихэвчлэн амьдардаг. 1958 онд нэгдэлжих хөдөлгөөнд ард иргэд хамрагдсанаас “Айраг нуур” буюу 1-р бригад, 1998 оноос 1-р баг гэж нэрлэгдсэн. Айраг нуур баг нь 2012 оны байдлаар 108 өрх, 355 хүн амтай. 19009 толгой мал тоологдсоноос : тэмээ – 1784, адуу – 937,

үхэр – 126, хонь – 4259, ямаа – 11903 тус тус байна.

Тус баг нь урд талаараа Завхан аймгийн Ургамал, зүүн талаараа Увс аймгийн Цагаан хайрхан сумуудтай хил залган оршдог.

Тус багаас 1949 онд МУ-ын 9-р УИХ-ын даргаар ажиллаж байсан Маажавын Булган, МАХН-ын 15-р их хурлын төлөөлөгч Хайнзангийн Норов, АИХ-ын депутат МУ-ын Хөдөлмөрийн баатар Г.Шагдарсүрэн, Ж.Энэбиш, Г.Бямбаа, Улсын аварга малчин Ц.Бүрнээ, Ж.Шархүү, Г.Бааст, Ш.Надмид, Б.Жамсран, Ш.Бааст, Г.Бямбаа, Ч.Цэвээн, МУ-ын шатрын спортын мастер Ж.Хулганаа, улсын залуу аварга, эмнэг сургалтын спортын мастер Ж.Чулуунбаатар, Аймгийн аварга малчин С.Өлзийтогтох, Ш.Цэрэн, Д.Бямба, Аймгийн аварга малчин Алтан ботгоны эзэн Д.Цэндхүү, Аймгийн сайн малчин Д.Дамдинсүрэн, Ц.Даваажав зэрэг ажил хөдөлмөрийн аваргууд, эрдэм номын эзэд болсон Г.Совд, Г.Галбадрах, О.Лхагва, П.Зузаан, О.Бат-Эрдэнэ, Ц.Дэмбэрэл, С.Дулмаа, Б.Бадарч нарын эрдэмтэн доктор, гавьяатууд төрөн гарсан нутаг юмаа.

“Хармагт” баг

Тус баг нь 1955 онд байгуулагдсан. Тус багийн нутагт алаг адуу, жанжинхүү, шар зэгс зэргийн овог ястнууд голлон амьдардаг.

Хармагт баг нь баруун талаараа Ховд аймгийн Дөргөн, баруун урд талаараа Завхан аймгийн Дөрвөлжин, Ургамал, хойд талаараа өөрийн аймгийн Өлгий сумтай тус тус хиллэдэг.

Тус баг нь 2012 онд 107 өрх, 349 хүн амтай. 15038 толгой мал тоолуулсанаас тэмээ – 1096, адуу – 742,

үхэр – 51, хонь – 3856, ямаа – 9293 тус тус тоологдсон байна.

Тус багаас улсын аварга малчин Х.Жадамбаа, МУГЖ Г.Жанчив, аймгийн сайн малчин Н.Буудайхүү, Г.Орсоо, аймгийн аварга энх сүрэгтэн Б.Банзрагч, аймгийн алдарт уяач Х.Балжин, Р.Халтар, Х.Цогтбаяр гэх мэтийн ажил үйлсээрээ тэргүүний олон сайчууд төрөн гарсан.



“Хяргас нуур” баг

Тусбаг нь 1955 онд байгуулагдсан. Гол төлөв Тугтан, Яргай, Булгадар, Таргад, Зуутраг, Шангас овог ястнууд амьдардаг. Ховд аймгийн Дөргөн, Увс аймгийн Өлгий, Наранбулаг, Хяргас, Малчин сумуудтай хиллэдэг.

Тус баг нь одоогийн байдлаар багийн Засаг дарга, ИНХ-ын дарга, багийн эмч, багийн сахиул гэсэн 4 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

2011 онд багийн төвийн конторын барилга шинээр баригдаж ашиглалтанд орсоноор иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай, нэг цэгээс хүргэх боломж бүрдээд байна. 2012онд 96 өрхийн 364хүн амтай, 15065 толгой мал толуулсанаас тэмээ – 1052, адуу – 609, үхэр – 90, хонь – 4797, ямаа – 8517 тус тус байна.



Тус багаас улсын аварга малчин Т.Бааяа, аймгийн хошой аварга малчин Ц.Жаргал, аймгийн аварга малчин Б.Мягмар, Гэл.Цэвээн, тэргүүний малчин залуу алтан медальт М.Баатар зэрэг олон хөдөлмөрийн сайчууд төрөн гарсан нутаг юм.

“Шар булаг” баг

Тус баг нь хуучин үйлдвэр бригадын суурин дээр 1959 онд байгуулагдсан. Баруун мухар, Завхан голоос хойших сумын төвийг хамарсан газар нутаг юм. Ихэвчлэн Тугтан, Шарга, Зуутраг, Булгадар, Шангас, Таргад, Яргай, Хошууд, Алаг адуу, Гэлэн, тайж, Шаргууд, Цөөхөр зэрэг ястнууд амьдардаг.

Тус баг нь 2012 оны байдлаар 178 өрх, 609 хүн амтай ба 12896 толгой мал тоолуулснаас тэмээ – 768, адуу – 636, үхэр – 274, хонь – 2943, ямаа – 8275 тус тус тоолуулсан байна. Тус багийн ихэнх өрхүүд нь сумын төвдөө төвлөрөн суурин суудаг, баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, байнгын цахилгааны эх үүсвэртэй, холбоо мэдээллийн байнгын харилцаатай, үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжсөн, төрийн болон хувийн



хэвшлийн байгууллагууд өнгө үзэмжээ сайжруулж, мод тарих зэргээр олон дэвшилттэй санаачлага өрнөж сумын хөгжлийн төв болон өргөжиж байна.

Багуудын SWOT шинжилгээ


<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
• МАА түүний дотор тэмээн сүргийн түлхүү өсгөх боломжтой • Багийн дарга, эмч унаатай болсон • Багийн төвүүд шинээр баригдаж байна	• Багийн иргэд хөдөлмөрөө хамтрах, хорших талаар ойлголт дутмаг • Иргэдийн боловсролын түвшин доогуур, аминч, бэлэнчлэх сэтгэлгээнээс салаагүй. • Багийн хөгжил сул. • Холбоо харилцааны сүлжээнд багийн бүх иргэд жилийн 4 улиралд хамрагдах боломж хязгаарлагдмал. • МАА-гаас өөр АА эрхлэх боломж хязгаарлагдмал
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
• Байгалийн үзэсгэлэнт газар, нуур голуудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх • Багийн төв шинээр баригдаж төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх боломж бүрдсэн. • Ингэний фермер, болон бусад ГТ, МАА-н чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжтой	• Сумын төвөөс алслагдмал, гол устай, төрийн үйлчилгээг хүргэхэд өртөг өндөр. • Байгалийн эрсдэл, ган зуд

Эдийн засаг, салбаруудын хөгжил

Мал аж ахуйн салбар: Мал сүрэг нь манай улсын соёлын өв уламжлалыг хадгалан авч яваа дэлхийн үнэт өв сан, тогтвортой хөгжлийн үндэс эдийн засгийн баталгаа, монголчуудын амьжиргааны гол эх үүсвэрийн нэг, нөхөн сэргээгддэг амьд био үйлдвэр тул МУ-ын үндсэн хуулинд “ Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна” гэж заасан байдаг.

МАА-г уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амын эрүүл аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах зорилго тавин ажиллаж байна.

Завхан сум МАА-н үйлдвэрлэл эрхэлдэг 4 багийн 333 малчин өрх, 669 малчинтай, үүнээс эмэгтэй малчин- 297 байна. Манай сум 62080 толгой малтай, үүнд тэмээ – 4700, адуу – 2924, үхэр – 541, хонь – 15855, ямаа – 37988 тус тус тоолуулсан байна. Сумын хэмжээнд сүргийн бүтцийн зохистой харьцаа алдагдаж, бод мал 14 хувийг эзэлж байхад ямаа 61 хувийг эзэлж байгаа юм. Цаашид ямааны тоо толгойг бууруулж, тэмээний аж ахуйг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх



бодлого баримталж, тэмээний тоо толгойг одоогийн байгаагаас 50 %-иар өсгөж 2021 онд тэмээн сүргийн тоог 7050 толгойд хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.

Бойжуулсан төлийн тоо \мян.тол. сүүлийн 5 жилээр\



Он	Бүгд дүн	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
2007	18744	629	512	287	6090	11226
2008	18720	732	571	271	7200	9946
2009	14220	639	268	185	6073	7055
2010	6259	500	184	67	2795	2713
2011	21930	676	604	143	5812	14695

Хээлтэгч малын тоо толгой 23450 болж нийт малын 38 хувийг эзэлж байна. Үүнд ингэ-1699, гүү-838, үнээ-272, эм хонь-6197, эм ямаа-14444 байна.

Сумын МЭҮТасгийн зорилго чиглэл нь тухайн нутаг дэвсгэрт ХАА-н салбарын чиглэлээр төр засгаас гарсан хууль, тогтоол, шийдвэр журам заавар, хөтөлбөр, стандартын хэрэгжилтэнд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах, зохицуулах, хянах чиг үүрэгтэй анхан шатны нэгж юм. МЭҮТ –нь 2010 оны 11-р сард 3 орон тоотойгоор байгуулагдсан.

Мал аж ахуйн салбарын SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
- Улсын МЭҮТасаг байгуулагдаж ажиллах нөхцөл, техник хэрэгсэл, унаа машинаар хангагдсан - Халдварт өвчний гаралт харьцангуй тайван - Тэмээн сүрэгт нэн тохиромжтой өвстэй, тэмээн дээр төвлөрөн эрчимжсэн МАА хөгжүүлэх боломжтой - Сумын нийт өрхийн 88-90 % нь МАА эрхэлдэг, арга туршлага сайтай - Мал хамгаалах сан болон өвс тэжээлийн агуулах байр, фондтой болсон	- Малчдын мэдлэг боловсрол тааруу - МАА-н мэргэжилтэн дутагдалтай. - МАА-н бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр хөгжөөгүй - Сүргийн бүтэц алдагдсан - Малын чанар муудаж, ашиг шим буурсан - Мал эрүүлжүүлэх ажилүйлчилгээ тааруу - Малын даатгалын тогтолцоо төлөвшөөгүй - Бэлчээрийн даац хэтэрсэн - Мал сүрэг байгалийн эрсдэлд өртөмхий
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
- Төрөөс малчид, МАА-н салбарыг дэмжсэн хууль эрх зүйн орчин бүрдсэн - ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулагдсан - Гадаадын орнууд монгол малын мах, сүүг экологийн цэвэр хүнс гэж сонирхож байна.	- Байгалийн гамшгийн давтамж ойртсон - Гоц халдварт өвчин гарсан тохиолдолд олон мал өвчлөх магадлалтай - Бэлчээрийн доройтол нэмэгдэх хандлагатай

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Иргэд төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн мэдлэг тааруу	Төрөөс малчдын талаар баримталж байгаа бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах, зөв ойлголт өгөх

МАА-н салбарыг эрүүлжүүлэх ажил хангалтгүй, материаллаг хангамж дутагдалтай	Мал эрүүлжүүлэх арга ажиллагааг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх Мал эмнэлэг ариун цэврийн чанарын лабораторитай болох
МАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ ханш тогтмол бус, бага байна.	МАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг биржээр дамжуулан нийлүүлэх Бүтээгдэхүүний урамшуулалд бүрэн хамрагдах
Байгалийн болзошгүй эрсдэлд төр, малчдын бэлтгэл хангалтгүй байна.	Сумын өвс тэжээлийн фондын хөрөнгийг арвижуулах, зөв зохистой ашиглах, байнгын нөөц бүрдүүлэх МАА-н менежментийг сайжруулах
Малын үүлдэр угсааг сайжруулах ажил хангалтгүй байгаагаас малын ашиг шим багасаж байна.	Хээлтүүлэгчийн тусгай суурьтай болох Шилмэл омгийн эцэг мал худалдан авч үүлдэр угсааг сайжруулах, өсгөн үржүүлэх Зохиомол хээлтүүлгийг нэвтрүүлэх Фермерийн аж ахуйг хөгжүүлэх
МАА-н мэргэжилтэн дутагдалтай \малын эмч, мал зүйч\	Үндэсний боловсон хүчинг гэрээгээр сургах Давтан сургах, хос мэргэжил эзэмшүүлэх.
Тэмээн сүргийн хамгаалалт муу	Тэмээний тоо толгойг нэмэгдүүлж, ноос, сүүг боловсруулах



Газар тариалангийн салбарТус сум нь МАА голлон эрхэлж, газар тариаланг туслах аж ахуйн чанартай хөгжүүлж ирсэн. Газар тариалан эрхлэх туршлагагүй, үржил шимт хөрс муутай өвөрмөц нутаг юм. Сүүлийн жилүүдэд газар тариалангийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, атрын 3 дугаар аянтай уялдаад иргэдийн дунд хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх, төмс хүнсний ногоо, малын тэжээл тариалах хандлага нэмэгдэж байна.

Газар тариалангийн салбарын SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
- Усалгаанд ашиглах усны нөөц хүрэлцээтэй - Иргэдийн ГТ-ийн аж ахуй эрхлэх сонирхол нэмэгдэж байгаа - Сумын иргэд орон нутгийн хүнсний ногоог хүнсэндээ хэрэглэх сонирхолтой - Газар тариаланд ашиглах газрын нөөцтэй	- Үржил шимт хөрс тааруу - Газар тариалан эрхэлж байсан туршлага, технологи байхгүй - Мэргэжилтэй боловсон хүчин дутмаг - Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө гараагүй, энэ чиглэлийг тусгаагүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
- Энэ чиглэл хөгжөөгүй учир өрсөлдөгч байхгүй - Завхан гол дагуу Чацаргана болон бусад төрлийн тариалан эрхлэх боломжтой. - Төрийн бодлого энэ чиглэлийг түлхүү дэмжиж байгаа	- Газар тариалангийн чиглэлийн техник хэрэгсэл дутагдалтай. - Энэ чиглэлийн төсөл хөтөлбөр хэрэгждэггүй. - Санхүүгийн боломж муу.

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Энэ чиглэл хөгжөөгүй, техник тоног төхөөрөмж байхгүй.	Төсөл хөтөлбөрт хамрагдах, лизингийн тоног төхөөрөмж нийлүүлэх зэргээр шийдвэрлэх Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх Нарийн ногоо даршлах арга технологи эзэмшүүлэх Чацаргана, жимсний мод тариалах
Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай.	Бизнес эрхлэгчдийг дэмжих сургалт зохион байгуулах Орон нутгийн бодлогоор мэргэжилтэн сургаж бэлтгэх.
Санхүүгийн боломж муу	Хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах, дэмжлэг үзүүлэх
Усны хомсдолтой	Ус дутагдалтай газар нутагт худаг уст цэг бариулах

Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжил:

Тус сумын худалдаа, бэлтгэлийн анги 1991 онд хувьчлагдсанаар хувийн хэвшлийн худалдаа үйлчилгээний салбарын хөгжил эхэлсэн. Эхэндээ жижиг түргэн үйлчилгээний цэгүүд байгуулагдан ажиллаж эхэлсэн бол одоо стандарт хангахуйц дэлгүүр болон хөгжиж байна. Тус суманд улсын бүртгэлтэй ААНБ – 13 байгаагийн 70 гаруй хувийг худалдаа, үйлчилгээний эрхтэй ААНБ эзэлж байна. Одоогийн байдлаар тус суманд дэлгүүр, мухлаг-11, хоолны газар, кафе-3, ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэг-1, талх, нарийн боовны цех-2, халуун ус, үсчин, компьютер, каноны үйлчилгээ тус бүр нэг нэг үйл ажиллагаа явуулж иргэд хөдөлмөрчдөд үйлчилж байна.

**Худалдаа, үйлчилгээний салбарын SWOT шинжилгээ:**

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
- Хүн амыг өдөр тутмын хэрэгцээт бараа бүтээгдэхүүнээр хангадаг - Дотооддоо мах бэлтгэж, иргэд, төсөвт газруудыг хангадаг - Худалдааны цэгийн тоо нэмэгдсэн	- Худалдаа үйлчилгээний стандартыг хангаж ажилладаггүй - Худалдааны цэг, салбаруудын тохижилт таруу - Зах зээлээс алслагдмал, өртөг өндөр - Барааны нэр төрөл цөөн, нөөц муу - Үйлчилгээний чанар хүртээмж, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх, харилцааны ёс зүйн асуудал хангалтгүй - Мэргэжлийн ажиллах хүч дутмаг - Үйлчилгээний газрууд орчин үеийн дэвшилтэт техник хэрэгслээр хангагдаагүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
- Банк санхүүгийн уян хатан бодлого хэрэгжих нөхцөл бүрдсэн. - Худалдаа үйлчилгээний байгууллагууд төрийн зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх эрх зүй бүрдсэн.	- Үнийн өсөлт - Хүн ам цөөн, худалдан авах чадвар муу - Санхүүгийн дутмаг байдал - Бизнесийг дэмжих ажиллагаа хангалтгүй

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Худалдаа, үйлчилгээний газрууд эрүүл ахуйн болон үйлчилгээний стандарт хангадаггүй	Төрийн хяналтыг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөх Сургалт сурталчилгаа зохион байгуулах
Үйлдвэрлэл үйлчилгээ явуулах орон байр хүрэлцээгүй	Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх стандартын байр барих Орон нутагт байгаа ашиглах боломжтой байр савыг засварлах, халаалтын асуудлыг шийдвэрлэж ашиглах
Банк санхүүгийн уян хатан бодлого байхгүй	Зээлийн хэмжээг өсгөх, хугацааг уртасгах Хүү бууруулах Хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах
Мэргэжилтэй боловсон хүчин дутмаг	ХХҮХэлтэс болон сургалтын төвүүдтэй хамтран сургалт зохион байгуулах

Жижиг, дунд үйлдвэрлэл:

Манай сумын хувьд МАА хөгжүүлэхээс гадна мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мод модон эдлэл, гурил гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл түлхүү хөгжих боломжтой юм. Тус суманд ЖДҮ-лэл эхлэлийн шатандаа байна. Иймд сумаас ЖДҮ-лэлийн цар хүрээг өргөтгөх, орон нутгийн эдийн засгийн боломж, түүхий эд, ажиллах хүчний нөөцөд тулгуурлан ирээдүйд үр ашгаа өгөх, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх, шинээр байгуулах замаар ЖДҮ-ийг хөгжүүлэх, орон нутгийн бренд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. ЖДҮ-лэлийн чиглэлээр гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн цех – 2, Модон эдлэлийн цех – 1, Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн фермер – 1, хатуу, зөөлөн оёдлын ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэг – 1, эсгийний үйлдвэр – 1 тус тус ажиллаж байна. Тэдний үйл ажиллагаанаас товч танилцуулья.



Талх, нарийн боов.Талх, нарийн боовны 2 цех үйл ажиллагаа явуулж, сумын иргэд болон гал тогоо бүхий газрууд, сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр зэрэгт гэрээгээр нийлүүлэн гурилан бүтээгдэхүүнээр ханган ажиллаж байна. Сумын ИТХ-аар тэргүүлэх чиглэлээ тодорхойлон сум хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон бусад төсөл хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээл олгох зэргээр дэмжлэг үзүүлж байна. Энэ чиглэлээр мод модон эдлэлийн үйлдвэрлэл, ингэний фермерийн аж ахуй, МАА-н гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх төв, эсгийний үйлдвэрлэл, хатуу, зөөлөн эдлэлийн ахуйн үйлчилгээний төв, тоосгоны үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр дэмжиж үйл ажиллагаа нь эхлээд байна.

Ахуйн үйлчилгээ :ТА-2 төслөөр зөөлөн оёдол, гутал, үсчний тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлсэн. Ингэснэрахуй үйлчилгээний төвлөрсөн цэг ажиллаж гэрийн



бүрээс, цаваг, оосор бүч, монгол дээл, төрөл бүрийн загварын хувцас, цагаан ултай гутал зэргийг дотооддоо үйлдвэрлэж иргэдэд үйлчилж байна. Мөн 2 үсчин байнгын ажлын байраар хангагдан ажиллаж байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн SWOT шинжилгээ:

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
- Газар нутаг, талбай сайтай - Байнгын цахилгааны эх үүсвэртэй - Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй - Үйлдвэрлэлийн зориулалтаар газар эзэмших бүрэн боломжтой - Байгалийн баялагийн зохих нөөцтэй - Эсгийний үйлдвэрийн бэлэн тоног төхөөрөмжтэй	- Санхүүгийн чадавхи сул - ЖДҮ-ийн туршлагагүй - Хэрэглэгчдийн тоо цөөн, зах зээл муу, борлуулалтын суваг үүсээгүй - Шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин дутмаг - Техник хэрэгсэл, тоног төхөөрөмж дутмаг - Зориулалтын байр дутагдалтай - ЖДҮ эрхлэх иргэдийн боломж тааруу, сэтгэлгээ дутуу, бэлэнчлэх сэтгэлгээнээс салаагүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
- Төрийн бодлогоор түлхүү дэмжигдэж байна - Хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломж бүрдсэн - Орон нутгийн түүхий эдийн зохихнөөцтэй - Байгалийн баялгийн нөөцтэй - Одоогоор өрсөлдөгч бага	- Хүн ам цөөн, худалдан авах чадвар муу - Зах зээлээс алслагдмал, өртөг өндөр - Хөрөнгө, санхүү хүрэлцээгүй - Банкны хүү өндөр, барьцаа хөрөнгө хүрэлцдэггүй, хугацаа богино

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
ЖДҮ-лэл явуулах зориулалтын байр хангалтгүй байна	Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх стандартын байр барих Орон нутагт байгаа ашиглах боломжтой байр савыг засварлах, халаалтын асуудлыг шийдвэрлэж ашиглах
Санхүү мөнгө дутагдалтай байна.	Зээлийн хэмжээг өсгөх, хугацааг уртасгах Хүү бууруулах Хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах
Шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин дутмаг	ХХҮХэлтэс болон сургалтын төвүүдтэй хамтран сургалт зохион байгуулах
Иргэдийн залхуу байдал, бэлэнчлэх сэтгэлгээ	Сургалт сурталчилгааг сайжруулах, дэмжих

Аялал жуулчлал:

Тус сум нь байгалийн үзэсгэлэнт газар, нуур голууд олонтой. Түүнийгээ түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой юм. 2007 оноос тус сумын уугуул Улаан баатар хот дахь нутгийн зөвлөлийн дарга С.Хийморьсан “Хэцүү хад” аялал жуулчлалын бааз байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Гадаад, дотоодын амрагчдад үйлчилж байна.



Аялал жуулчлалын SWOT шинжилгээ:

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
Байгалийн үзэсгэлэнт газар, нуур голуудтай	- Зам тээвэр, эрчим хүчинд холбогдоогүй - Аялал жуулчлал эрхлэх томоохон түнш байхгүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
- Байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх - Төрийн бодлого дэмжлэг нэмэгдэж байгаа	Санхүүгийн боломж муу

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Төсөв, санхүү хүрэлцээгүй	Хөнгөлөлттэй зээл тусламжинд хамрагдах Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг энэ салбарт дэмжих
Мэргэжилтэй боловсон хүчин дутмаг	Томоохон хандивлагч бизнес түнш олох, хамтран ажиллах

Сумын дэд бүтцийн салбарын хөгжил**Ерөнхий мэдээлэл:**

Эрчим хүчний хангамж: 2008 онд сум Баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Байнгын эрчим хүчний эх үүсвэртэй.

Холбоо, мэдээллийн сүлжээний хөгжил: Тус суманд холбооны салбар нь анх 1961 онд агаарын радио станцаар тусгай цагийн хувиараар аймгийн төвтэй өдөрт 2 удаа холбоо барьдаг, 1 ажилтантайгаар байгуулагдаж байжээ. 1971-1974 онд холбооны шугам байгуулагдаж, телефон харилцаатай болж 1987 онд Экран чен станц тавигдаж зөвлөлийн нэвтрүүлэг үзэж эхэлсэн бөгөөд тун удалгүй Монголын үндэсний телевизийн нэвтрүүлгийг үзэх боломж бүрдсэн байна. 1991 оноос Азиасит станцаар үндэсний нэвтрүүлэг шууд хүлээн авч үздэг болсон. 2001 оноос сумын холбооны салбарыг хөдөөгийн багуудтай холбоо барьдаг болгон өргөжүүлж, 2003 онд нарны зайг суурилуулснаар холбооны салбарын цахилгааны асуудал шийдвэрлэгдсэн. 2005 онд 32 номерын АТС тавигдаж айл өрх, албан байгууллагуудад телефон цэгээр үйлчилж эхэлсэн. 2008 онд сумын төв баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсноор холбоо мэдээллийн орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрсэн. Ингэснээр холбооны салбарын үйл ажиллагаа зогсож, үүрэн телефоны Юнител корпораци станцаа суурилуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Одоогоор 1000 шахам хэрэглэгчтэй, гэрээт борлуулагчаар 5 ААНБ хамтран ажиллаж байна. Аймгийн шуудан холбооны салбарт гэрээгээр 1 шуудангийн ажилтан ажиллаж иргэдэд хэвлэл мэдээлэл түгээж ажиллаж байна.



ШТС станц: Тус суманд анх 1972 онд Сандай нэгдлийн харьяа “Бензин колонк” байгуулагдаж байсан. 1990 онд энэхүү колонкын суурин дээр барилга баригдан НИК-ийн харьяа ШТС байгуулагдаж өнөөг хүртэл иргэдэд тасралтгүй үйлчилж байна. Мөн 2006 оноос

“Өнө булаг” шатахуун түгээх станц байгуулагдан үйл ажиллагаа явуулж иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.

Хэрэглээний болон үндны усны хангамж: Сумын төвийн ундны усны хэрэгцээнд улсын төсвийн хөрөнгөөр баригдсан гүн өрмийн худаг 3, Туркийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгээр баригдсан 1 худаг тус тус ажиллаж иргэдийн ундны усны хэрэгцээг хангаж байна. Мөн иргэд хувиараа гаргасан 10-аад гар худгаас хэрэглээний усаа хангаж байна.

Банк, санхүүгийн үйлчилгээ: Банк санхүүгийн салбарын хөгжил 1966 оноос эхлэлтэй юм. Анх 1966 онд “Банкны тооцооны касс” нэртэйгээр, эрхлэгчээр нь Д.Намбаа, Няраваар нь Доржнамжил гэсэн 2 ажилтантайгаар байгуулагджээ. 1969 онд Завхан суман дахь банкны тооцооны салбар болон өргөжсөн. 1991 оны 5-р сарын 18-нд банк өөрийн шинэ байртай болж, ХАА-н хоршоолол нэртэй, 6 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулах болсон. Эрхлэгчээр нь М.Ганхуяг, нягтлангаар нь С.Цэвэлмаа нар ажиллаж байв. 1995 оны 6 – р сараас ХАА-н банкны 86-р тооцооны төв болон бие даасан аж ахуйн нэгж болж өөрчлөгдсөнөөр мөнгөн хадгаламж, зээлийн үйлчилгээ өргөжин тэлж байгууллага, иргэдэд эрэлттэй тэргүүн зэргийн шинэ бүтээгдэхүүнээр үйлчилж эхэлсэн.



ХААН банкны Завхан тооцооны төв нь 2008 онд Онлайн сүлжээнд холбогдсоноор иргэдэд хурдан шуурхай, хүртээмжтэйгээр үйлчилгээ үзүүлж байна. Одоо банкны эрхлэгчээр С.Цэвэлмаа, эдийн засагчаар А.Түвшинжаргал, ахлах теллер Х.Цэцэгбал, теллер С.Амаржаргал нар ажиллаж байна.

Мөн 2011 оноос Хадгаламж банкны тооцооны салбар байгуулагдан ажиллаж байна. Ингэснээр иргэдэд банк санхүүгийн уян хатан бодлого хэрэгжих нөхцөл бүрдээд байна.

Бизнесийг дэмжих үйлчилгээ: Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих сургалтын төв болон банк бус санхүүгийн байгууллага одоогоор байгуулагдаагүй байна. Увс аймгийн ХХҮХэлтэс, Бизнес инкубатор төвүүдтэй хамтран бизнес эрхлэхийг хүсэгчдийг зуучлан арга зүйн сргалтанд хамруулах, сертификат олгох, ажил эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах зэргээр дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

Барилга, газар зохион байгуулалт: Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил бүр ИТХ-ын хуралдаанаар батлуулж мөрдөж ажилладаг. Сумын төвийг ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байгаа бөгөөд кадастрын зураглал хийгдсэн .

Зам, тээвэр: Суудлын авто машин 54, ачааны авто машин 26, мотоцикль 103 зэрэг тээврийн хэрэгслүүдтэй. Хот хооронд болон аймаг, орон нутаг хооронд 20 гаруй авто машин хүн, ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байна.

Дэд бүтцийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
Баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, эрчим хүчний байнгын эх үүсвэртэй.	- Газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөгүй, сумын төвийн тохижилт муу - Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудал

- Харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтэрч эхэлсэн. Юнител корпараци үйлчилгээ үзүүлдэг. - Банк санхүүгийн хоёр салбар үйл ажиллагаа явуулдаг. - Малчдын 90 хувь нь сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан. - Суурин өрхүүд ундны усны цэвэршүүлэх төхөөрөмжөөр хангагдсан.	- хангалтгүй - Зам харилцаа хөгжөөгүй, зах зээлээс алслагдмал - Шилэн кабельд холбогдоогүй - Сумын төвийн цахилгааны шугам сүлжээ муу, шугамын алдагдал ихтэй - Тээвэр шатахууны өртөг өндөр, ШТС-уудад орчин үеийн техник хэрэгсэл сууриллагдаагүй. - Тээврийн үйлчилгээний төвлөрсөн цэггүй, шуудангийн үйлчилгээ цаг алддаг - Орон нутгийн мэдээллийн хэрэгсэлгүй - Инженерийн нэгдсэн шугам сүлжээ байхгүй - Орон сууцжуулах нэгдсэн бодлогогүй
Боломж	Саад бэрхшээл
- Банк санхүүгийн хоёр салбар үйл ажиллагаа явуулж байгаа нь цаашид эдийн засгийн уян хатан бодлого хэрэгжих нөхцөл бүрдсэн. - Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн зам харилцаа, гүүр тавьж аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой. - Малчид сэргээгдэх эрчим хүч ашиглан орчин үеийн техник хэрэгсэл ашиглах боломж бүрдэж байна. - Малчдын үүрэн телефон ашиглалтын хүрээг өргөтгөх	- Эрчим хүч хэрэглэгчдийн амьжиргааны түвшин доогуур, өр үүсэх эрсдэлтэй. - Шуурга салхи, өвлийн хүйтнээс шалтгаалан гэрэл цахилгааны тасалдал их гардаг, өртөг өндөр - Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх санхүү төсөв хүрэлцээгүй. - Энэ салбарт янз бүрийн төсөл хөтөлбөр хэрэгждэггүй, хүртээмж муу. - Инженерийн байгууламжийн асуудал

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх санхүү төсөв хүрэлцээгүй	Төсөл хөтөлбөрт хамрагдах, санал боловсруулж холбогдох газарт уламжлах, төсөвт тусгах
Тээврийн үйлчилгээний төвлөрсөн цэггүй	Тээврийн үйлчилгээний нэгдсэн цэгтэй болох, байрыг засварлах
Газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө байхгүй	Газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажиллах
Энэ салбарт шаардлагатай боловсон хүчин дутмаг	Мэргэжлийн боловсон хүчнээр хангах, ажилчдыг давтан сургах
Эрчим хүчний өр, шугамын алдагдал	Санал боловсруулж хүргэх зэргээр улсын төсөвт суулгаж дотоод шугам сүлжээг бүрэн шинэчлэх Болзошгүй өрийн асуудлыг шийдвэрлэх нөөц хөрөнгөтэй болох
Инженерийн байгууламжийн асуудал	Төсөвт суулгаж шийдвэрлэх

Төр, нийгмийн үйлчилгээний салбарын хөгжлийн байдал

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ:

Тус сумын Цэцэрлэг анх 1962 онд Шар булаг багийн төвд багш, асрагч, тогооч гэсэн 3 ажилчинтай, 25 хүүхэдтэй нэгдлийн харьяа байгуулагдан нэдлээс санхүүжигдэж байжээ. Багш Цэвэлмаа, тогооч Өргөний Ням, асрагч Намин, Боожий, Түмэн нар ажиллаж байсан. Энэ үед 6 –н сартайгаас 7 нас хүртэлх хүүхдийг хамруулан сургаж байжээ.

1970 оноос 25 хүүхэдтэй улсын төсөвтэй боловсролын байгууллагад харьяалагдаж 3-7 настай хүүхдийг хамран сургаж эхэлсэн.1977 оноос 50-н хүүхэдтэй 7 орон тоотой ажиллах болсон. 1989 онд 75-н хүүхэдтэй, 12 хүний бүрэлдэхүүнтэй болж өргөжсөн.2002 оноос НҮБ-ын Хүүхдийн Сангаас “Бага насны хүүхдийн халамж хөгжил ” төсөл хэрэгжүүлсэнээр хөдөөгийн 3-н багт гэр цэцэрлэгүүд ажиллаж малчдын хүүхдийг СӨБ-д тогтмол бүрэн хамруулах нөхцөл бүрдсэн.

Одоо тус цэцэрлэг нь үндсэн 2 бүлэгт дунджаар 60 хүүхэд, хувилбарт сургалтанд дунджаар 55 хүүхэд хамрагдаж, 12 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Эрхлэгчээр Г. Отгонсүрэн, багш Х. Чимгээ, Т. Анхтуяа, туслах багш Г. Янжив, М.Цэрэнчимэд,Н.Цолмон, гэр цэцэрлэгийн багш Ч. Эрдэнэчимэг, З.Бадамрагчаа, М. Янжмаа, тогооч А. Дэлгэрцэцэг, Н.Бямбасүрэн, нярав М. Сэргэлэн, сан техникч Г. Тодбаяр, галч М.Амгалан, Ж. Баатар, Н. Доржбаяр нар ажиллаж байна.



2011 онд улсын төсвийн 375 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр баригдаж 2012 оны 7 сард ашиглалтанд орохоор ажиллаж байна. Ингэснээр сумын хүүхэд багачууд стандартын цэвэр, тав тухтай орчинд хүмүүжиж, боловсрол эзэмших нөхцөл бүрдээд байна.

Сургуулийн өмнөх боловсролын SWOT

Давуу тал	Сул тал
- Багш ажилчид ажиллах болон хүүхдүүдийн сурч, хөгжих боломж сайтай тохилог, дулаахан, цэвэрхэн орчинтой - Бүтээлч санаачлагатай, эвсэг хамт олон бүрдсэн. - Багш ажилчид харьцангуй тогтвор суурьшилтай ажилладаг. - Багш, ажилчид мэдлэг боловсролоо дээшлүүлэх эрмэлзэлтэй. - СӨБ-д хамрагдаагүй хүүхдийг сургуульд бэлтгэх талаар санаачлага гарган ажилладаг. - Мэргэжлийн удирдлагатай.	- Төсвийн хүрэлцээ муу - Сургалтын техник хэрэгсэл дутагдалтай. - Зориулалтын бус байртай. - Хэрэглэгчдийн хүсэж буй бүжиг, дуу, экологи, сэтгэхүй хөгжүүлэх чиглэлийн гүнзгийрүүлсэн сургалттай анги байхгүй - Бүлэг дүүргэлт нь нас насаараа байдаггүй холимог бүлэг ажилладаг - Мэргэжлийн багш дутагдалтай - Хүүхдийн дунд дугуйлан хичээллүүлдэг боловч үр дүнд хүрэхгүй байгаа. - Гэр цэцэрлэгийн үйл ажиллагаа харилцан адилгүй, тогтмолжоогүй.
Боломж	Саад бэрхшээл
- Туслах аж ахуйхөгжүүлэх - Олон улсын байгууллагаас төсөл бичиж хөрөнгө босгох - Сургууль, эцэг эхтэй хамран ажиллах, гадаад, дотоод харилцааг өргөжүүлэх	- Багш нар нэг газар хэт удаан ажилласнаас ажлын амжилт саарах хандлагатай - Алслагдмал багийн иргэд ойролцоосумдад хүүхдээ сургах тохиолдол гардаг учирхамран сургалт буурах магадлалтай

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай	Хөрвөх болон мэргэшүүлэх, давтан сургалтанд хамруулах зэргээр мэргэжлийн боловсон хүчнээр хангах Мэргэжлийн сургууль төгсөгчдөөс сонгон шалгаруулж авах
Цэцэрлэгийн шинэ байранд ороход бэлтгэл ажил хангах, техник хэрэгсэл, материаллаг эд зүйлсээ шинэчлэх	Төсөл хөтөлбөрт хандах замаар хатуу зөөлөн эдлэл, бусад эд зүйлсээ шинэчлэх Гал тогооны цахилгаан хэрэгсэл авах
Гадна талбайг хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулах	Мод тарих Төсөл хөтөлбөр, өөрийн нөөц боломжоор тоглоомын талбай байгуулах
Гэр цэцэрлэгүүдийн ажиллагааг эрчимжүүлэх	Үйл ажиллагааг нь цагт нь эхлүүлэх Багш нарыг мэргэшүүлэх

Суурь боловсролын үйлчилгээ:

Тус сумын сургууль нь 1940 онд байгуулагдсан. 1977-1978 оны хичээлийн жилд 8 жилийн дунд сургууль болон өргөжиж, 320 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн байр, 1987-1988 онд сургуулийн өргөтгөл, 1990-1991 онд дотуур байр, гал тогоо ашиглалтанд орж, 2005-2006 онд 9 жилийн дунд сургууль болон өргөжсөн.



2011-2012 оны хичээлийн жилд 313 сурагч, 16 багш, удирдах ажилтан 3, гүйцэтгэх ажилтан 19 ажиллаж, дотуур байранд 65 сурагч амьдарч байна.

Багш ажилчдыг боловсролын түвшингээр авч үзвэл магистр 2, дээд боловсролтой 19, дипломын 3, бүрэн дунд 4, бүрэн бус боловсролтой 10 хүн, нийт ажиллагсадын 76.4%-ийг эмэгтэй, 23.6%-ийг эрэгтэй багш ажилчид эзлэж байна.

Хамран сургалт 99.2%, мэргэжлийн багшийн хангалт 90%, нийт ангийн 7 буюу 63.7%-ийг гэрчилгээтэй кабинет, сурах бичгийн хангалт 85%, сурагчдын дүрэмт хувцас 94.5%-тай байна.

Тус сургуульд Японы засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөр, Дэлхийн банк, Хөдөөгийн боловсролыг дэмжих READ төсөл, Тогтвортой амьжиргаа төсөл, Хүүхдэд ээлтэй сургууль

төсөл,Хүүхэд хамгаалал,БСШУЯ-аас хэрэгжүүлж буй “Үр дүнд түргэн хүрэх санаачилга төсөл, Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3,Аймгийн ХЭДС зэрэг төсөл, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна.

Материаллаг бааз суурь сайн,хичээлийн байрны хүрэлцээ сайн,суралцах, ажиллах нөхцөл боломжийн, байнгын цахилгааны эх үүсвэрт холбогдсон,галтогооны цахилгаан хэрэгслээр бүрэн хангагдаж, багш хөгжлийн танхим,мэдээлэл зүйн иж бүрэн кабинеттай, нам даралтын халаалттай үйл ажиллагаагаа явуулдаг.

Манай сургуулийг төгсөгчдөөс Хөдөлмөрийн баатар Г.Шагдарсүрэн,Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн физик математикийн шинжлэх ухааны доктор, профессор О.Лхагва, Гавьяат жүжигчин Г.Жанчив,Монгол улсын төрийн соёрхолт,доктор О.Бат-Эрдэнэ, МУ-ын хүний гавьяат эмч Ш.Ган-Очир,Төмөр замын гавьяат ажилтан Г.Вандандагва, Улсын аварга тариаланч Т.Цэвэгмэд,физик –математикийн ухааны шинжлэх ухааны доктор,профессор П.Зузаан,доктор С.Мягмар,З.Мягмар,хошууч генарал А.Думбурай, шатрын олон улсын хэмжээний мастер Ж.Хулганаа, Хурандаа Т.Рэнцэн-Очир, МУ-ын аварга малчин Ч.Чулуун,Г.Бааст,Ш.Бааст,Б.Жамсран,Х.Жадамбаа, Ш.Надмид,Г.Бямбаа, Т.Бааяа,МУ-ын начин спортын мастер М.Мижиддорж,шатрын спортын мастер М.Энхболд, Аймгийн начин,спортын дэд мастер Б.Пүрэвгончиг,шинийг санаачлагч инженер Ч.Баяр, Ардын боловсролын тэргүүний ажилтан Г.Санж,Н.Дэмбэрэл,Ч.Дашням, С.Бухаа, Г.Цэнд,С.Сосорбурам,М.Төмөрбаатар, Ж.Мидэр,С.Өлзийдэмбэрэл,В.Түвдэндорж,Д.Зузаан,Ж.Зоригоо, Г.Янжмаа,Д.Аюуш,Д.Алтанхүү,С.Мягмаржав,Б.Маамуу,Ш.Алтанцэцэг, П.Цагаан, Б.Сувдаа,Ө.Чойжилжав,Т.Чимэдцэрэн, Ч.Банзрагч,А.Вандан,А.Зундуй, Д.Батмөнх,Р.Баалаахүү,З.Дашзэвэг,С.Дулмаа, Н.Дулмаа,Р.Дэжид,Т.Лхагваа,Р.Пүрэв,Ө.Ч СТА М.Балжинням,улсын залуу аварга малчин П.Маамуу,Ж.Эрдэнээ, тэргүүний малчин залуу алтан медальт П.Мягмар зэрэг бидний бахархал болсон олон алдар гавьяатнууд төрөн гаржээ.



Сумын сургуулийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд

Он	2007	2008	2009	2010	2011
Хамрагдсан хүүхэд	99.1%	99.1%	99.2%	99.3%	99.2%
Үүнээс малчдын	165	175	188	198	166
Шинээр элссэн хүүхэд	52	49	63	30	35
Сургууль завсардсан хүүхэд		1	4	3	
Сурлагын стандарт хангалт	58%, AB-15%	57%, AB-14%	54,3%, AB-16,7%	53,7%, AB-14,8%	63.7%, AB-14,8%
Дотуур байрны хүүхэд	65	75	68	81	70

Сумын хүн амын боловсролын байдал

Он		2010	2011	9-49 нас
Бичиг үсэг үл мэдэгч		80	73	
Бичиг үсгийн сургалтанд хамрагдсан хүний тоо		23	28	
Бичиг үсэгт тайлагдсан хүн		0	7	
Боловсролын түвшин	Дээд	70	83	16 наснаас дээш
	Тусгай мэргэжлийн дунд	49	52	
	Текник мэргэжлийн анхан шатны	56	64	
	Бүрэн дунд	102	115	
	Бүрэн бус дунд	438	444	
	Бага	303	242	
	Боловсролгүй	93	91	
Бүгд		1111	1091	

2011 онд сумын хөдөлмөрийн насны нийт хүн амын 18,2% нь дээд болон тусгай дунд, 51,4 % нь бүрэн болон бүрэн бус дунд , 30,4 % нь бага болон боловсролгүй иргэд байна.

Суурь боловсролын үйлчилгээний SWOT

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
- Хичээлийн болон дотуур байрны барилга хүрэлцээтэй, сайн - Багшлах боловсон хүчний хүрэлцээ сайн, ур чадвар сайн, өндөр - Материаллаг бааз, компьютер, техник хэрэгслийн хүрэлцээ хангамж сайн - Багш хөгжлийн танхим болон мэдээлэл зүйн кабинеттэй. - Цахилгааны эх үүсвэртэй - Нэг ээлжээр хичээллэдэг, нэг танхимд ноогдох суралцагчийн тоо цөөн учир сурагчдад үзүүлэх хүртээмж өндөр - Эвсэг хамт олонтой	- Аймаг, нийслэлээс алс оршдог. - Шилжилт ихтэй - Сурагчдын чөлөөт цаг өнгөрөөх, биеийн тамир, урлаг, соёлын техник хэрэгслүүд дутмаг - Сургуулийн нийт төсөв хүрэлцдэггүй - Одоо хэрэглэж байгаа нам даралтын зуух түлш их хэрэглэдэг - Боловсролын салбарын хэмжээнд сургалтын зардал хүрэлцээгүйгээс багш ажилчдыг чадваржуулах, дадлагажуулах сургалт хангалтгүй - Цэвэр бохир ус, халуун усны асуудал шийдвэрлэгддэггүй - Чийрэгжүүлэлтийн өрөө багаж, төхөөрөмж байхгүй - Интэрнэтэд холбогдоогүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
- Багш нарын мэргэжлийг ажлын байранд дээшлүүлэх боломж бүрдсэн - Сургууль эцэг эхийн холбоо сайн - Оюунлаг хүмүүс, төгсөгчдөөс дэмжлэг авах боломжтой	- Боловсролын шинэчлэлийн талаархи иргэдийн ойлголт харилцан адилгүй - Шилжилт хөдөлгөөний улмаас суралцагчдын тоо буурах хандлагатай - Үнэ ханшны өсөлтөөс төсвийн дутагдал нэмэгдэж байна

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Кабинетийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй, хангалтгүй	Хичээлийн кабинетүүдийг иж бүрнээр стандартын дагуу тохижуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
Алслагдсан байдал, боловсролын хүртээмж чанар хангалтгүйгээс шилжилт явагдаж суралцагчийн тоо буурах хандлагатай байна.	Боловсон хүчнийг мэргэшүүлэх, чадваржуулах, хариуцлагыг нэмэгдүүлэх Иргэдийн оролцоо, идэвхийг сайжруулж хамтын ажиллагааг нэмэгдүүлэх Үйлчилгээний автомашинтай байх

Дотуур байр, галтогооны тохижилт, засвар үйлчилгээ сайнгүй	Дотуур байр, галтогооны тохижилт, засварыг сайжруулах төсөл, хөтөлбөрт хамрагдах
Интернэтэд холбогдоогүй	Интернэтэд холбогдож мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх

Эрүүл мэндийн үйлчилгээ

Анх 1925 онд Гуугийн сайр хэмээх газар ил галтай гэрт эмнэлгийн суурь тавигдаж байжээ. Т.Гомбожав сумынхаа анхны ардын хоршооноос гэр, ширээ, сандал нэг нэгийг гаргуулан авч 1925 оны сүүлчээр нутгийнхаа Гуугийн сайр хэмээх газар гэр барьж эмнэлгийн эх суурь тулгын чулууг тавьж үйл ажиллагаагаа эхэлсэнээр сумын эмнэлгийн эх үүсвэр тавигдсан түүхтэй.

Гомбожав нь айлуудаар явж эмнэлгийн анхны тусламж үзүүлж, модон чагнуураар чагнан, үзэж оношилж, эмчилгээг хийдэг байжээ. 1939.05.01-нд сумын ард иргэдээс хөрөнгө цуглуулан хоёр гэр, 3 ор гудас, хөнжил цагаан хэрэглэлийг худалдан авч анхны эмнэлгийг нээсэн байна. Галчаар Сайманз, үйлчлэгчээр Памсүрэн, туслах ажилтнаар Цанжид нарыг ажиллуулжээ. Т.Гомбажавын ажил хөдөлмөрийг үнэлж БНМАУ-ын эрүүл мэндийг хамгаалах явдлын яамны 15 жилийн ойгоор 1931.10.15 ны өдрийн 184 тоот үүрд хадгалах сайшаалын үнэмлэхээр шагнан урамшуулсан байна.

Т.Гомбажав нь 1948 он хүртэл сумын эмнэлгийн анхны хүн эмнэлгийн эмчээр ажиллаж байгаад уг эмнэлгийн салбарыг одоогийн Завхан сумын төв Шарбулагт өргөтгөн байгуулахад сувилагчаар үлдэж эрхлэгчээр бага эмч Долгор ажилласан байна.

1951 онд 1800 төгрөгийн төсөвтэй, 5 ортой эмнэлгийн барилга баригджээ. 1964 онд их эмч Самдан ирж их эмчийн салбар байгуулагдан ажиллажээ.

Тус эмнэлэг нь төлөвлөгөөт үзүүлэлт болон сургалт сурталчилгааг амжилттай хэрэгжүүлсэнээр жирэмсний хяналт сайжирч, хүндрэл, эх хүүхдийн эндэгдэл буурч, сүүлийн жилүүдэд ажлаараа аймаг улсад тэргүүн байруудад орсон амжилттай ажиллаж байна.

2009 онд 2 давхар 8 ортой эмнэлэг шинээр баригдаж ашиглалтанд орсноор эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тав тухтай орчин бүрдсэн. Одоо тус эмнэлэг нь 24 ажилчинтай, их эмч -1, статистикч бага эмч -1, эх баригч -1, багийн эмч -3, сувилагч -5, НЭМА -1, эмийн санч -1, тогооч -1, жолооч -1, нярав -1, үйлчлэгч -1, угаагч -1, галч -4, БТАрга зүйч -1, ня-бо -1 зэрэг орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна. 2010 оны ажлаараа эрүүл мэндийн шилдэг байгууллага хамт олон болсон.



Эрүүл мэндийн салбарын SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
• Шинэ нөхцөлд ажиллаж болохуйц тогтолцоо бий болсон • Мэргэжлийн зарим боловсон хүчний нөөц чадавхи сайтай • Боловсон хүчний тогтвор сууршил сайжирч байгаа • Ажилтны техник хэрэгсэлтэй ажиллах чадавх мэдэгдэхүйц дээшилсэн • Үйл ажиллагааг хэрэгжүүлэгч боловсон хүчний чадавх сайн, өндөр хариуцлагатай ажиллах нөхцөл бүрэлдэж буй	• Ажлын байр, тоног төхөөрөмж техник хэрэгсэл дутагдалтай • Тогтвор сууршилтай ажиллах их эмчийн нөөцгүй • Эмнэлэгт нөхөн сэргээх эмчилгээний багаж тоног төхөөрөмж байхгүй • Ажилчдын ажлын ачаалал харилцан адилгүй, мэргэжлийн ажилчдын манлайлал сул • Ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж тогтолцоо сул • Халаалтын зардал өндөр
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
• Орон нутгийн дэмжлэг сайн • Хууль эрх зүйн нөхцөл бүрдсэн, мэдээлэл авах, өгөх систем сайжирсан, мэдээллийг ашиглан өргөн хэмжээний судалгаа тооцоо хийх • Боловсон хүчнийг шилж сонгох, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах • Төсөв хөрөнгийг үр дүнтэй ашиглах боломж бий	• Батлагдсан төсөв хүрэлцэхгүйгээс он дамжсан өр үүсэх • Ажлын байр өрөө тасалгаа хүрэлцээгүй, зарим мэргэжилтэнд таарсан стандартын өрөө байхгүй • Нарийн мэргэжлийн эмч ирдэггүй • Эргэлтийн эмийн сангийн байр муудсан тул цаашид ажиллах нөхцөл муу

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг	Рентген, физик эмчилгээ, зайн оношилгооны болон бусад тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах
Хүүхдийн мэргэшсэн эмч олдохгүй байгаа	Хүүхдийн болон нарийн мэргэжлийн эмч нартай болох бүх талын арга хэмжээ авах
Шинжилгээний нэр төрөл хэт цөөн	Оношилгоо, шинжилгээний лаборатортай болох
Эмийн сангийн смтандартын байргүй	Эмийн сангийн байрыг шинэчлэн стандартад нийцүүлэх
Иргэдийн эрүүл мэндийн боловсрол тааруу	Сургалт сурталчилгааг өргөтгөх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, чийрэгжүүлэлтийн олон талт арга хэмжээ авах

Соёл, урлагийн үйлчилгээ:

Соёлын байгууллага нь 1945 онд Улаан гэр нэртэй нэг орон тоотойгоор байгуулагдсан бөгөөд эрхлэгчээр Гончигзэвэг ажиллаж ард иргэдэд төр засгийн бодлого шийдвэр, орон нутгийн цаг үеийн ажил байдлыг ухуулан таниулж соёлын үйлчилгээ дуу хуур, кино, шии жүжиг концертыг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулдаг байжээ. Үүнд нутгийн авьяас билэгтэн Түхэр, Санж, Бондив, Магсаржав нарын хүмүүс ерөөл магтаал уртын дуу, ардын дуу дуулж морин хуур, хөгжим тоглодог байжээ. 1960 онд 150 хүний суудал бүхий Улаан булан баригдаж удирдлагаар



Д.Сеимлов Д.Михалов О.Жамсрандорж,Санжаажав,П.Баяртай нар удирдан ажиллажээ. Энэ хугацаанд Эшинхүү, Даваа, Буянжаргал, Тэсэгжав, Алтанхүү нарын 20-иод уран сайханчидтай ажиллаж байжээ.

1981 оноос мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж багшийн сургуулийн соёлын анги төгссөн. А.Бадам клубын эрхлэгчээр, номын санч Н.Үржинхүү, кино механикчаар Б.Бямбажав нар ажиллаж уран сайханчдын урын санг баяжуулж, 1988 онд Ардын театр байгуулан ажиллаж, 1990онд соёлын төв болон өргөжсөн байна. Захирлаар М.Пүрэвжав, хөгжмийн багшаар А.Бадам, бүжгийн багшаар Лхамжав нар ажиллах болсон.1998 оноос 2 орон тоонд шилжиж захирлаар Б.Бямбажав, хөгжмийн багшаар А.Бадам нар ажиллаж байв. 2001 оноос Соёлын төвийн эрхлэгчээр Х.Цэнджав томилогдон одоог хүртэл ажиллаж байна. 2005 онд 250 хүний суудал бүхий соёлын төв баригдаж ашиглалтанд орсон.Одоо 5 орон тоотой ажиллаж эрхлэгчээр-Х.Цэнджав, номын санчаар - Л.Цэвээнгэрэл, бүжгийн багшаар – Ц.Өлзийсүрэн, хөгжмийн багшаар–Ц.Ганхуяг, үйлчлэгчээр - Н.Гүнсэн, галчаар - Н.Мандшир, Г.Очирмаань тус тус ажиллаж байна.

Соёлын төв нь жилд нийт хүн амд соёл урлагийн 60 гаруй ажил үйлчилгээ, мөн түүх соёл, утга соёл, хурал цуглаан, тэмцээн уралдаан, өдөрлөг наадам зэрэг 100 гаруй ажил зохион байгуулж давхардсан тоогоор 8000 гаруй үзэгч хамруулан ажилладаг мэргэжлийн урлагийн байгууллага юм.

Соёлын үйлчилгээний SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
• Үйлчилгээний танхимын багтаамж сайн • Бүрэн хэмжээний концерт, жүжиг, найруулан тавьж байгаа • Үндэсний урлагийг сурталчлан зааж сургаж байгаа • Иргэдийн нийгэм ахуйн болон хувийн соёл дээшилсэн • Дуу хөгжмийн, бүжгийн дугуйлан хичээллүүлж байгаа • Уншигчид танхимаар үйлчлүүлэх,хичээллэх нөхцөл бүрдсэн • Компютер, техник хэрэгсэлийг ашиглан иргэдэд соёл урлагийн үйлчилгээг түргэн шуурхай өгөх сурталчлах нөхцөл бүрдсэн • Ажилчидын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх давтан сургаж байгаа	• Иргэд соёлоор үйлчлүүлэх идэвхтөлөвшөөгүй • Үйлчилгээ техник хэрэгсэл дутагдалтай • Хөгжмийн зэмсэг дутагдалтай • Явуулын үйлчилгээний унаа, санхүүгийн байдал хомс • Эртний үнэт эд зүйлсээ хадгалж өвлөн сурталчилах зан үйлээ өвлүүлэх ажиллагаа дутмаг • Нүүдэлчний соёл иргэншил орхигдож байгаа • Номын сангийн тохижилт, номын фонд бүрдүүлэлт тааруу • ОНСудлах кабинет байгуулан эд өлгийн зүйлээр баяжуулах санхүү дутмаг • Ажлын байр хүрэлцээгүй, нөхцөл тааруу • Мэргэжлийн боловсон хүчин дутмаг • Байрны халаалт шаардлага хангахгүй байгаа • Үйлчилгээний байр стандартын бус
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
• Төрөөс баримтлах соёлын бодлого ЗГ-ын тогтоол шийдвэр үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа • Шашин урлагийг хөгжүүлэх /дарь эхийн сүмтэй/	• Шилжилт хөдөлгөөн ихтэй хүн ам цөөн • Явуулын үйлчилгээ үзүүлэхэд багийн айл өрх алслагдсан байрлалтай • Төсөв санхүү дутагдалтай

Сумын цагдаагийн хэсэг

Тус сумын төрийн тусгай албанд хэсгийн төлөөлөгч Баттулга, Насанбат, Лхагва, А.Сүхтулга, Гансүх, Сэмжид, Хүрлээ, Б.Нямдаваа, цагдаа Ө.Лхамсүрэн, Ч.Даваа, Цогнэмэх нар ажиллаж байжээ.

2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цагдаагийн кабон баригдаж ашиглалтанд орсноор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа жигдэрч, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээд байна.

**Байгаль орчны салбарын хөгжил**

Сумын байгаль орчны хэсэг нь сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан, 11 гишүүнтэй. Үүнд: хэсгийн ахлагчаар Засаг даргын орлогч С.Энхцацрал, нарийн бичгийн дарга Ж.Самдан – БОХУБайцаагч, гишүүдэд Б.Батмөнх- Байгаль хамгаалалгч, Н.Уламбаяр – Цаг уурын өртөөний дарга, Л.Дорж – ТХГНБайцаагч, Б.Цэвээн – БЗДарга, З.Туяацэцэг- БГТХЖДҮХМэргэжилтэн, Ц.Оюун-Эрдэнэ- Газрын даамал, Н.Нандинцэцэг – Хими биологийн багш, Ч.Лхагвацэцэг- ТА-төслийн ажилтан, Д.Доржсүрэн – идэвхтэн байгаль хамгаалагч нар ажилладаг. Тус сум нь нийт-682.9 мянган га талбай бүхий газар нутагтай. Үүний 332.8 мянган га талбайг Улсын тусгай хамгаалалттай, “Хяргас нуурын байгалийн цогцолборт газар” эзэлдэг. Хяргас нуурын байгалийн цогцолборт газар нь Хяргас-Айраг нуур, Завхан, Хүнгүйн голуудын адаг, тэдгээрийн эргэн тойрны цөлөрхөг, ландшафт бүхий гандуу хуурай орчныг хамарсан өвөрмөц тогтоцтой нутаг юм. Энэхүү тусгай хамгаалалттай газар нутагт нэг байгаль хамгаалагч ажилладаг.

Тус сум нь Айраг, Хяргас нуур, Хэцүү хад, гурван нуурын сэлгээ, Цахир хошуу, Хайчийн агуй, Зогсоо хайрхан, Гилбэн уулын дарцагт оргил гэх мэтийн олон үзэсгэлэнт уул нурууд, Хос арал, элсэн манхнууд зэрэг аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх боломжтой өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд олон байна.

Сумын байгаль орчны хэсэг нь байгаль орчны тухай хууль тогтоомж үүний дотор Усны тухай хууль, ан агнуурын тухай хууль, газрын тухай хууль, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэнд анхаарлаа хандуулж ажилладаг. Тус суманд газрын хэвлийн ашигт малтмал ашиглах эрхтэй, үйл ажиллагаа явуулдаг ААНБ, иргэн байхгүй, хайгуулын лиценз эзэмшдэг хоёр ААН байдаг ч одоогоор үйл ажиллагаа явуулахгүй байна. Байгаль хамгаалах хоёр нөхөрлөл байгуулагдан ажиллаж байна. Тус суманд нийтдээ 13 инженерийн хийцтэй худаг, олон тооны гар худаг ашиглаж байна. Сумын төвийн ундны усны хэрэгцээг 4 гүн өрмийн худаг хангадаг. Одоогоор бохир зайлуулах



систем, бохир ус цэвэрлэх байгууламж байхгүй, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглаж, хаядаг байгууллага, ААН байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал хурдацтай явагдаж, ган зудын давтамж ойртож, байгалийн тэнцвэрт байдал алдагдаж байгаатай холбоотой тус суманд элсний нүүдэл ихсэж, цөлжилт хурдацтай явагдаж, гол нуурын усны түвшин багасч, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж байгаад дүгнэлт хийн цөлжилтийг сааруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Сумын Засаг даргын захирамжаар шаваг бутлаг ургамлыг сумын төвийн түлшний хэрэглээнд хэрэглэхийг хориглосон нь тодорхой үр дүнгээ өгч байна. Мөн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж өвөлжөө, хаваржааны отрын бүс нутгийг хамгаалах, хадлангийн хорио цээр тогтоох зэргээр бэлчээрийг нөхөн сэргээх, зүй зохистой, хуваарьтай ашиглах ажлыг зохион байгуулж байна. Бүх нийтээр мод тарих хөдөлгөөн өрнүүлж албан байгууллага, аж ахуй нэгж байгууллага, айл өрхүүд мод тарих ажлыг дэмжиж санаачлагатай ажиллаж байна. Цаашид төсөл хөтөлбөрүүдэд хамрагдахад онцгой анхаарч ажиллаж байна.

2008, 2009 онуудад Завхан гол ширгэж үгүй болсон, ган гачиг, байгаль цаг уурын таагүй нөхцөл бий болсон, загас жараахай ихээр үхсэн, хүмүүсийн сэтгэл зүйд таагүй орчин нөхцөл бүрдсэн үед УИХ, ЗГ, холбогдох дээд шатны байгууллагууд, гол мөрний хөдөлгөөн, хэвлэл мэдээлэл, радио телевизүүдийг орон нутагт газар дээр нь урин ажиллуулж, Телевизийн нэвтрүүлэг, хэвлэл мэдээллээр асуудал дэвшүүлэн тодорхой тэмцэл хийж хамтран ажилласны үр дүнд тайширын усан цахилгаан станцыг тавиулж Завхан гол ирснээр байгаль экологи сэргэж хэвийн нөхцөл бүрдсэн. Завхан голын сав газрын зөвлөлд хамрагдаж, 2011 оноос Засаг дарга зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

Айраг, Хяргас нуурын загасны нөөц тогтоолгох, байгаль экологийн байдалд үнэлгээ хийлгэхэд анхаарч ажиллаж байна. Нутгийн иргэдахуйн хэрэгцээндээ зохих хэмжээний загас ашиглаж байна. Загасны зуны нөөц тогтоосон.

Байгаль орчны SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
- Хулгайн ан агнуур болон хууль зөрчих байдал харьцангуй тайван. - Байгаль орчноо хамгаалах ажилд иргэд, ААНБ-ын идэвхи оролцоо дээшилсэн - Байгалийн баялаг, ашигт малтмалын зохих нөөцтэй, ашиглаж хөндөөгүй - Олон зүйлийн ховор ургамал элбэгтэй - Шаваг шарилж, бутлаг ургамлыг түлшинд хэрэглэхийг хориглосон	- Байгаль орчны хэсэг үйл ажиллагаа явуулах техник хэрэгсэл, орчин дутмаг - Байгаль орчны хуулийн хэрэгжилт, хяналт сул - Байгаль орчны чиглэлийн төсөл хөтөлбөрт хамрагдах боломж муу - Бэлчээр нутгийн хүрэлцээ муутай - Завхан гол дагуух мод төгөл устаж үгүй болсон - Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг - Сумын хогийн цэгийн хог хагдал ихэссэн
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
- Аялал жуулчлал хөгжүүлэх байгалийн үзэсгэлэнт газар, олон нуур голуудтай - Байгалийн баялаг, ашигт малтмалын нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулж зөв зохистой ашиглах боломж бий - Байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх иргэд, олон нийтийн ухамсар дээшилсэн, санал санаачилга нэмэгдэж байгаа	- Сүүлийн жилүүдэд элсний нүүдэл ихсэж, цөлжилт хурдацтай явагдаж байгаа - Байгалийн эрсдэл, ган зудын давтамж ойртож, байгалийн тэнцвэр алдагдаж эхэлсэн - Нуур, голуудын ус багасаж, гольдрол алдагдаж байна - Байгаль хамгаалах төсөв санхүүгийн боломж муу

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Элсний нүүдэл, цөлжилт	Мод тарих хөдөлгөөн өрнүүлэх
Байгаль хамгаалах төсөв санхүүгийн боломж муу	Байгаль хамгаалах төсөл хөтөлбөрт хамрагдах , төсөвт тодорхой хөрөнгө тусгах
Байгаль орчны хэсгийг техник, хэрэгслээр хангах	Төсөл хөтөлбөрт хамрагдах, хандивлагчдыг татах
Загасны нөөц тогтоолгох, ашиглах эрхзүйн орчин бүрдээгүй	Нөөц тогтоолгох Дээд шатны байгууллагуудад санал хүсэлт, асуудал тавьж байгалийн баялаг, загас ашиглах эрхзүйн орчин бүрдүүлэх

Цаг уурын өртөө нь 1964 онд Цаг уурын харуул нэртэйгээр анх цаг уурын байгууллага байгуулагдаж, харуулын ажиглагчаар М.Өнөр ажиллаж байжээ. Цаг уурын станц нь орон нутгийн цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, цаг агаарын аюултай үзэгдэл, элемент, ХАА-н цаг уур, бэлчээрийн ургамлын болон хөнөөлт хортон шавьж, мэрэгчдийн ажиглалт зэргийг хийж мэдээ мэдээллийг дотоодын болон олон улсын сүлжээнд оруулах үүргийг хүлээхийн зэрэгцээ цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг улирал, сар, 7 болон 5 хоногоор хүлээн авч орон нутгийн иргэд, байгууллага, малчдад түгээн ажиллаж байна. Мөн станцын хүрээнд ус судлалын харуул ажиллаж 1980-иад оны дундуур зоо цаг уур ажиллаж байв.

Тус станцын анхны даргаар С.Пүрэв ажилласан ба үүнээс хойш Ө.Гончиг, Батнасан, Б.Бямбаасүрэн, О.Баярхүү, Ш.Бямбаа, Р.Даваа, С.Гал, Л.Баянмөнх нар ажиллаж байсан бөгөөд 2001 оноос хойш Н.Уламбаяр ажиллаж байна. Одоо ажиглагчаар Ц.Сүнжидмаа, С.Норжинжав, С.Янжив, З.Амарсайхан нар ажиллаж байна. Тус байгууллага нь ажил үүргээ амжилттай гүйцэтгэж 1999, 2001 онуудад аймгийн системийн салбартаа тэргүүн байр эзэлж, 2006-2011 онд тогтмол эхний 5 байрт орж амжилт дүүрэн ажиллаж байна.



Сумын ахмадын хороо Анх 1995 онд ахмадын хороо байгуулагдаж, анхны даргаар нь ахмад багш П.Дашзэвэг томилогдон 1997 он хүртэл ажиллаж, 1998 оноос хойш Ж.Мидэр ажиллаж байна. 2012 оны байдлаар 133 ахмад байгаагаас эрэгтэй-47, эмэгтэй-86, 80-аас дээш настай-5, 70-аас дээш настай-41, хөгжлийн бэрхшээлтэй-13, ганцаараа амьдардаг-67, мал аж ахуй дээр ажилладаг-61 тус тус байна. Ахмадуудын дундаас хөдөлмөрийн баатар-1, улсын аварга малчин-9, аймаг, сумын аваргууд олноор төрөн гарсан байна. Манай байгууллага нь ахмадууддаа тусламж дэмжлэг хэрэгтэй болсон үед нь бага гэлгүй сэтгэл гарган туслаж, өнө мөнхөд тэтгэхэд биш өчүүхэн бага тус хүргэхээс эхлэх ёстой гэдэг зарчмыг үйл ажиллагааныхаа чиглэл болгон ажилладаг. Ахмад настны талаар төрөөс баримлах төрийн бодлогыг

хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хамт олон, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагын тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллж байна. Настан буурлууд маань үр хүүхэддээ өмөг түшигтэй, өргөө гэртээ аз жаргалтай байх болтугай.

Завхан сумын эдийн засгийн чадавхийн үнэлгээ

Сумын өнөөгийн удирдлага, зохион байгуулалт, хөгжлийн чадавхийг тодорхойлох зорилгоор 50 хүнийг санамсаргүйгээр сонгон чадавхийн үнэлгээ хийв.

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

д/д	Үүргүүд	Үнэлгээ					Сумын дундаж
		1	2	3	4	5	
1	Маркетинг	10	14	20	3	3	2,1
2	Хөрөнгө, оруулагчтай холбоо тогтоох	4	10	16	17	3	2,6
3	Орон нутгийн бизнес эрхлэгч нартай холбоотой байх	1	12	20	14	3	2,6
4	Стратеги төлөвлөлтийн үйл явцыг дэмжих	4	10	20	12	4	2,9
5	Урамшуулал бий болгох санхүүжилт олгох	8	10	23	5	4	2,7
6	Ажиллах хүчний хөгжил	5	10	24	8	3	3,7
7	Эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх хянах	6	10	24	7	3	2,4
8	ОНЭЗХ-н төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	5	15	22	4	4	2,3
9	Засаг дарга болон Иргэдийн хурлын зөвлөгөө мэдээллээр хангагдах түвшин	3	15	18	11	3	2,4
10	Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төв байгууллагатай харилцаа тогтоон ажиллах	8	15	20	4	3	2,2
11	Мэдээллийн сан байгуулах	7	20	16	6	1	2,1
12	Үйл ажиллагаагааг тайлагнах	4	10	17	14	5	2,6
13	Олон нийтийн харилцаа	5	10	20	11	4	2,5
Д Ү Н							2,5

Тайлбар:

- 1- Маш бага чадавхтай, эсвэл тухайн үүрэг огт биелэгддэггүй
- 2- Тухайн үүрэг маш бага түвшинд биелэгддэг
- 3- Энэ чиглэлд хүчин чармайлт гаргаж байгаа, гэхдээ цаашид улам сайжруулах шаардлагатай
- 4- Энэхүү үүрэгт хамаарах сумын чадавхи нь сайн
- 5- Сум нь энэхүү үүргийг маш сайн биелүүлдэг, өндөр хөгжсөн чадавхтай

Тус сумын өнөөгийн удирдлагад чадавхийн үнэлгээ хийхэд сум нь хөгжлийн стратеги төлөвлөлтийн үйл явцыг ач холбогдол өгч дэмжиж байгаа нь харагдаж байна. Мөн ажиллах хүчний хөгжил сайжирсан, урамшууллын болон санхүүгийн дэмжлэг нэмэгдсэн, хөрөнгө оруулагч болон орон нутгийн бизнес эрхлэгч нартай холбоо тогтоох, тэднийг дэмжих, олон нийтийн харилцаа сайжирсан гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Харин Засаг дарга болон Иргэдийн хурлын зөвлөгөө мэдээллээр хангагдах түвшин доогуур, мэдээ мэдээллийг хүргэх ажиллагаа хангалтгүй, орон нутгийн эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх, хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх ажиллагаа хангалтгүй байна гэсэн дүгнэлт гарч байна. Энэхүү үнэлгээний дүнд цаашид дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Сумын чадавхийн үнэлгээний голлох дүгнэлтүүд:

1. Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр төслүүдийг маш нарийн боловсруулж бэлтгэх
2. Бэлтгэсэн төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийг татах, холбоо тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх
3. Иргэдэд мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, шуурхай хүргэх арга технологи нэвтрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлж ажиллах
4. Иргэд олон нийтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Завхан сумын бизнесийн орчны судалгааны үр дүн ба дүгнэлтүүдийн тойм

Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад олон нийтийн оролцоог хангах, орон нутгийн үйлдвэрлэгчид, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн санал бодлыг тусгах, төр – бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй болон давуу тал юу байгааг тодорхойлоход энэхүү судалгааны ач холбогдол оршино.

Завхан сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд бизнес эрхлэгчид, малчдыг оролцуулан **50 хүнээс** бизнесийн орчны судалгааг авч дүн шинжилгээ хийв. Судалгаанд оролцогчдын **74% нь** хувиараа хөдөлмөр эрхлэгч, **22% нь** компани, **4 % нь**




хоршооны хэлбэрээр ажиллагсад байна. Эрхэлж буй бизнесийн төрөл хэлбэрээр нь харуулбал дараах байдалтай байна.

Судалгааны нэгтгэлээс харахад хугацааны хувьд бизнес эрхлэгчдийн **52.9 % буюу** тэн хагасаас илүү хувь нь **0-3 жил** ажиллаж байгаа шинэ бизнес эрхлэгчид, **15.6 % нь 3-10 жил**, **31.3 % нь 11-ээс дээш жил** үйл ажиллагаа явуулж байгаа дүнтэй

байна.

Бизнесийн орчин, ирээдүйн байдал

Бизнес эрхлэгчдийн **88 %** нь бизнесийн ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж, **19.6 хувь** нь хэмжээг нь нэмэгдүүлэх, **39.2 % нь** эрчимжүүлэх, **21.5 %** чанарыг сайжруулах, **49.0 %** нь зах зээлээ өргөтгөх хүсэлтэй байна. Бизнесийн өнөөгийн нөхцөл байдал хэр байгаа талаар харуулья.



Диаграммаас үзэхэд газар, эрчим хүч хүрэлцээтэй, зам, харилцаа холбоо, инженерийн байгууламж, түүхий эд материал, санхүүгийн эх үүсвэр, мэргэжилтэй ажиллах хүчин дутагдалтай, хүрэлцээгүй гэсэн байна. Иймд эдгээр асуудалд орон нутаг анхаарлаа хандуулж, дэмжлэг үзүүлэх, бодлого боловсруулж ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлт гарч байна. Харин бизнес эрхлэгчид борлуулалтаа яаж нэмэгдүүлэх бэ гэсэн асуултанд чанарыг сайжруулах-15%, захиалагчаа зөв олох-15%, нэр төрлийг олшруулах-13%, шинэ зах зээл эзэмших-13% гэсэн хариултууд голлосон байна. Үүнээс харахад бизнес эрхлэгчид борлуулалтаа цаашид нэмэгдүүлэх ихээхэн сонирхолтой байгаа нь харагдаж байна. Сав, баглаа боодлыг сайжруулах гэсэн хариултыг 5 хувь буюу хамгийн бага өгсөн нь тэд өөрсдөө савлалтын асуудалд оролцдоггүйтэй холбоотой байна.



Бизнесийн саад бэрхшээл

Судалгаанд оролцогчид бизнес эрхлэхэд хамгийн их саад болж буй хүчин зүйл нь мөнгө санхүүгийн дутмаг байдал, банкны өндөр хүү, төрийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамрагдах боломж муу, ажлын туршлага, мэргэжлийн ажиллах хүч дутмаг, шаардлагатай техник тоног төхөөрөмж, зориулалтын ажлын байр хүрэлцээгүй, МАА-н гаралтай бүтээгдэхүүний үнийн уналт, иргэдийн орлого багассан, бараа бүтээгдэхүүний үнэ ханшийн өсөлт гэж хариулжээ.



Тэгвэл бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх, мэдлэг мэдээллийг нь дээшлүүлэх зорилгоор хэрэгцээт сургалтыг нь тодорхойлоход чадавхи бэхжүүлэх, санхүү бүртгэл, менежмент,

чанар, технологи, компьютерийн сургалтанд хамрагдах сонирхол ихтэй байна.

Тухайн бизнесийн үйл ажиллагаанд нийгмийн үйлчилгээ хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад Эмнэлэг, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ, банк санхүүгийн үйлчилгээ, байгаль орчны хамгаалалт, байр орон сууцны хангамж их нөлөөтэй буюу 50 –иас дээш хувийн нөлөөтэй гэж хариулсан бол цагдаагийн хамгаалалт, ахуйн үйлчилгээ зэрэг нь дунд зэрэг нөлөөтэй гэж хариулжээ.


Сумын төр захиргааны үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл болох дүрэм журмын зохицуулалт, албан тушаалтны чирэгдэл, авилга, хууль бус ажиллагааны талаар доорхи байдлаар хариулсан байна.

Сумын удирдлага, албан тушаалтнуудтай хэрхэн харилцаа холбоотой ажиллаж байгааг тодруулахад ихэнх албан тушаалтнуудтай дунд зэрэг, сумын засаг дарга, татварын байцаагч, ХХАА-н түшмэлтэй сайн, ИТХ-ын дарга, цагдаагийн хэсэгтэй тааруу харилцаатай гэж хариулсан байна.

Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд сумын төр, захиргаанаас хэрэгжүүлбэл зохих гол арга хэмжээг тодруулахад :

1. Төрийн үйлчилгээг сайжруулах – 74.5%
2. Эдийн засгийн зохицуулалт – 64.7%
3. Хамтын ажиллагаа – 64.7%
4. Сургалт зөвлөгөө - 56.8%
5. Дэд бүтэц сайжруулах – 52.9%
6. Газар, ажлын байр – 50.9%
7. Бизнесийн мэдээлэл – 45.0%
8. Төр, захиргааны иурхай ажиллагаа – 41.1%
9. Байгаль хамгаалал – 39.2% гэж тус тус хариулсан байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн өсөлтийн талаархи үзэл бодлыг нь тодруулахад:



Үүнээс үзэхэд сүүлийн 5 жилд бизнесийн орчин сайжирсан гэж дүгнэж болохоор байна. Харин сумынхаа хөгжилд ямар хувь нэмэр оруулж чадах талаар дараах байдлаар санал бодлоо илэрхийлсэн байна.



Эндээс “Орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж чадах таны хувь нэмэр юу вэ?” гэсэн асуултанд хариулсан байдлаас дүгнэхэд бизнес эрхлэгчид цаашид үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөжүүлэх, ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байр гаргах, ажиллах хүчний чадавхийг сайжруулах, төрийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээг дэмжиж хамтран ажиллах замаар орон нутгийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулахад бэлэн байгаа нь харагдаж байна.



Мөн ажилгүйдэл ядуурлыг бууруулахад төр захиргааны зүгээс ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх байдлаар ажлын байр гаргах, төр бизнесийн хамтын ажиллагааг сайжруулах, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах, дэмжих, мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэхэд анхаарч мэдээлэл сургалтыг байнга зохион байгуулах, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, иргэдийн ухамсар, бэлэнчлэх сэтгэлгээг өөрчлөх тал дээр түлхүү анхаарч ажиллах шаардлагатай байгааг нотолсон байна.

Гурав. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**ЗАВХАН сумын хөгжлийн АЛСЫН ХАРАА**

ОЮУНЛАГ, ЭРҮҮЛ, БҮТЭЭЛЧ ИРГЭДТЭЙ, БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН БҮХИЙ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨНДӨР ЧАДАВХИТАЙ БИЕ ДААН ХӨГЖИХ НӨХЦӨЛ БҮРДСЭН БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ХӨГЖИНГҮЙ СУМ БАЙХ

Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл

Мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлж үр ашгийг дээшлүүлэх нь сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл байх болно.

Мөн орон нутгийн байгалийн болон бусад нөөцөд суурилсан аялал жуулчлалын үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Хөгжлийн тэргүүлэх чиглэлд баримтлах бодлого, үзэл баримтлал**Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд:**

- Сумын бэлчээрийн даац боломжид тохируулан уламжлалт болон эрчимжсэн хэлбэрээр зохистой хослуулан хөгжүүлэх
- Тус сумын онцлог болсон тэмээн сүргийг тогтвортой өсгөн ноос, сүүний ашиг шимийг нэмэгдүүлэн нутгийн бренди болгох
- Адуун сүргийг хурдны угшлаар сайжруулах
- Нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлж нутгийн сайжруулсан омог, хэвилийг бий болгох

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд:

- Баруун бүсийн аялал жуулчлалын хөгжлийн чиглэл, мастер төлөвлөгөөнд тулгуурлан түүний бүрэлдэхүүн хэсэг байхаар бодож зохион байгуулж явуулах
- Хяргас, Айраг нуур, Завхан голын ай савын байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалыг түшиглэсэн аялал жуулчлалыг нэгдмэл иж бүрэн цогцолбор хэлбэрээр үе шаттай хөгжүүлэх
- Сумын онцлогийг харуулсан ЭКО, угсаатны зүй, явган ба ердийн хөсгийн аялал, усан аялал, малчдын ахуйтай танилцуулах аялал зэрэг эвент бүтээгдэхүүнийг бий болгох замаар үйл ажиллагааг хэлбэрэлтгүй өргөтгөх
- Аялал жуулчлалыг дагасан төрөл бүрийн угтвар үйлчилгээг сайжруулах

Ашигт малтмалын салбарт:

- Байгалийн тогтоцын эмзэг байдалтай уялдуулан ашигт малтмал олборлолтыг хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулах
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтонд зохистой хязгаарлалт тогтоох
- Ашигт малтмалын үр ашиг өндөртэй 1-2 ордыг сумын хөгжилд үр ашигтай байдлаар эдийн засгийн эргэлтэнд оруулах
- Уул уурхайн үйлдвэрлэлд байгальд хал багатай дэвшилтэт технологийг ашиглуулах

- Байгалийн болон техникийн нөхөн сэргээлтийг тухай бүр нь хийлгээж, суманд актаар хүлээн авдаг журмыг заавал хэвшүүлэх

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд

- Орон нутгийн нөөцийг ашигласан, аль болох нэмүү өртөг шингээсэн байх
- Нутгийн бренди болох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг голчлох
- Тэмээний ашиг шимийг орон нутагтаа боловсруулан нутгийн брендийн түвшинд хүргэх
- Мах, сүү, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ зэрэг хүнсний голлох нэрийн бүтээгдэхүүнээр сум өөрийнхөө хэрэгцээг бүрэн хангах

Төлөвлөгөөний хамрах хугацаа, үе шатүүд

Завхан сумын хөгжлийн энэхүү төлөвлөгөө нь 2012-2021 оныг хамран хэрэгжих бөгөөд дараах үе шатуудтай байна. Үүнд:

1-р үе шат	2012-2015 он
2-р үе шат	2016-2018 он
3-р үе шат	2019-2021 он

Үе шат бүр нь дараах онцлогтой байна.

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ: Хөгжлийн төлөвлөгөөг сурталчлан таниулах, хөгжилд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, хөгжлийн суурь нөхцлийг хангах үе шат 2012-2015он

- Хөгжлийн төлөвлөгөөг сурталчлан таниулах, олны хүртээл болгох
- Тодорхой төслүүдийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгө босгох
- Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эрхзүйн болон мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтэрч, бүтээн байгуулалтын суурь орчин бүрдүүлэх

ХОЁРДУГААР ҮЕ ШАТ : Хөгжлийн төлөвлөгөөний эрчимтэй хөгжлийн үе шат 2016-2018 он

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, иргэдэд хурдан шуурхай, хүртээмжтэй, мэргэжлийн, ур чадварын, сэтгэл ханамжийн өндөр түвшинд үйлчлэх тав тухтай орчин бүрдүүлэх.
- Монгол мал хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, МАА-н тогтвортой өсөлтийг хангасан, бүтээгдэхүүний чанар, үнэлэмж сайжирсан, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих ажиллагаа
- Бизнес эрхлэх эрхзүйн болон санхүүгийн таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулах замаар бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх
- Байгалийн нөөцийн судалгаа, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулж, байгалийн баялагт түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийг дэмжих
- Орон нутгийн нөөц, онцлог давуу талд түшиглэсэн ЖДҮ-лэл, үйлчилгээг өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх
- Харилцан ашигтай гадаад, дотоод харилцааг хөгжүүлэх

ГУРАВДУГААР ҮЕ ШАТ : Нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хөгжлийн ололт амжилтыг бэхжүүлэх, хөгжүүлэх үе шат 2019-2021 он

- Алсын хараанд хүрэхэд тэмүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах
- Эдийн засгийн тогтвортой өсөлт бий болсон, санхүүгийн хувьд бие даах

- Үйлдвэрлэл үйлчилгээний ажиллагаа тогтмолжиж, үр ашиг дээшилсэн, гадаад дотоодод нийлүүлэх
- Сумын төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинд хүргэх

Төлөвлөгөөний хүрээний зорилго, зорилт, хөтөлбөр, төслүүд

Сумын хөгжлийн хэтийн түвшинг тодорхойлсон Алсын хараанд хүрэхийн тулд дор дурдсан зорилго, зорилтыг хангах, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

ЗАВХАН сумын хөгжлийн зорилго, зорилтын нэгдсэн матриц

ЗОРИЛГО		ЗОРИЛТ	
1.	Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж сумын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх	1.1.	Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг зохистой хослуулан хөгжүүлж үр ашгийг дээшлүүлэх
		1.2.	Орон нутгийн нөөцөд суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 5 дахин нэмэгдүүлэх
		1.3.	Эрэлт хэрэгцээнд нийцсэн худалдаа, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх
2.	Иргэд, аж ахуйн нэгж бүр үр ашигтай бизнес эрхлэх тэгш, шудрага, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх	2.1.	Хатуу дэд бүтцийн орон нутгийн бүтэц, сүлжээг хөгжүүлэх
		2.2.	Бизнесийн эрх зүйн орчинг сайжруулж, бүх талын түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх
3.	Эрүүл, оюунлаг, бүтээлч сэтгэлгээтэй, өв соёлоо дээдэлсэн иргэнийг төлөвшүүлэх	3.1.	Суурь боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлж, сургалтын чанарыг 75 хувьд хүргэж, мэдлэг чадвартай иргэнийг төлөвшүүлэх
		3.2.	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдийг цогц байдлаар хөгжүүлэх
		3.3.	Үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх
		3.4.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн өвчлөлийг 2 дахин бууруулах
		3.5.	Төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, ил тод, оновчтой хэлбэрээр хүргэх
4.	Байгаль, орчныг хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах	4.1.	Байгаль хамгаалах тогтолцоог сайжруулж үр нөлөөг дээшлүүлэх
		4.2.	Байгаль орчны техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах

Зорилго, зорилтуудыг хангах хүрээнд хамрах хөтөлбөр, төслүүд**Зорилго-1. Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж сумын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх хүрээний хөтөлбөр, төслүүд**

Хөтөлбөр	Төслийн хувийн дугаар, нэр
Зорилт 1.1. Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг зохистой хослуулан хөгжүүлж үр ашгийг дээшлүүлэх	
Хөтөлбөр 1.1.1. Малын үржлийн ажлын үр дүнг дээшлүүлж, үүлдэр угсааг сайжруулах	1.1.1.1. Шилмэл омгийн буур, ингийг бусад аймаг, сумаас худалдан авч сүргийн сайжруулагчаар ашиглах
	1.1.1.2. Адууны угшлийг сайжруулж, хурдан удмын адуутай болох
	1.1.1.3. Хуц, ухнын тусгай сууриуд бий болгох
	1.1.1.4. Бод малын зохиомол хээлтүүлгийн цэг байгуулан ажиллуулах
	1.1.1.5. Хээлтүүлэгчийн өвөлжөөний хашаа барих
	1.1.1.6. Цөм сүрэг бүрдүүлж, үржлийн мал бойжуулах, худалдах
Хөтөлбөр 1.1.2. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах	1.1.2.1. Баг бүрт малын үзлэгийн хашаа барих
	1.1.2.2. Баг бүрт малын угаалга, ариутгалын суурин цэг байгуулах
	1.1.2.3. Мал эмнэлэг, ариун цэврийн чанарын лабораторитой болох
Хөтөлбөр 1.1.3. Мал аж ахуйн шинэлэг хэлбэрийг нэвтэрүүлэх	1.1.3.1. Ингэ, үнээ болон ямааны загвар фермер байгуулах
	1.1.3.2. Тахиа, гахайны аж ахуйг хөгжүүлэх
Хөтөлбөр 1.1.4. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	1.1.4.1. Бэлчээрийн ургамал, газрын хөрс, усны биогеохимийн шинжилгээ хийлгэх
	1.1.4.2. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх
	1.1.4.3. Усалгаатай талбайд жимс, жимсгэнэ тариалах
	1.1.4.4. Завхан голын дагуу усалгаатай талбайд царгас, согоовор, ерхөг зэрэг малын тэжээлийн ургамал тариалах
Зорилт 1.2. Орон нутгийн нөөцөд суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 5 дахин нэмэгдүүлэх	
Хөтөлбөр 1.2.1. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	1.2.1.1. Малын тэжээлийн жижиг үйлдвэртэй болох
	1.2.1.2. Ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулах
	1.2.1.3. Тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах
	1.2.1.4. Эсгийний үйлдвэр ажиллуулах
	1.2.1.5. Мал нядлах, мах хадгалах, боловсруулах цэгтэй болох
	1.2.1.6. Ноос, түүхий эд бэлтгэл, анхан шатны тордолтын цэгтэй болж, үйл ажиллагааг тогтворжуулах
Хөтөлбөр 1.2.2. Орон нутгийн байгалийн нөөцийг ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх	1.2.2.1. Загасны үйлдвэр байгуулах
	1.2.2.2. Тоосго, блокны үйлдвэр байгуулах
	1.2.2.3. Сангийн далай ордыг түшиглэн давсны жижиг үйлдвэр байгуулах

	1.2.2.4. Шар толгой, Улаандэлийн газрын ховор элементийн ордыг орон нутагт үр ашигтай нөхцөлөөр ашиглах
	1.2.2.5. Барилгын өнгөлгөөний чулууны нөөцийг тогтоолгож үйлдвэрлэлийн зориулалтаар орон нутгийн түвшинд хязгаарлагдмал хүрээнд ашиглах
Хөтөлбөр 1.2.3. Аялал жуулчлалын салбарыг бие даан хөгжүүлэх	1.2.3.1. Айраг, Хяргас нуурын хоолойд аялал жуулчлалын цогцолбор байгуулах
	1.2.3.2. Таваг чулуунд аялал жуулчлалын бааз байгуулах
	1.2.3.3. Цахир хошуунд аялал жуулчлалын бааз байгуулах
	1.2.3.4. Хос аралд аялал жуулчлалын бааз байгуулах
	1.2.3.5. Завхан сумын эко аяллын маршрут үүсгэн зуучлалын нэгж байгуулах
Зорилт 1.3. Эрэлт хэрэгцээнд нийцсэн худалдаа, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх	
Хөтөлбөр 1.3.1. Худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний хүрээг өргөтгөн хөгжүүлэх	1.3.1.1. Хүнсний бөөний худалдааны төвтэй болох
	1.3.1.2. Сумын төвд 100-150 суудалтай зоогийн газартай болох
	1.3.1.3.Талх, нарийн боовны үйлдвэрлэлийг өргөжүүлэх
	1.3.1.4. Сумын төвд бараа, бүтээгдэхүүний нэгдсэн зах байгуулах
Хөтөлбөр 1.3.2. Ахуйн үйлчилгээг хөгжүүлж, нэр төрлийг нь нэмэгдүүлэх	1.3.2.1.Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний газрыг бий болгох
	1.3.2.2. Ахуйн үйлчилгээний нэр төрлийг үе шаттай нэмэгдүүлэн хөгжүүлэх
	1.3.2.3. Сумын төвд 30 ортой зочид буудал барих
	1.3.2.4. Халуун ус, саун, массажны үйлчилгээг өргөжүүлэх

Зорилго-2. Иргэд, аж ахуйн нэгж бүр үр ашигтай бизнес эрхлэх тэгш, шудрага, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх хүрээний хөтөлбөр, төслүүд

Хөтөлбөр	Төслийн хувийн дугаар, нэр
Зорилт 2.1. Хатуу дэд бүтцийн орон нутгийн бүтэц, сүлжээг хөгжүүлэх	
Хөтөлбөр 2.1.1. Сумын холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх	2.1.1.1. Сумын төвийг шилэн кабелийн сүлжээнд холбох
	2.1.1.2. Орон нутгийн мэдээллийн студитэй болох
	2.1.1.3. Богино долгионы радио станц нээн ажиллуулах
	2.1.1.4. Интернэт кафе ажиллуулах
Хөтөлбөр 2.1.2. Цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх	2.1.2.1 Сумын төвийн цахилгаан түгээх 04-ын шугамыг бүрэн шинэчилж, стандартад нийцүүлэх
	2.1.2.2. Сумын төвөөс Хяргас-Айраг нуурын хоолой, Хэцүү хад чиглэлд 40 км-т 10 квт-ын ЦДАШ байгуулах
Хөтөлбөр 2.1.3. Зам, тээврийн үйлчилгээг сайжруулах	2.1.3.1. Шар булаг-Наранбулаг чиглэлийн хатуу хучилттай зам байгуулах
	2.1.3.2. Сумын төвийг хатуу хучилттай замтай болгох
	2.1.3.3. Нуурын хоолойд тээврийн хэрэгслийн гарц байгуулах
	2.1.3.4. Нийтийн тээврийн үйлчилгээний нэгдсэн цэгтэй болох

	2.1.3.5. Шингэн хог, хаягдал зайлуулах зориулалтын тээврийн хэрэгслийн үйлчилгээг нэвтрүүлэх
Хөтөлбөр 2.1.4. Сумын төвийн хот байгуулалтыг нэмэгдүүлэх	2.1.4.1. Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээг байгуулах
	2.1.4.2. Иргэдийг орон сууцжуулах
	2.1.4.3. Сумын төвд спортын нэгдсэн цогцолбор байгуулах
	2.1.4.4. Сумын төвийн гудамж, талбайг гэрэлтүүлэгжүүлэх, тэмдэгжүүлэх, ёслолын хаалга барих
	2.1.4.5. Сумын бэлэг тэмдэг, хүндэтгэлийн самбар босгох
Зорилт 2.2. Бизнесийн эрх зүйн орчинг сайжруулж, бүх талын түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх	
Хөтөлбөр 2.2.1. Бизнесийн хөгжлийн эрх зүйн орчинг сайжруулах	2.2.1.1. Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх
	2.2.1.2. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх
	2.2.1.3. Бизнесийн эрх зүйн орчинг сайжруулан төр, иргэний нийгэм, бизнесийн түншлэлийн хамтын гэрээтэй ажиллах
	2.2.1.4. ОХУ-ын Тува болон бусад улсын зарим субьекттай түншийн харилцаа тогтоон хамтарч ажиллах
	2.2.1.5. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг сумаас экспортлох боломж, нөхцөлийг хангах
Хөтөлбөр 2.2.2. Бизнесийг дэмжих, хамгаалах үйлчилгээг төгөлдөржүүлэх	2.2.2.1. Жижиг үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний нэгдсэн парк-төв байгуулах
	2.2.2.2. Бизнесийн сургалт, зөвөлгөө, зуучлалын нэгж байгуулах
	2.2.2.3. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог дэмжин нэмэгдүүлэх
	2.2.2.4. Цагдаагийн хэсгийг унаажуулах

Зорилго-3. Эрүүл, оюунлаг, бүтээлч сэтгэлгээтэй, өв соёлоо дээдэлсэн иргэнийг төлөвшүүлэххүрээний хөтөлбөр, төслүүд

Хөтөлбөр	Төслийн хувийн дугаар, нэр
Зорилт 3.1. Суурь боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлж, сургалтын чанарыг 75 хувьд хүргэж, мэдлэг чадвартай иргэнийг төлөвшүүлэх	
Хөтөлбөр 3.1.1. Багш, ажилчид, зарим суралцагчдад зориулсан таатай нөхцөлийг бүрдүүлэх	3.1.1.1. Багш, ажилчдын чийрэгжүүлэлтийн танхимтай болох
	3.1.1.2. Хүүхэд хөгжлийн танхим байгуулан ажиллуулах
	3.1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан тусгай танхимтай болох
	3.1.1.4. Хүүхдийн соёл, амралтын зуслан байгуулах
	3.1.1.5. Үйлчилгээний авто машинтай болох
Хөтөлбөр 3.1.2. Сургуулийн сургалтын орчин, материаллаг баазыг нэмэгдүүлэх	3.1.2.1. Сургалтын кабинетүүдийн тохижилтыг сайжруулж, бүх хичээлийг кабинетаар явуулах
	3.1.2.2. Анги бүрийг компьютер, LCD проектортой болгох
	3.1.2.3. Компьютерийн танхимийг ширээ сандлаар хангаж, тохижуулах
	3.1.2.4. Биеийн тамир, хөдөлмөрийн болон дуу хөгжмийн кабинетуудыг тохижуулах
	3.1.2.5. Алдрын танхим байгуулан тохижуулах
	3.1.2.6. Сургуулийн орчныг ногоон бүс болгон тохижуулах
	3.1.2.7. Сургуулийн хичээлийн байранд их засвар хийж тохижуулах

	3.1.2.8. Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах
	3.1.2.9. Гал тогооны байр шинээр барих
	3.1.2.10. Сургуулийн номын санд цахим үйлчилгээ нэвтрүүлж, уншлагын танхимыг тохижуулах
	3.1.2.11. Албан бус боловсролын “Гэгээрэл төв”-ийг байр, техник хэрэгслээр хангаж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах
Зорилт 3.2. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдийг цогц байдлаар хөгжүүлэх	
Хөтөлбөр 3.2.1. СӨБ-ын үйлчилгээний менежментийг сайжруулах	3.2.1.2. Багш хөгжлийн төв байгуулах
	3.2.1.3. Багш, хүүхэд, эцэг эх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх
Хөтөлбөр 3.2.2. СӨБ-ын үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах	3.2.2.1. Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн танхимыг тохижуулах, сургалтын техник хэрэгслээр хангах
	3.2.2.2. Гал тогоог тоног төхөөрөмжөөр хангах
	3.2.2.3. Цэцэрлэгийн гадна талбайг хашаатай болгох
	3.2.2.4. Цэцэрлэгийн тоглоомын талбайг тохижуулах, ногоон байгууламжтай болох
	3.2.2.5. Дуу хөгжмийн боловсрол эзэмшүүлэх өрөөг тохижуулж, техник хэрэгслээр хангах
	3.2.2.6. Анги, бүлэг бүрийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайг шинэчлэх, нэмэгдүүлэх
Хөтөлбөр 3.2.3. Хөдөөгийн хүүхдийг СӨБ-д хамруулах	3.2.3.1. Хөдөөгийн багуудын гэр цэцэрлэгийг шинэчлэх
	3.2.3.2. Нүүдлийн болон гэр цэцэрлэгийн үйлчилгээний автомашинтай болох
Зорилт 3.3. Үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх	
Хөтөлбөр 3.3.1. Соёл, урлагийн үйлчилгээний байгууллагын хангамжийг сайжруулах	3.3.1.1. Соёл, урлагийн явуулын үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний зориулалтын автомашинтай болох
	3.3.1.2. Соёлын төвийг техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгээр бүрэн хангах
	3.3.1.3. Уран сайханчдыг тоглолтын хувцас, хэрэглэлээр хангах
	3.3.1.4. Номын сангийн цахим үйлчилгээ нэвтрүүлэх
	3.3.1.5. Орон нутаг судлах кабинетыг байртай болгож, тохижуулах, үзмэрийг баяжуулах
Хөтөлбөр 3.3.2. Соёл, урлагийн үйлчилгээний байрны нөхцөлийг сайжруулах	3.3.2.1. Номын сангийн уншлагын танхимыг тохижуулах
	3.3.2.2. Соёлын төвийн байрны халаалтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх
	3.3.2.3. Соёлын төвийн барилгад их засвар хийж үйлчилгээний стандартад нийцүүлэх
Хөтөлбөр 3.3.3. Түүхэн уламжлалыг сэргээх, хамгаалах	3.3.3.1. Түүх, соёлын дурсгалт газар, зүйлүүдийг хамгаалалтанд авах, хэсэгчлэн хайсжуулах
	3.3.3.2. Хүн амыг угийн бичгийг бүрэн хэмжээгээр хөтлүүлэх
	3.3.3.3. Дарь эхийн сүмийг техник хэрэгслээр хангах, бурхан шашны уламжлалыг сэргээх
Зорилт 3.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн өвчлөлийг 2 дахин бууруулах	
Хөтөлбөр 3.4.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх	3.4.1.1. Суманд зонхилон тохиолдож буй өвчлөлийн судалгаа гаргаж өвчлөлийг бууруулах арга хэмжээ авах
	3.4.1.2. Өвчлөлөөс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийн сургалтыг зохион байгуулах, сургалтын тусгайлсан танхим байгуулж тохижуулах

	3.4.1.3. "Эх, хүүхдийн эрүүл мэнд" төсөл хэрэгжүүлэх
Хөтөлбөр 3.4.2. Эмчилгээ, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, чанаржуулах	3.4.2.1. Мэргэшсэн хүүхдийн эмчтэй болох
	3.4.2.2. Сумын хүн эмнэлэгт рентген аппарат авах
	3.4.2.3. Зайн оношлогооны багажаар хангах
	3.4.2.4. Физик эмчилгээний багаж, тоног төхөөрөмжөөр хангах
Хөтөлбөр 3.4.3. Эмчилгээ, үйлчилгээний байрны нөхцөлийг сайжруулах	3.4.3.1. Өдрийн эмчилгээний тасаг нээн ажиллуулах
	3.4.3.2. Уламжлалт болон эмийн бус эмчилгээний сувилал байгуулах
	3.4.3.3. Эмийн сангийн байрыг шинээр барих
	3.4.3.5. Шинжилгээ оношлогооны лаборатори нээн ажиллуулах
	3.4.3.6. Эмнэлгийн барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, засварлах
Зорилт 3.5. Төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, ил тод, оновчтой хэлбэрээр хүргэх	
Хөтөлбөр 3.5.1. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган хүртээмжийг нэмэгдүүлэх	3.5.1.1. Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх
	3.5.1.2. Эрх зүйн туслалцааны төв байгуулан ажиллуулах
	3.5.1.3. Төрийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн цахим болон явуулын сантай болж иргэдэд мэдээлэл түгээхэд ашиглаж байх
	3.5.1.4. Дотоодын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах
	3.5.1.5. Сумын вэб сайт нээж ажиллуулах
	3.5.1.6. Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудыг интернэтийн дотоод сүлжээнд холбох
	3.5.1.7. Төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх
Хөтөлбөр 3.5.2. Малчдад хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах	3.5.2.1. Хармагт багийн төвийг шинээр барих
	3.5.2.2. Багийн дарга нарыг унаагаар хангах
	3.5.2.3. Хөдөөгийн багийн төвүүдийн гадна дотно орчныг тохижуулах
	3.5.2.4. Малгүй болон цөөн малтай өрхийг малжуулах
Хөтөлбөр 3.5.3. Төрийн үйлчилгээний орчинг сайжруулах	3.5.3.1. Нутгийн удирдлагын ордонтой болох
	3.5.3.2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах
	3.5.3.3. Сумын ёслол хүндэтгэлийн өргөө байгуулан ажиллуулах

Зорилго-4. Байгаль, орчныг хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах хүрээний хөтөлбөр, төслүүд

Хөтөлбөр	Төслийн хувийн дугаар, нэр
Зорилт 4.1. Байгаль хамгаалах тогтолцоог сайжруулж үр нөлөөг дээшлүүлэх	
Хөтөлбөр 4.1.1. Байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалтын менежментийг сайжруулах	4.1.1.1. Сумын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэх
	4.1.1.2. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах
	4.1.1.3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд иргэдийн оролцоог хангаж, малчдын бүлэг, байгаль хамгаалах нөхөрлөлийн тоог нэмэгдүүлэх
	4.1.1.4. Баг бүр хадлан, тэжээлийн ургамлын 2-оос доошгүй талбайтай болох (20 га газар-Шар мод, Баян хошуу, Сайхан, Цайдам, Өвөр хулсны чиглэл)
	4.1.1.5. "Мухарын хойд, урд булгийн эх"-ийг хашиж хамгаалах, мод тарьж тохижуулах
	4.1.1.6. Гүний болон гадаргын усны нөөцийг тогтоох, хамгаалалтыг сайжруулах
	4.1.1.7. Сумын төвийн ундны усны эх үүсвэрүүдэд цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах

	4.1.1.8. Завхан голын хамгаалалтын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
	4.1.1.9. Хяргас, Айраг нуурын загасны судалгаа хийж, нөөцийг тогтоох, үржүүлэх
	4.1.1.10. Биологийн төрөл зүйлийг иргэдийн оролцоотойгоор хамгаалах
Хөтөлбөр 4.1.2. Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	4.1.2.1. Завхан голын дагууд 62 мянган метрт ойн зурвас байгуулах
	4.1.2.2. Суманд мод үржүүлгийн газар байгуулах.
	4.1.2.3. Мод орлох хийн болон шахмал түлшийг ахуйн хэрэглээнд ашиглах
Зорилт 4.2. Байгаль орчны техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах	
Хөтөлбөр 4.2.1. Байгаль орчны зориулалтын техник хэрэгслийн хангамжийг сайжруулах	4.2.1.1. "ЭКО КЛУБ" - ыг тоног төхөөрөмжөөр хангах
	4.2.1.2. Сумын байгаль орчны хэсгийг шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангах, унаажуулах
	4.2.1.3. Цаг уурын өртөөний байрыг засварлаж, тохижуулах
	4.2.1.4. Цаг уурын шинжилгээ, ажиглалтын автомат станц суурилуулан техник хэрэгслээр хангаж цахим мэдээллийн сүлжээ нэвтрүүлэх
Хөтөлбөр 4.2.2. Байгаль орчны бохирдлыг бууруулах	4.2.2.1. Сумын төвийн хог зөөвөрлөх зориулалтын машинтай болох
	4.2.2.2. Хуучин балгас, шороон хогийг овоолго болгон нөхөн сэргээх
	4.2.2.3. Сумын төвийн хогийн цэгт хязгаар тогтоон хашаажуулж тэмдэгжүүлэх, хамгаалалттай болгох
	4.2.2.4. Сумын төвд нийтийн бие засах газар, стандартын бохир усны цооногтой болох

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамаарах талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг

Энэхүү төлөвлөгөө нь тус сумын удирдлага, иргэд, хөдөлмөрчдөөс гадна аймаг, бүс, улсын хэмжээний бодлого боловсруулж шийдвэр гаргагчид, ТББ, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагч, хандивлагчдын дэмжлэгтэйгээр хэрэгжих үндэстэй тул дараах байдлаар хамтран ажиллах, оролцох, үүрэг хүлээх боломжтой.

Хамтран ажиллах субъект	Хамтран ажиллах чиглэл, хүрэх үр дүн
Сумын төр захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагууд	- Төлөвлөгөөг дэмжигч, хэрэгжүүлэгч байгууллага, сонирхогч иргэд, хуулийн этгээдийг зохион байгуулалт, арга зүйгээр дэмжих - Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг зохион байгуулах, хандивлагчдад танилцуулах ажлыг чанартай зохион байгуулах - Төлөвлөгөөнд туссан зорилго, зорилт, хөтөлбөр, төслүүдийг жил жилийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах - Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх - Хөгжлийн төлөвлөгөөний тендер шалгаруулалтыг хуулийн дагуу ил тод нээлттэй, чанартай зохион байгуулах, хөтөлбөрийг дэмжигчдийн хувь, хандивийг зохистой зарцуулж, үр дүнг нийтэд мэдээлж ажиллах - Бусад аймаг, хотуудад амьдарч байгаа нутгийн иргэдийн нутгаа зорих, тус нутагт амьдран суугаа аав ээж, ахан дүүсээ дэмжихэд орон

	нутгийн төрийн байгууллагуудаас бүх талаар дэмжих хамтран ажиллах
Завхан сумын уугуул болон тус суманд ажиллаж амьдарч байсан хүмүүс, нутгийн зөвлөлүүд	- Мэдээллийн цахим сан үүсгэн хөгжлийн төлөвлөгөөг сурталчлах, мэдээлэх. - Өөр аймаг, сум, хотод ажиллаж амьдарч байгаа иргэдийн хамтран ажиллах санаачлагыг нэмэгдүүлэх, иргэдийг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагч, хандивлагч татах, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах
Банк санхүү, хувийн хэвшлийн ААНБ, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагч, төсөл хэрэгжүүлэгч нэгж	- Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох, гүйцэтгэгчээр хамтран ажиллах. - Зах зээлд шударгаар өрсөлдөх байгууллагынхаа жил жилийн ажлын зорилт, төлөвлөгөөнд хөгжлийн төлөвлөгөөний төслүүдийг суулган төлөвлөн ажиллах - Төсөл хэрэгжүүлэгчдэд санхүүгийн дэмжлэг, зээл туслалцаа үзүүлэх
ТББ, иргэд	- Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санал санаачлага гаргах, дэмжлэг үзүүлэх - Хөтөлбөр төслөөс сонгон авч хэрэгжүүлэх, төрийн байгууллагатай хамтарч ажиллах, хөндлөнгийн хяналт тавих - Тайлан мэдээлэл сонсож, зөв мэдээлэл түгээх
Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, сургалт мэдээллийн байгууллагууд	- Сургалт, сурталчилгаа заавар зөвлөгөө өгч хамтран ажиллах - Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар цаг тухайд нь иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл өгөх - Хөтөлбөрт тодорхойлогдсон төслүүдийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд бусад аймаг, сум, байгууллагатай хамтран ажиллах чиглэл

№	Аймаг сумын нэр	Хамтран ажиллах чиглэл	Хөрш аймаг, суманд санал болгох бүтээгдэхүүн	Хөрш аймаг, сумаас авах бүтээгдэхүүн
1	Увс аймгийн Наранбулаг	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, нутаг бэлчээр, түлшний болон ахуйн хэрэглээний мод, модон эдлэл	Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн, улаан давс, Загас, суль, сулхир	Түлшний болон ахуйн хэрэглээний мод, модон эдлэл, тэргүүн туршлага
2	Цагаанхайрхан сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, нутаг бэлчээр, түлшний болон ахуйн хэрэглээний мод, модон эдлэл	Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн, улаан давс, Загас, суль, сулхир	Түлшний болон ахуйн хэрэглээний мод, модон эдлэл, малын бэлчээр
3	Малчин сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, нутаг бэлчээр, ааруул цагаан идээ боловсруулах технологи	Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн, улаан давс, Загас, суль, сулхир	малын бэлчээр, Баяд ааруул цагаан идээ
4	Ховд аймгийн Дөргөн сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг	Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн, улаан давс, Загас, суль, сулхир	малын бэлчээр, тэргүүн туршлага

		уулзалт, нутаг бэлчээр, эрчим хүч		
5	Ховд аймгийн Мянгад сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, нутаг бэлчээр, улаан тоосго	Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн, улаан давс, Загас, суль сулхир	малын бэлчээр, улаан тоосго
6	Завхан аймгийн Ургамал сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, нутаг бэлчээр	Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн, улаан давс, Загас, суль сулхир,	малын бэлчээр, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн
7	Завхан аймгийн Дөрвөлжин сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, нутаг бэлчээр, сум дундын бүс нутаг тогтоох	Ингэний айраг, сүүн бүтээгдэхүүн, улаан давс, Загас, суль сулхир	малын бэлчээр, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн
8	Хилийн худалдаа	Худалдааны чиглэлээр	ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүн

Дөрөв.ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээний төслүүд ба хөрөнгө санхүүгийн тооцоолол

Сумынхөгжлийнстратегитөлөвлөгөөгхэрэгжүүлэхэднийт**80107сая** төгрөгийн эх үүсвэр шаардлагатай бөгөөд үүнийг дараах эх үүсвэрээр хангахаар тооцоолж байна. Үүнд:

- Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр **61149**сая төгрөг буюу76,3 хувь
- Орон нутгийн хөрөнгөөр **1301**сая төгрөг буюу 1,6 хувь
- Хөрөнгө оруулагчид, хандивлагчдын зардлаар **17657**сая төгрөг буюу 22,0 хувийг тус тус хангана.

Нийт **148 төсөл, үйл ажиллагааг** хэрэгжүүлэх бөгөөд үүнийг салбараар авч үзвэл:

Эдийн засгийн салбарыг хөгжүүлэх **39-төсөл, 16216 сая** төгрөгийн
Дэд бүтцийг хөгжүүлж, бизнесийн орчин бүрдүүлэх **25-төсөл, 57865 сая** төгрөгийн
Төр, нийгмийн үйлчилгээг сайжруулах **63-төсөл, 3943сая** төгрөгийн
Байгаль орчныг хамгаалах хүрээнд**21-төсөл, 2083 сая** төгрөгийнхбайхаартөсөөлжбайна.

Төлөвлөгөөнийхүрээндхэрэгжүүлэххөтөлбөр, төсөлүйлажиллагааныталаархдэлгэрэнгүй мэдээллийг төлөвлөгөөний холбогдох бүлэг болон төлөвлөгөөний хавсралт, хүснэгт, танилцуулгуудаас үзэж болно.

№	Зорилго	Хөтөлбөрийн тоо	Төслийн тоо	Төслийн нийт өртөг \сая, төг\	Үүнээс		
					Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Улсын төсвийн хөрөнгөөр	Хөрөнгө оруулагчид дэмжигч, хандивлагчдын хөрөнгөөр
1	Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж сумын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх	9	39	16216	741	1094	14381
2	Иргэд, аж ахуйн нэгж бүр үр ашигтай бизнес эрхлэх тэгш, шударга, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх	6	25	57865	91	56414	1360
3	Эрүүл, оюунлаг, амьдрах ухаантай, бүтээлч сэтгэлгээтэй, өв соёлоо дээдэлсэн иргэнийг төлөвшүүлэх	14	63	3943	321	2946	676
4	Байгаль, орчныг хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах	4	21	2083	148	695	1240
Д Ү Н		33	148	80107	1301	61149	17657

4.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн нэгдсэн шалгуур үзүүлэлтүүд

Сумын хөгжлийн төлөвлөгөөний үр дүнг тооцохдоо дараах ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэл болгож байна. Үүнд:

ДД	Гол үзүүлэлт	Хэмжих нэгж	Одоогийн түвшин	Хүрэх түвшин		
				2015 он	2018 он	2021 он
1.	Нэг хүнд ноогдох ДНБ	Мян.төг	1700	5000	10000	15000
2.	Сумын хүн ам	Тоо	1853	2076	2303	2528
3.	Сургуулийн суралцагчдын сурлагын амжилт	Хувь	63,6	67	70	75
4.	Сургуулийн мэргэжлийн зэрэгтэй багшийн хувийн жин	Хувь	52,9	76,4	88,2	95
5.	Бичиг үсэг үл мэдэгч	Тоо	80	60	30	-
6.	Сургуулийн өмнөх боловсролын стандарт хангалт	Хувь	67	75	80	85
7.	СӨБ-ын хамран сургалт	Хувь	82	92	97	100
8.	СӨБ-ын мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувийн жин	Хувь	33,3	66,6	88	95
9.	Соёлын мэргэжлийн боловсон хүчний хангалт	Хувь	0	100	100	100
10.	Соёл, урлагийн явуулын үйлчилгээний тоо	Тоо	6	9	12	15
11.	Соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо	Мянган хүн	8	9	10,5	12

12.	Соёл, урлагийн чиг баримжаат дугуйлан	Тоо	1	4	8	8
13.	Хүн амын өвчлөлийн түвшин	Хувь	28,2	19,6	17,1	13,9
14.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт	Хувь	26,2	45	60	80
15.	Нэг цонхны ба явуулын үйлчилгээнд хамрагдсад	Мянган хүн	0	3	4	5
16.	Эрх зүйн төвөөр үйлчлүүлэгчдийн тоо	Мянган хүн	0	0,5	1	1,5
17.	Төрийн үйлчилгээний ажлын тайлан тавилтанд хамрагдагчид	Мянган хүн	1.2	2	3	4
18.	Ажилгүйдлийн түвшин	Хувь	1,9	1,5	1,3	0,5
19.	Ядуурлын түвшин	Хувь	57	29	13	4
20.	Нийгэм зүй, амьдрах ухааны сургалтанд хамрагдагчид	Хүний тоо	150	399	500	800
21.	Сайжруулсан ба хатуу хучилттай зам	Км	0	0	30	121
22.	Инженерийн хийцтэй гүүр	Тоо	0	1	1	1
23.	Цахилгаан эрчим хүчний хангамжтай өрх	Хувь	87	95	100	100
24.	Үүрэн телефон хэрэглэгчид	Тоо	600	700	850	1600
25.	Бизнес эрхлэгчид (малчид ороогүй)	Хүний тоо	60	80	100	130
26.	Мэдлэг, чадвартай бизнес эрхлэгчид	Тоо	50	100	120	130
27.	Бизнесийг дэмжих болон эрх зүйн үйлчилгээ үзүүлэгч цэгийн	Тоо	0	1	1	1
28.	Гадаал харилцаанд оролцох чиглэл	Тоо	0	3	5	6
29.	Сумын өөрийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага	Тоо	0	1	2	2
30.	Малын тоо	Толгой	60000	75000	82000	90000
31.	Тэмээний тоо	Толгой	4700	5100	5500	7500
32.	Нэг ямаанаас авах ноолуур	Гр	300	310	330	350
33.	Тэмээний нэгдүгээр зэргийн ноос	Кг	5	5,1	5,3	5,5
34.	Хонины нэгдүгээр зэргийн ноос	Кг	1,2	1,3	1,4	1,5
35.	Хүлэмжийн тоо	Тоо	1	5	8	10
36.	Чацарганы тариалалтын талбай	Га	1	15	20	25
37.	Жижиг, дунд үйлдвэр	Тоо	0	4	7	9
38.	Аялал, жуулчлалын баазын тоо	Тоо	1	2	3	4
39.	Аялал, жуулчлалын үйлчилгээ авагчид	Тоо	800	2400	3900	5000
40.	Эрэлтэнд нийцсэн худалдаа, үйлчилгээний томоохон цэг	Тоо	0	1	1	1
41.	Бараа борлуулалтын нийт орлого	Сая.төг	100	300	650	850
42.	Ашиглагдахгүй байгаа бэлчээр	Га	265	175	100	50
43.	Таримал ойн зурвас	Га	1	16	40	62
44.	Инженерийн хийцтэй худгийн тоо	Тоо	17	20	23	25
45.	Хог бүхий талбайн хэмжээ	Га	5	4	3	2
46.	Хадлангийн хашсан талбай	Га	2	8	15	20

Төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, үнэлгээ

Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын болон төгсгөлийн хяналт үнэлгээг ИТХ, ТХХ-оос хамтран зохих журмын дагуу зохион байгуулж байна. Хяналт үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний хэрэгжилт биелэлтийн явцыг үе шаттайгаар тодорхойлох, явцыг эрчимжүүлэх явдал мөн.

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн явцад сумын ИТХ болон ЗДТГ, сумын төлөвлөлт хяналтын хорооны зэрэгцээ сумын төрийн бус байгууллага, иргэд хяналт зохих хэмжээгээр тавьж оролцоно.

Хяналт, үнэлгээг төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний үе шат, дунд хугацааны үе шат, төгсгөлийн үе шатны гэсэн үе шаттайгаар хянаж дүгнэлт гаргах ба энэ үйл ажиллагааг зохион байгуулахдаа сумын төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааны журмыг удирдлага болгоно.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны үнэлгээг 2016, 2019, 2022 оны эхний улирлуудад тус тус зохион байгуулна. Үе шатны үнэлгээний зэрэгцээ төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүрийн эцэст болон тухайн төслийн хэрэгжилтийн дунд хугацаанд хэрэгжүүлж байна.

Хяналт, үнэлгээг явуулахдаа төсөл тус бүрийн танилцуулгад тодорхойлсон болон ерөнхий шалгуур үзүүлэлттэй жишиж харьцуулах ба тогтоосон баталгаажилтын эх үүсвэрүүдийг үндэслэл болгож байна.

Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилийн хяналт, үнэлгээ явуулсан тухай бүр иргэд, олон нийтэд ил тод мэдээлж байх ба мэдээллийн тусгай самбарыг тогтмол ажиллуулна.

Хяналт, үнэлгээний дүнг үндэслэн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулах асуудлыг сумын ИТХ, ТХХ хамтран шийдвэрлэж байна. Энэ ажиллагаанд зохих журмыг удирдлага болгоно.

ЗАВХАН СУМЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ХОРОО,
АЖЛЫН ХЭСЭГ

СУМЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Ерөнхий зүйл. Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэх үйл явц нь тухайн сумын нийт байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагаа мөн. Дээрх үйл ажиллагааг сумын түвшинд хариуцан төр, захиргааны болон иргэний нийгэмтэй хамтран зохион байгуулж хэрэгжүүлэгч нь олон нийтийн төлөөллийн бүрэлдэхүүн бүхий Төлөвлөлт, хяналтын хороо юм. Энэхүү журам нь сумын төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагаанд хамаарна.

Зорилго, хэрэгцээ. Сумын төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааг жигд тасалдалгүй явуулах, зохицуулахад энэхүү журмын зорилго оршино. Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавих, үнэлгээ хийх үйл ажиллагааг сумын Төлөвлөлт, хяналтын хорооноос хариуцан зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хөгжлийнхөө стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж буй сум нь энэхүү үлгэрчилсэн журамд үндэслэн орон нутгийнхаа онцлогийг харгалзан өөрийн сумын “Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааны журам”-ыг батлан хэрэгжүүлж ажиллана.

Сумын төлөвлөлт, хяналтын хорооны тодорхойлолт, зорилго

Сумын төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн бодлоготой холбоотой асуудлыг хариуцан зангидаж ажиллах төр, захиргааны байгууллага, иргэд, олон нийтийн төлөөллийн орон тооны бус бүтэц мөн. Төлөвлөлт, хяналтын хороог тухайн сум хөгжлийнхөө стратеги төлөвлөгөөг боловсруулахын өмнө байгуулан ажиллуулна. Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүнийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталж, **сумын Засаг даргаар** ахлуулна. Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүнд нь:

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-ИТХ
- сумын ЗДТГ
- төрийн үйлчилгээний байгууллага
- нийгмийн үйлчилгээний байгууллага
- дэд бүтцийн аж ахуйн нэгж
- төрийн бус байгууллагууд
- иргэний нийгмийн бүлэг, бүлэглэл
- улс төрчид-намууд
- албан хэвшлийн бизнесийн аж ахуйн нэгж
- албан бусаар бизнес эрхлэгчдийн төлөөлөл зэрэг 15-аас доошгүй гишүүн оролцсон байх нь тохиромжтой.

Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааны журмыг хөгжлийн стратеги төлөвлөгөөний хамт сумын ИТХ-аар хэлэлцэж баталгаажуулна.

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулж эхлэх үйл явцаас эхлэн уг төлөвлөгөөг хэрэгжиж дуусах хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулах бөгөөд стратеги төлөвлөгөөний хугацааг сунгах, хугацаа дуусмагц дараагийн шатны төлөвлөгөөг шинээр боловсруулах үед үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна.

Төлөвлөлт, хяналтын хорооны бүтэц, зохион байгуулалт

Төлөвлөлт, хяналтын хороо нь жилд 2-оос доошгүй удаа хуралдаж төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үнэлгээний зэрэг асуудлыг хэлэлцэж байна. Хурлаас тогтоол, тэмдэглэл гаргаж, хурлыг даргалагч гарын үсэг зурж шийдвэрийг баталгаажуулж байна.

Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүн, бүтэц, зохион байгуулалтыг Төлөвлөлт, хяналтын хороо өөрийн анхны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Төлөвлөлт, хяналтын хороо нь даргын зэрэгцээ бодлогын хүрээнд үйл ажиллагааг хариуцан зохицуулах нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн дарга нь **сумын Засаг даргын орлогч** байх юм. Нарийн бичгийн дарга нь хорооны албан хэргийг хөтлөх бөгөөд байнгын үйл ажиллагааг хангах зохион байгуулалтыг хариуцан ажиллана.

Хороо нь дотроо суман дахь голлох салбаруудын хөгжлийн асуудлыг хариуцсан ажлын бүлгүүдтэй байна. Ажлын бүлэг нь 4-өөс доошгүй байх бөгөөд

- эдийн засгийн хөгжлийн ажлын бүлэг
- бизнесийн орчны ажлын бүлэг
- нийгмийн үйлчилгээний ажлын бүлэг
- байгаль, орчны ажлын бүлгүүд заавал байна.

Эдийн засгийн тэргүүлэх салбаруудын болон орон нутгийн бусад онцлогийг харгалзан ажлын нэмэлт бүлгүүдийг төрөлжүүлэн байгуулан ажиллуулж болно. Мөн бизнес, эдийн засгийн бүлгийг асуудлыг хариуцсан бүлгийг нэгтгэн зохион байгуулж болно.

Ажлын бүлгүүд нь тус тусдаа гишүүд, ахлагчтай байх бөгөөд тэднийг Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүнээр хэлэлцэн уг хорооны бүрэлдэхүүнд оролцогчдоос сонгож ажиллуулна.

Хорооны гишүүдээс орон гарсан бол тухайн гишүүдийн ажил эрхлэлтийн байдал, хорооны бүрэлдэхүүний онцлогийг харгалзан ИТХ-ын тэргүүлэгчид нөхөн томилж байна.

Төлөвлөлт, хяналтын хороо нь ажлаа жил жилээр төлөвлөн хэрэгжүүлж ажиллана. Төлөвлөгөөг сумын ИТХ-ын хурал, ЗДТГ-тай санал солилцсоны үндсэн дээр хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд төлөвлөлт, хяналтын хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Мөн түүний жилийн ажлын төлөвлөгөөг ИТХ-аар хэлэлцэн баталгаажуулж болно.

Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэн эрх

Төлөвлөлт, хяналтын хороо нь бие даасан байгууллагын хувьд хууль, эрх зүйд нийцсэн шийдвэрийг гаргаж байна. Гаргасан шийдвэр нь хорооны бүрэлдэхүүний хувьд заавал биелүүлэх баримт бичиг болно.

Төлөвлөлт, хяналтын хороо нь дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:

- Төлөвлөгөөг боловсруулах, түүнд тусгах асуудал, хэрэгжүүлэх арга замын талаар хэлэлцүүлэг зохион байгуулах
- Хөгжлийн бодлого, чиг хандлагатай холбоотой асуудлаар санал, зөвлөмж гаргах

- Төлөвлөгөөг хэрэгүүлэх явцад түүнийг өөрчлөх, нэмэлт, өөрчлөлт оруулах, сайжруулах талаар хамтын шийдвэр гаргах, тэр тухай саналаа ИТХ-д мэдүүлэх, хуралдаанаар хэлэлцүүлэх
- Цаг хугацааны хувьд болон бусад шалтгаанаар хэрэгжих боломжгүй төсөл, асуудлыг төлөвлөгөөнөөс хасахыг санал болгох.

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой бүхий л асуудлаар ИТХ, ЗДТГ-т зөвлөх эрхтэй. Мөн төлөвлөгөө, төсөл хэрэгжүүлэгчид болон бусад хамаарагчдад зөвлөгөө, чиглэл өгч ажиллана.

Төлөвлөлт, хяналтын хорооны голлох үүргүүд

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулахаас түүнийг хэрэгжиж дуусах хүртэл үйл ажиллагаа явуулахдаа дор дурдсан үүргийг хүлээн ажиллана.

Төлөвлөгөөг боловсруулахад оролцох нь

Төлөвлөлт, хяналтын хорооны гол үүргийн нэг нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулахад оролцож, оролцооны үнэлгээг олон хэлбэрээр хийх, олон нийтийг хамарсан ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, нөхцөл байдлын судалгаа явуулах зэрэг үйл ажиллагааг бүрэн хариуцан хэрэгжүүлнэ. Мөн тэдгээрийн үр дүнг нэгтгэн төлөвлөх, төлөвлөгөөний төслийг хянан сайжруулах, ИТХ-д өргөн барих ажиллагааг гардан зохион байгуулж ажиллана.

Төлөвлөгөөг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд байлцаж, хурлаас гарсан шийдвэрийн дагуу өөрчлөлт, сайжруулалтыг хийж эцэслэн боловсруулна.

Төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаанд сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгтэй нягт хамтран ажиллана.

Ажлын хэсгийн гүйцэтгэвэл зохих үйл ажиллагаа дуусмагц төлөвлөгөөтэй холбоотой асуудлаар Төлөвлөлт, хяналтын хороо цаашид дагнан ажиллана.

Хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулахад өөрийн бүрэлдэхүүнээс гадна иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй нягт хамтран ажиллана.

Төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулах

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл явцыг уг төлөвлөгөөний үндсэн болон хавсралт хэсгүүдэд зааж тодорхойлсны дагуу зохих хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Ингэж ажиллахдаа дараах зарчим, арга хэлбэрийг үндэслэл болгоно. Үүнд:

- Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан төсөл бүрийг хорооныхоо гишүүдэд хуваарилан хариуцуулж, биелэлтийг дүгнэн мэдээлж байх
- Төлөвлөгөөний төсөл бүрийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлон баримталж ажиллах

- Төсөл нэт бүрт хувийн хэрэг нээн хөтөлж, зохих баяжуулалт хийж байна (Хувийн хэрэг нь нарийн бичгийн даргад хадгалагдах ба ажлын бүлгийн ахлагч нар баяжуулалт хийж байна. Хувийн хэргийн санал болгож буй загварыг хавсаргав)
- Төсөл бүрийн хөрөнгийг босгох арга гарган бүрдүүлэх
- Төслүүдийг хэрэгжүүлэх талаар цаг үеийн болон тусгай компанит ажлууд зохион байгуулах
- Төслийг хэрэгжүүлэгчидтэй гэрээ, санамж бичиг байгуулан дүгнэж байх
- Голлох аж ахуйн нэгж, байгууллагуудыг хөгжлийн төлөвлөгөөтэй болгох, тэдний төлөвлөгөөнд сумын төлөвлөгөөгөөр тодорхойлсон асуудлуудыг тусгуулах
- Албан тушаалтнууд, иргэд, оролцогчдод бүтээлч даалгавар өгч дүгнэн ажиллах
- Төслүүдийг хэрэгжүүлэх ажлын явцын талаар хорооны гишүүд, байгууллагын эрх баригч нарын илтгэл, сонсголыг хэлэлцэж чиглэл, шийдвэр гаргах
- Хөрөнгө оруулагчид, хандивлагчдын чуулга-уулзалтыг ИТХ, ЗДТГ-тай хамтран үе шаттай зохион байгуулах
- Хөрөнгө оруулагчид, хандивлагчдын оруулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах үйл явцыг зохион байгуулах
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, зориулагдсан хөрөнгийн зарцуулалтын талаар жил бүр иргэд, олон нийтэд зориулсан мэдээллийн хуудас гаргаж байх
- Төлөвлөгөө, түүний явцыг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байх
- Өөрийн мэдээллийн самбар ажиллуулж, мэдээллийг тогтмол шинэчилж байх
- Мөн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор авах зохион байгуулалтын асуудлаар байр сууриа илэрхийлэн зохигчидтой хамтран ажиллах
- Төлөвлөгөөнд тодорхойлсон төслүүдийг хэрэгжүүлэхэд бололцоотой дэмжлэг тусалцааг дангаараа болон бусадтай хамтран үзүүлж ажиллах зэрэг болно.

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслүүдийн шалгаруулалтыг хариуцсан “Төсөл шалгаруулах, үнэлэх байнгын баг”-ийг хорооныхоо дэргэд байгуулж, төлөвлөгөөнд тодорхойлсон үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөл, хөтөлбөрийн шалгаруулалт зарлах, материалыг хүлээн авах, шалгаруулах үйл ажиллагааг зохицуулж хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавих үйл ажиллагаа

Төлөвлөлт, хяналтын хороо нь төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулагч, хариуцагчийн хувьд үр дүнг хянаж байх үүргийг хүлээнэ. Хянах үйл явц нь тасалдалгүй байнгын шинжтэй явагдах ёстой. Биелэлтийн явцыг хянаж байхад төсөл бүрт нээсэн хувийн хэргийг ашиглаж байна.

Хяналтыг голлон хэрэгжүүлэгч нь төлөвлөлт, хяналтын хорооны дарга, ажлын бүлгүүдийн ахлагч нар байна.

Хяналт хийсэн тухай бүрт төслийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийх ба хяналтын үр дүнг төлөвлөлт, хяналтын хорооны буюу ажлын бүлгийн хурлаар хэлэлцэж цаашид авах арга хэмжээг ярилцан тодорхойлж байна.

Хяналтын үйл явцад заавал анхаарвал зохих зүйл бол сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулан суманд оруулсан хөрөнгийн зарцуулалт мөн. Хөрөнгө оруулагчид, хандивлагчид, дэмжигчдээс оруулсан хөрөнгийн тооцоог эх үүсвэр нэг бүрээр гаргаж, тухайн хөрөнгийг юунд, ямар зориулалтаар зарцуулсныг үйл ажиллагаа нэг бүрээр тодорхойлж байна. Хэрэгжүүлсэн хяналтын үр дүнг өөрийн мэдээллийн самбар, хуудас болон бусад хэрэгслийг ашиглан иргэд, олон нийтэд хүргэж байна.

Төлөвлөгөөний төслүүдийн хэрэгжилтийн үнэлгээ, түүний арга хэлбэрүүдийн онцлог ба анхаарах зүйлүүд

Төлөвлөлт, хяналтын хорооны үндсэн үүрэгт ажлын чухал хэсэг нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний үнэлгээний асуудал мөн.

Төлөвлөгөөний үнэлгээг хийхдээ түүний хавсралт бүрэлдэхүүн хэсэг болох хяналт үнэлгээний матрицийг үндэслэл болгоно. Тухайлбал төлөвлөгөөний хүрээний төслүүдэд үнэлгээ хийх хугацаа, төсөл бүрийн шалгуур үзүүлэлт, баталгаажилтын эх үүсвэрийн үзүүлэлтүүдийг үнэлгээ явуулахад ашиглана.

Үнэлгээ хийх хугацааг сонгохдоо тухайн төсөл нь хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртлээ дунд шатны болон төгсгөлийн үнэлгээ хийгдсэн байхаар бодох ба харин төсөл хэрэгжиж эхэлсэн эсвэл дууссан эсэхээс үл шалтгаалан төлөвлөгөөний үе шатны бүрийн төгсгөлд үнэлгээг бүрэн хэмжээгээр хийж байна.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь тухайн төслийг хэрэгжсэн гэж үзэх үндэслэл болох тул үнэлгээний дүнг шалгуур үзүүлэлтийн түвшинг хэдий хэмжээгээр, хэдэн хувиар хангаж чадаж байгаагаар тодорхойлно.

Үнэлгээг явуулахдаа бодит баримт материал, судалгааны үр дүнг үндэслэх ба хийсвэр таамгаар үнэлэх явдал гаргаж болохгүй.

Үнэлгээг явуулахдаа хяналт, үнэлгээний багуудыг түр хугацаагаар зохион байгуулж ажиллуулах замаар зохион байгуулна.

Үнэлгээ явуулсан тухай бүр төслийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийж байна. Үнэлгээ хийх явцад болон хийсний дараа цаашид тухайн төслийг хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлыг тодорхойлж байна. Үнэлгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулна.

Д/д	Төслийн код, нэр	Үнэлгээ хийсэн хугацаа	Үнэлгээний дүн	Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ	Тохиолдсон бэрхшээл хүндрэл	Цаашид авах арга хэмжээ	Хариуцан зохицуулагч	Анхаарах хүчин зүйлүүд
1								
2								
3								
4								
5								
...								

Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах боломж ба арга зүй

Төлөвлөлт, хяналтын хороо нь жил бүрийн эцэст өөрийн ээлжит хуралдааныг хийж байх бөгөөд төлөвлөгөөний явц, үр дүнг төсөл нэг бүрээр хэлэлцэж байна. Ингэхдээ зайлшгүй өөрчлөх, нэмэлт, сайжруулалт оруулах, төлөвлөгөөнөөс хасах, мөн төлөвлөгөөнд нэмж оруулах шинэ төслүүдийн үндэслэлийг гаргаж, өөрийн санал, байр суурийг илэрхийлсэн тайлбарын хамт ИТХ-д мэдүүлж байна.

ИТХ нь тухайн материалыг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. ИТХ-аар хэлэлцээд тогтоол гарган өөрчлөлтийг баталж байна.

Төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтийн талаар иргэд, олон нийтэд мэдээлж байна.

Төсөв, санхүүгийн зохицуулалт

Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааны жилийн зардлыг сумын төсөвт тусган санхүүжүүлнэ. Эх үүсвэр нь орон нутгийн нэмэгдэл орлого, хандив зэргээс бүрдэнэ.

Төлөвлөлт, хяналтын хорооноос хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээний төлөвлөгөөг үндэслэн жил жилийн зардлыг төрөл тус бүрээр тодорхойлж сумын төсөвт тусгаж байна.

Төлөвлөлт, хяналтын хорооны дарга, нарийн бичгийн даргад тэдний үйл ажиллагааны идэвхитэй байдал, ажлын үр дүнг харгалзан жилд нэг удаа үр дүнгийн урамшуулал олгож байна. Урамшууллын хэмжээг тухайн нөхцөл байдалд үндэслэн тогтоох ба сумын жил жилийн төсөвт тусгана.

Төлөвлөлт, хяналтын хорооны шугамаар зохиогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ, судалгаа болон төрөл бүрийн бусад ажиллагаанд ИТХ, ЗДТГ-ыг болон ТХХ-ны шийдвэрээр томилогдож оролцсон гишүүдэд тухай бүр нь зохих урамшуулал олгох асуудлыг тухайн байгууллагууд хариуцан зохицуулж байна.

Хариуцсан төслүүдээ хугацаанд нь амжилттай сайн хэрэгжүүлж байгаа хорооны гишүүд, ажлын бүлгийн ахлагч нарт зохих урамшил олгож байна.

Онцгой ач холбогдолтой төслийг амжилттай хэрэгжүүлсэн хорооны гишүүнийг төслийн эдийн засгийн үр ашгаас хувь олгох байдлаар хэрэгжүүлэгчтэй холбон ажиллуулж болно.

Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Тухайн жилийн сумын төсөвт зааж тодорхойлсон эх үүсвэр
- Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааг дэмжих чиглэлээр өгсөн хандив, тусламж
- Орон нутгийн төсвөөс давсан орлого
- Засаг даргын мэдлийн нөөц хөрөнгө
- Бусад

Хяналт, үнэлгээний баг, түүний үйл ажиллагаа

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний биелэлтийн байдалд хяналт тавих, үнэлгээ хийх үйл явцаа хэрэгжүүлэхдээ хяналт, үнэлгээний багийг байгуулан ажиллуулах байдлаар хэрэгжүүлнэ.

Хяналт, үнэлгээний баг нь өргөн, дунд, анхан шатны гэсэн 3 шатлалын бүтэцтэй байна.

Өргөн бүтэц нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны төгсгөлийн буюу төлөвлөгөөний хэрэгжилтийн эцсийн хяналт, үнэлгээг хийхэд байгуулагдан ажиллах бөгөөд үүнд

төлөвлөлт, хяналтын хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцохын зэрэгцээ, иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг нэмж оролцуулна. Ийм үнэлгээг төлөвлөгөөнд тодорхойлогдсон бүх төслүүдийн байдалд хяналт, үнэлгээ хийх зарчмаар хэрэгжүүлнэ.

Дунд шатлалын бүтэц нь хөгжлийн стратеги төлөвлөгөөний жилийн үр дүнг тодорхойлоход байгуулагдан ажиллана. Ийм баг нь хорооны ажлын бүлгүүдийн болон иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон 10 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн жил жилийн хяналт, үнэлгээг хийхдээ нийт төслүүдийн биелэлтийг тодорхойлох бөгөөд тухайн жилд эхлэх, үргэлжлэх, бүрэн хэрэгжих төслүүдэд илүү анхаарал хандуулан үнэлгээг хийнэ.

Анхан шатны бүтэц нь тодорхой салбарын буюу тодорхой нэр заасан төслүүдийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх зориулалтаар байгуулагдана. Бүрэлдэхүүнийг сонгохдоо тухайн хяналт, үнэлгээ явуулах чиглэлийг харгалзан гишүүдийг оролцуулна. Гишүүдийн тоо нь 6 хүртэл байна.

Хяналт, үнэлгээнд зарим үед мэргэжлийн баг-ийг зохион байгуулж болох бөгөөд ийм багийг онцгой ач холбогдол бүхий төслүүдийн хэрэгжилтийг үнэлэхэд ашиглах бөгөөд төлөвлөлт, хяналтын хорооны гишүүдээс гадна мэргэжлийн эксперт оролцуулах байдлаар зохион байгуулна.

Бүх шатлалын хяналт, үнэлгээний багууд нь хяналт, үнэлгээ хийх төслүүдийн жагсаалт, ИТХ, ТХХ-оос баталсан удирдамжтайгаар ажиллаж, үр дүнгийн тусгай илтгэх хуудас, олон нийтэд зориулсан мэдээлэл, төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх саналаа бэлтгэн удирдамж батлагчид танилцуулж хүлээлгэн өгч байна.

Сумын Төлөвлөлт, хяналтын хорооны хамтын ажиллагаа

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн бодлогыг тодорхойлох, хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд голлох үүрэгтэй оролцогчийн хувьд төлөвлөгөөтэй хамааралтай асуудлаар холбогдогчидтой харилцаж, хамтран ажиллана. Хамтран ажиллахдаа сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний хавсралт хэсэг болгон баталсан иргэд олон нийттэй харилцах, хамтран ажиллах төлөвлөгөөг удирдлага болгоно. Хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөг сурталчлах, мэдээлэл түгээх, зөвлөгөө нэвтрүүлэх талаар тодорхойлсон арга хэмжээнүүдийг нэгбүрчлэн хэрэгжүүлнэ.

Үүний зэрэгцээ хамтын ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал. Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний асуудлаар ИТХ-тай байнгын холбоотой ажиллана.

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй холбоотой асуудлыг ИТХ-аар хэлэлцэх тухай бүрд төлөвлөлт, хяналтын хороо тухайн асуудлаар төлөөллөө оролцуулж байр сууриа илэрхийлж байна.

Жил жилийн сумын төсөв, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед өөрийн санал дүгнэлтийг ИТХ-д албан ёсоор оруулан танилцуулж байна.

Иргэдийн хурлын төлөөлөгчид төсөл хэрэгжүүлэх асуудлаар Төлөвлөлт, хяналтын хорооноос захиалга өгч болно.

Засаг даргын Тамгын газар. Сумын Засаг даргын Тамгын газар нь орон нутгийн хөгжлийн асуудлыг хариуцагч төрийн захиргааны байгууллагын хувьд төлөвлөлт, хяналтын хороо түүнтэй нягт хамтран ажиллана.

Төрийн бус байгууллага. Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн төлөө үзэл бодлоо илэрхийлж, эдийн засаг, бизнесийн хөгжил, байгаль орчин, төр, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар дуу хоолой гаргагч төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

Төлөвлөгөөний талаарх болон дээр дурдсан асуудлуудаар дараах байдлаар хамтарч ажиллана. Үүнд:

- Төлөөллийг нь Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүнд оруулах
- Оролцооны үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээг хамтран гүйцэтгэх
- Төлөвлөгөөнд тусгах асуудлаар санал бодлоо солилцох, тэдний саналыг сонсож төлөвлөлтөнд ашиглах
- Хяналт, үнэлгээний багт төлөөллийг оролцуулах
- Төлөвлөгөөтэй холбоотой асуудлаар мэдээлэл солилцох
- Мэдээллийг ил тодоор тэдэнд хүргэж байх
- Шаардлагатай асуудлаар хамтран үзэл баримтлал, дуу хоолойгоо илэрхийлж байх

Улс төрийн намууд. Төлөвлөгөөг бүхэлд нь хэрэгжүүлэх болон ач холбогдол бүхий тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх асуудлыг мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэхийг нам болон түүний нэр дэвшигч нарт санал болгох байдлаар хамтран ажиллаж болно.

Иргэд. Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний асуудлаар иргэдтэй дараах байдлаар хамтран ажиллана.

- Төлөвлөгөөг боловсруулах, түүнд тусгах асуудлын талаар иргэдтэй санал солилцох
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтрах
- Иргэдийн дунд хөдөлгөөн өрнүүлэх
- Хувь нэмэр оруулах аян явуулах
- Байгаль орчны төслүүдэд оролцуулах
- Төслийн хяналт, үнэлгээнд энгийн иргэдийг оролцуулах

Төлөвлөгөөг хэрэгжүүлэгчид болон хандивлагчид. Хэрэгжүүлэгч, хандивлагчидтай хамтрахдаа:

- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхижүүлэх, бүтцээ ашиглан зуучлах
- Хамтын гэрээ, санамж бичиг байгуулан дүгнэж ажиллах
- Хөрөнгө оруулалт, хандивын батламж гардуулах



Журмын хавсралт

**СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНИЙ ТӨСЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ТЭМДЭГЛЭХ, ДҮГНЭХ ХУВИЙН ХЭРЭГ**

Төслийн код, нэр.....

Төслийн хэрэгжилтийг хариуцагч, ТХХ-ны гишүүн

Дд	Хэрэгжүүлэх талаар явуулсан үйл ажиллагаа	Хугацаа	Үйл ажиллагааны үнэлгээ 1-5 баллаар	Хэрэгжилтийн түвшин /Хувиар/	Үнэлгээ хийгчийн гарын үсэг
Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэний явуулж буй үйл ажиллагаа					
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
Төслийг хариуцсан ТХХ-ны гишүүний үйл ажиллагаа					
1					
2					
3					
4					
5					
6					
6					
8					
9					
10					
Төслийн явцад хяналт, үнэлгээ хийсэн байдал					
1			X		
2			X		
3			X		
4			X		
5			X		
6			X		
7			X		

Хөтлөгч: Төлөвлөлт, хяналтын хорооны ажлын бүлгийн ахлагч.....

СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Д\д	Төслийн дугаар, код, нэр ба товч агуулга	Оруулсан өөрчлөлтийн үндэс	Өөрчлөлт оруулсан шийдвэрийн дугаар ба түүний хугацаа	Анхаарах хүчин зүйл
1				
2				
3				

Хөтлөгч. Төлөвлөлт, хяналтын хорооны нарийн бичгийн дарга.....

**УВС АЙМГИЙН ЗАВХАН СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2012-2021 он)-
НИЙ ХҮРЭЭНД СУРТАЛЧЛАХ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛ**

№	Үйл ажиллагаа	Зорилтот бүлэг	Давтамж	Үр дүн
1. СУРТАЛЧЛАХ АЖИЛЛАГАА				
1,1	Сумын хөгжлийн төлөвлөгөөний сурталчлах үйл ажиллагаа	Иргэд, бизнес эрхлэгчид, төрийн бус байгууллага	Төлөвлөгөөний үйл явц эхлэхэд	Харилцан итгэлцэл бий болгох
				Хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлыг танилцуулах
				Ил тод нээлттэй байдал
				Иргэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох
1,2	Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	Иргэд, бизнес эрхлэгчид	Жилд 2 удаа	Шинэ санаа олох
				Иргэдэд төлөвлөгөөний хэрэгжилт, ахиц, үр дүнгийн талаар мэдээлэх
				Тухайн ажлуудыг эрчимжүүлэх талаар туршлага солилцох
1,3	Иргэд, малчдад төслийн нэрсийг гарын авлага хэлбэрээр тараах	сумын иргэд малчид	Эхний жилд	Өрх бүрийн гишүүн бүр мэдээлэл авна
				Иргэн бүр санаачлагатай оролцоно
				Төрийн байгууллагатай хамтран ажиллах санаачлага дээшилнэ
1,4	Улаанбаатар хотын болон аймаг дахь нутгийн зөвлөлтэй хамтран ажиллах	Нутгийн зөвлөл бизнес эрхлэгчид	Жил бүр	Хамтын ажиллагаа өргөжинө
				Хөрөнгө оруулагчдыг татах
				Харилцан туршлага судлах, бодит жишээтэй танилцах боломж бүрдэнэ.
				Хамтын ажиллагааны боломжит салбаруудыг тодорхойлох
1,5	Гадаад, дотоодын байгууллагатай холбоотогтоон ажиллах	Төсөл хөтөлбөрүүдийн нэгж	Тогтмол	Хамтын ажиллагаа өргөжинө
				Туршлага судлана, солилцоно
				Хөрөнгө оруулалт хийгдэнэ.
				Агентлагын үйлчилгэний талаарх мэдээлэл
2. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ АЖИЛЛАГАА				
2,1	Сумын вэбсайт ажиллуулах	Хөрөнгө оруулагчид, төрийн байгууллагууд, бизнесийн сектор, хэвлэл мэдээлэл	Байнга шинэчилж байх	Сонирхсон хөрөнгө оруулагч нар болон бусад талууд мэдээлэл авах
				Энгийн байдлаар харьцангуй бага зардлаар мэдээлэл дамжуулах
				Олон нийтэд мэдээлэл түгээх сайн аргачлалтай болох
				Мэргэжлийн түвшинд хийгдсэн сумын имиж, түр төрхийг бий болгох
2,2	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, ахиц, дэвшил, төслийн хэрэгжилтийн мэдээлэх хуудас	Хөрөнгө оруулагчид, бизнесийн сектор, хэвлэл мэдээлэл	Жил бүр	Олон нийтэд мэдээлэл түгээх хамгийн ашигтай, үр дүнтэй аргыг бий болгох
				Үйл явцын ахиц, дэвшлийн талаар мэдээлэлтэй болох, сэдэл тэмүүлэл болон өөриймсөг сэтгэлгээтэй болох

2,3	Багийн иргэдийн нийтийн хурал	Нийт иргэд, Багийн иргэдийн нийтийн хурал	Жил бүр	Иргэд төслийн талаар мэдээлэлтэй болно
				Иргэдийн сумынхаа хөгжилд оролцох оролцоо нэмэгдэнэ
				Төслийн хэрэгжилтэнд тавих иргэдийн хяналт сайжирна
				Төслөөр хэрэгжсэн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг үр дүнтэй ашиглана.
3. ЗӨВЛӨХ АЖИЛЛАГАА				
3,1	Бизнесийн орчин, хандлагын судалгаа	Орон нутгийн бизнесийн салбар	Жил бүр	Төлөвлөлтөнд ашигтай биенесийн салбарын хэрэгцээний талаар нарийвчилсан мэдээлэл авах
3,2	Сумын Засаг даргад нэр дэвшигчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт төслүүдийг тусгах	Нэр дэвшигч хэрэгжүүлнэ, сумын ИТХурал хяналт тавина	4 жилд 1 удаа	Тухайн жилүүдэд хэрэгжихээр тусгагдсан төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжинэ
				Үйл явцын өрнөлийн талаарх мэдээлэл, төсөөлөл
				ЗДТГ-ын ажлын алба хамтран хэрэгжүүлнэ
3,3	Хөгжлийн талаарх шинэ санаа, санал санаачлагыг дэмжиж ажиллана	Орон нутгийн удирдлага, иргэд иргэний нийгмийн байгууллага	Жил бүр	Иргэдийн санаа бодлыг сонсох
				Гаргасан санал санаачлагыг тухай бүр нь хэрэгжүүлж ажиллана.
3,4	Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажилласнаар гарсан үр дүн бүтээн байгуулалтын ажлыг дүгнэж хэлэлцэх	Сумын ИТХурал, Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага , иргэд	2 жилд 1 удаа	Иргэдэд харагдахуйц тэдгээр дүгнэхүйц үр дүн харагдана.
				Хөтөлбөрийн дагуу төслүүд амжилттай хэрэгжиж бүтээн байгуулалтын ажил хийгдэнэ.
				Хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлснээр суманд оюуны болон бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ

ЗАВХАН СУМЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ХОРОО, АЖЛЫН ХЭСЭГ

**УВС АЙМГИЙН ЗАВХАН СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2012-2021 ОН)-НИЙ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хөтөлбөр	Дд	Төслийн хувийн дугаар, нэр	Хугацаа			Шаардлагатай хөрөнгийн тооцоолол (сая төгрөгөөр)				Хэрэгжүүлэгчид
			Эхлэх	Дуусах	Үргэлжлэх	Нийт төсөв	Орон нутгийн төсөв	Улсын төсөв	Хандив, хөрөнгө оруулагчийн зардал	
Хөтөлбөр 1.1.1. Малын үржлийн ажлын үр дүнг дээшлүүлж, үүлдэр угсааг сайжруулах	1	1.1.1.1. Шилмэл омгийн буур, ингийг бусад аймаг, сумаас худалдан авч сүргийн сайжруулагчаар ашиглах	2015	2021	6	60	10	40	10	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	2	1.1.1.2. Адууны угшлийг сайжруулж, хурдан удмын адуутай болох	2012	2021	10	130	30	0	100	ИТХ, ЗДТГ, МЭҮН, Сумын МСУХолбоо, уяачид
	3	1.1.1.3. Хуц, ухнын тусгай сууриуд бий болгох	2013	2021	9	40	10	15	15	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, баг, төсөл хэрэгжүүлэгч
	4	1.1.1.4. Бод малын зохиомол хээлтүүлгийн цэг байгуулан ажиллуулах	2015	2018	4	45	0	30	15	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, малчид
	5	1.1.1.5. Хээлтүүлэгчийн өвөлжөөний хашаа барих	2013	2018	6	60	10	20	30	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	6	1.1.1.6. Цөм сүрэг бүрдүүлж, үржлийн мал бойжуулах, худалдах	2012	2021	10	30	20	0	10	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, малчид
Хөтөлбөр 1.1.2. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах	7	1.1.2.1. Баг бүрт малын үзлэгийн хашаа барих	2013	2018	6	80	20	20	40	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	8	1.1.2.2. Баг бүрт малын угаалга, ариутгалын суурин цэг байгуулах	2013	2016	4	48	20	14	14	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	9	1.1.2.3. Мал эмнэлэг, ариун цэврийн чанарын лабораторитой болох	2018	2021	4	200	0	150	50	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, малчид, төсөл хэрэгжүүлэгч
Хөтөлбөр 1.1.3. Мал аж ахуйн шинэлэг хэлбэрийг нэвтэрүүлэх	10	1.1.3.1. Ингэ, үнээ болон ямааны загвар фермер байгуулах	2012	2021	10	150	30	90	30	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН, Хоршоо, малчид
	11	1.1.3.2. Тахиа, гахайны аж ахуйг хөгжүүлэх	2013	2021	9	120	20	80	20	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
Хөтөлбөр 1.1.4. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	12	1.1.4.1. Бэлчээрийн ургамал, газрын хөрс, усны биогехимийн шинжилгээ хийлгэх	2013	2015	3	8	1	5	2	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, МЭҮН
	13	1.1.4.2. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	2012	2021	10	40	20	0	20	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд

	14	1.1.4.3. Усалгаатай талбайд жимс, жимсгэнэ тариалах	2013	2021	9	50	20	0	30	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, иргэд
	15	1.1.4.4. Завхан голын дагуу усалгаатай талбайд царгас, согоовор, ерхөг зэрэг малын тэжээлийн ургамал тариалах	2013	2021	9	100	20	30	50	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, иргэд
Хөтөлбөр 1.2.1. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	16	1.2.1.1. Малын тэжээлийн жижиг үйлдвэртэй болох	2013	2018	3	105	35	35	35	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч
	17	1.2.1.2. Ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулах	2013	2017	5	200	100	0	100	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	18	1.2.1.3. Тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах	2014	2018	5	500	0	300	200	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	19	1.2.1.4. Эсгийний үйлдвэр ажиллуулах	2012	2015	4	50	0	25	25	ЗДТГ, ААНБ, иргэд
	20	1.2.1.5. Мал нядлах, мах хадгалах, боловсруулах цэгтэй болох	2012	2014	3	300	10	150	140	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	21	1.2.1.6. Ноос, түүхий эд бэлтгэл, анхан шатны тордолтын цэгтэй болж, үйл ажиллагааг тогтворжуулах	2013	2016	4	100	0	30	70	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
Хөтөлбөр 1.2.2. Орон нутгийн байгалийн нөөцийг ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх	22	1.2.2.1. Загасны үйлдвэр байгуулах	2015	2018	4	150	20	60	70	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	23	1.2.2.2. Тоосго, блокны үйлдвэр байгуулах	2012	2019	8	150	0	0	150	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	24	1.2.2.3. Сангийн далай ордыг түшиглэн давсны жижиг үйлдвэр байгуулах	2013	2021	9	650	0	0	650	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	25	1.2.2.4. Шар толгой, Улаандэлийн газрын ховор элементийн ордыг орон нутагт үр ашигтай нөхцөлөөр ашиглах	2013	2020	7	3000	0	0	3000	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ
	26	1.2.2.5. Барилгын өнгөлгөөний чулууны нөөцийг тогтоолгож үйлдвэрлэлийн зориулалтаар орон нутгийн түвшинд хязгаарлагдмал хүрээнд ашиглах	2013	2017	5	2000	0	0	2000	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ
Хөтөлбөр 1.2.3. Аялал жуулчлалын салбарыг бие даан хөгжүүлэх	27	1.2.3.1. Айраг, Хяргас нуурын хоолойд аялал жуулчлалын цогцолбор байгуулах	2013	2021	9	3000	0	0	3000	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	28	1.2.3.2. Таваг чулуунд аялал жуулчлалын бааз байгуулах	2015	2021	7	1000	0	0	1000	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	28	1.2.3.3. Цахир хошуунд аялал жуулчлалын бааз байгуулах	2016	2021	6	1000	0	0	1000	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд

	30	1.2.3.4. Хос аралд аялал жуулчлалын бааз байгуулах	2015	2021	7	600	0	0	600	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	31	1.2.3.5. Завхан сумын эко аяллын маршрут үүсгэн зохион байгуулах	2014	2017	4	100	100	0	0	ИТХ, ЗДТГ, ААНБ, иргэд
Хөтөлбөр 1.3.1. Худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний хүрээг өргөтгөн хөгжүүлэх	32	1.3.1.1. Хүнсний бөөний худалдааны төвтэй болох	2013	2014	2	150	150	0	0	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	33	1.3.1.2. Сумын төвд 100-150 суудалтай зоогийн газартай болох	2014	2021	8	800	0	0	800	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	34	1.3.1.3. Талх, нарийн боовны үйлдвэрлэлийг өргөжүүлэх	2013	2015	3	25	25	0	0	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	35	1.3.1.4. Сумын төвд бараа, бүтээгдэхүүний нэгдсэн зах байгуулах	2013	2015	2	120	0	0	120	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
Хөтөлбөр 1.3.2. Ахуйн үйлчилгээг хөгжүүлж, нэр төрлийг нь нэмэгдүүлэх	36	1.3.2.1. Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний газрыг бий болгох	2013	2014	2	10	10	0	0	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	37	1.3.2.2. Ахуйн үйлчилгээний нэр төрлийг үе шаттай нэмэгдүүлэн хөгжүүлэх	2013	2020	8	95	40	0	55	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	38	1.3.2.3. Сумын төвд 30 ортой зочид буудал барих	2016	2020	5	900	0	0	900	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
	39	1.3.2.4. Халуун ус, саун, массажны үйлчилгээг өргөжүүлэх	2013	2017	5	50	20	0	30	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч, ААНБ, иргэд
Хөтөлбөр 2.1.1. Сумын холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх	40	2.1.1.1. Сумын төвийг шилэн кабелийн сүлжээнд холбох	2012	2013	2	600	0	600	0	ИТХ, ЗДТГ, гүйцэтгэгч компани
	41	2.1.1.2. Орон нутгийн мэдээллийн студитэй болох	2013	2014	2	50	25	0	25	ИТХ, ЗДТГ, Төсөл хэрэгжүүлэгч
	42	2.1.1.3. Богино долгионы радио станц нээн ажиллуулах	2014	2015	2	15	0	0	15	ИТХ, ЗДТГ, Төсөл хэрэгжүүлэгч, иргэд
	43	2.1.1.4. Интернэт кафе ажиллуулах	2013	2016	4	40	0	0	40	ЗДТГ, ААНБ, иргэд
Хөтөлбөр 2.1.2. Цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх	44	2.1.2.1 Сумын төвийн цахилгаан түгээх 04-ын шугамыг бүрэн шинэчилж, стандартад нийцүүлэх	2013	2016	4	50	1	49	0	ИТХ, ЗДТГ, Увс аймгийн ЦТС ХХК, иргэд
	45	2.1.2.2. Сумын төвөөс Хяргас-Айраг нуурын хоолой, Хэцүү хад чиглэлд 40 км-т 10 квт-ын ЦДАШ байгуулах	2014	2021	3	500	0	500	0	ИТХ, ЗДТГ, Төсөл хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч компани

Хөтөлбөр 2.1.3. Зам, тээврийн үйлчилгээг сайжруулах	46	2.1.3.1. Шар булаг-Наранбулаг чиглэлийн хатуу хучилттай зам байгуулах	2014	2021	8	5000 0	0	50000	0	ИТХ, ЗДТГ, Увс аймгийн Тээвэр авто замын газар, гүйцэтгэгч
	47	2.1.3.2. Сумын төвийг хатуу хучилттай замтай болгох	2015	2020	6	1000	0	1000	0	ИТХ, ЗДТГ, аймгийн Тээвэр, авто замын газар, гүйцэтгэгч
	48	2.1.3.3. Нуурын хоолойд тээврийн хэрэгслийн гарц байгуулах	2012	2013	2	50	0	50	0	ИТХ, ЗДТГ, гүйцэтгэгч
	49	2.1.3.4. Нийтийн тээврийн үйлчилгээний нэгдсэн цэгтэй болох	2013	2016	4	15	5	0	10	ИТХ, ЗДТГ, Төсөл хэрэгжүүлэгч, иргэд
	50	2.1.3.5. Шингэн хог, хаягдал зайлуулах зориулалтын тээврийн хэрэгслийн үйлчилгээг нэвтрүүлэх	2013	2015	3	30	0	30	0	ИТХ, ЗДТГ, иргэд
Хөтөлбөр 2.1.4. Сумын төвийн хот байгуулалтыг нэмэгдүүлэх	51	2.1.4.1. Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээг байгуулах	2014	2018	5	2000	0	2000	0	ИТХ, ЗДТГ, гүйцэтгэгч компани
	52	2.1.4.2. Иргэдийг орон сууцжуулах	2013	2021	9	1000	0	500	500	ИТХ, ЗДТГ, иргэд
	53	2.1.4.3. Сумын төвд спортын нэгдсэн цогцолбор байгуулах	2014	2016	3	1000	0	1000	0	ИТХ, ЗДТГ, Гүйцэтгэгч
	54	2.1.4.4. Сумын төвийн гудамж, талбайг гэрэлтүүлэгжүүлэх, тэмдэгжүүлэх, ёслолын хаалга барих	2013	2015	3	30	0	10	20	ИТХ, ЗДТГ, Төсөл хэрэгжүүлэгч, иргэд
	55	2.1.4.5. Хурдан хүрэн азарганы хүндэтгэлийн хөшөө босгох	2015	2016	2	50	25	0	25	ИТХ, ЗДТГ, МСУХолбоо, ивээн тэтгэгч
Хөтөлбөр 2.2.1. Бизнесийн хөгжлийн эрх зүйн орчинг сайжруулах	56	2.2.1.1. Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх	2012	2021	10	10	5		5	ИТХ, ЗДТГ, Хувийн хэвшлийн ААНБ, иргэд
	57	2.2.1.2. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх	2013	2021	9	50	0	50	0	Аймгийн БХБГ, ИТХ, ЗДТГ, БОХ, Газрын даамал,
	58	2.2.1.3. Бизнесийн эрх зүйн орчинг сайжруулан төр, иргэний нийгэм, бизнесийн түншлэлийн хамтын гэрээтэй ажиллах	2012	2021	10	10	5	0	5	ИТХ, ЗДТГ, ТББ, бизнес эрхлэгчид
	59	2.2.1.4. ОХУ-ын Тува болон бусад улсын зарим субъекттай түншийн харилцаа тогтоон хамтарч ажиллах	2013	2021	9	20	20	0	0	ИТХ, ЗДТГ, бизнес эрхлэгчид
	60	2.2.1.5. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг сумаас экспортлох боломж, нөхцөлийг хангах	2013	2021	9	10	5	0	5	ИТХ, ЗДТГ, бизнес эрхлэгчид, иргэд

Хөтөлбөр 2.2.2. Бизнесийг дэмжих, хамгаалах үйлчилгээг төгөлдөржүүлэх	61	2.2.2.1 Жижиг үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний нэгдсэн парк-төв байгуулах	2014	2021	8	500	0	200	300	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч
	62	2.2.2.2. Бизнесийн сургалт, зөвөлгөө, зуучлалын нэгж байгуулах	2015	2021	6	20	5	0	15	ИТХ, ЗДТГ, иргэд
	63	2.2.2.3. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог дэмжин нэмэгдүүлэх	2014	2021	8	800	0	400	400	ИТХ, ЗДТГ, Мэргэжлийн ААНБ, иргэн
	64	2.2.2.4. Цагдаагийн хэсгийг унаажуулах	2013	2016	4	25	0	25	0	ИТХ, ЗДТГ, Аймгийн ЦГазар
Хөтөлбөр 3.1.1. Багш, ажилчид, зарим суралцагчдад зориулсан таатай нөхцөлийг бүрдүүлэх	65	3.1.1.1. Багш, ажилчдын чийрэгжүүлэлтийн танхимтай болох	2013	2015	3	15	0	0	15	ИТХ, ЗДТГ, Сургууль хандивлагч
	66	3.1.1.2. Хүүхэд хөгжлийн танхим байгуулан ажиллуулах	2012	2013	2	20	3	0	17	ИТХ, ЗДТГ Сургууль, хандивлагч
	67	3.1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан тусгай танхимтай болох	2013	2016	4	10	1	0	9	ИТХ,ЗДТГ, Сургууль, хандивлагч
	68	3.1.1.4. Хүүхдийн соёл, амралтын зуслан байгуулах	2013	2018	6	90	10	20	60	ИТХ,ЗДТГ, Сургууль, төсөл хэрэгжүүлэгч
	69	3.1.1.5. Үйлчилгээний авто машинтай болох	2012	2016	5	30	0	20	10	ИТХ,ЗДТГ, Сургууль хандивлагч
Хөтөлбөр 3.1.2. Сургуулийн сургалтын орчин, материаллаг баазыг нэмэгдүүлэх	70	3.1.2.1. Сургалтын кабинетүүдийн тохижилтыг сайжруулж, бүх хичээлийг кабинетаар явуулах	2012	2016	5	150	0	100	50	ИТХ,ЗДТГ Сургууль, хандивлагч
	71	3.1.2.2. Анги бүрийг компьютер, LCD проектортой болгох	2013	2016	4	30	0	30	0	ИТХ, ЗДТГ, Сургууль, хандивлагч
	72	3.1.2.3. Компьютерийн танхимийг ширээ сандлаар хангаж, тохижуулах	2013	2014	2	4	0	2	2	ИТХ,ЗДТГ Сургууль хандивлагч
	73	3.1.2.4. Биеийн тамир, хөдөлмөрийн болон дуу хөгжмийн кабинетуудыг тохижуулах	2013	2016	4	50	3	25	22	ИТХ,ЗДТГ Сургууль хандивлагч
	74	3.1.2.5. Алдрын танхим байгуулан тохижуулах	2013	2014	2	10	2	0	8	ИТХ,ЗДТГ Сургууль хандивлагч
	75	3.1.2.6. Сургуулийн орчныг ногоон бүс болгон тохижуулах	2012	2017	6	20	5	0	15	ИТХ,ЗДТГ Сургууль хандивлагч
	76	3.1.2.7. Сургуулийн хичээлийн байранд их засвар хийж тохижуулах	2014	2019	6	200	0	200	0	ИТХ,ЗДТГ Сургууль хандивлагч
	77	3.1.2.8. Дотуур байрны орчин	2012	2018	7	100	0	50	50	ЗДТГ Сургууль хандивлагч

		нөхцөлийг сайжруулах								
	78	3.1.2.9. Гал тогооны байр шинээр барих	2013	2015	3	200	0	200	0	ЗДТГ Сургууль хандивлагч
	79	3.1.2.10. Сургуулийн номын санд цахим үйлчилгээ нэвтрүүлж, уншлагын танхимыг тохижуулах	2013	2015	3	20	0	20	0	ИТХ,ЗДТГ Сургууль хандивлагч
	80	3.1.2.11. Албан бус боловсролын “Тэгээрэл төв”-ийг байр, техник хэрэгслээр хангаж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	2013	2016	4	10	0	5	5	ИТХ,ЗДТГ Сургууль хандивлагч
Хөтөлбөр 3.2.1. СӨБ-ын үйлчилгээний менежментийг сайжруулах	81	3.2.1.2. Багш хөгжлийн төв байгуулах	2013	2016	4	20	0	20	0	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг
	82	3.2.1.3. Багш, хүүхэд, эцэг эх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх	2012	2021	10	6	2	0	4	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг, иргэд, ААНБ
Хөтөлбөр 3.2.2. СӨБ-ын үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах	83	3.2.2.1. Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн танхимыг тохижуулах, сургалтын техник хэрэгслээр хангах	2013	2015	3	18	5	5	8	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг, хандивлагч
	84	3.2.2.2. Гал тогоог тоног төхөөрөмжөөр хангах	2012	2013	2	20	0	20	0	ЗДТГ, Цэцэрлэг
	85	3.2.2.3. Цэцэрлэгийн гадна талбайг хашаатай болгох	2012	2013	2	10	0	10	0	ЗДТГ, Цэцэрлэг
	86	3.2.2.4. Цэцэрлэгийн тоглоомын талбайг тохижуулах, ногоон байгууламжтай болох	2012	2015	4	30	2	15	13	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг, төсөл хэрэгжүүлэгч
	87	3.2.2.5. Дуу хөгжмийн боловсрол эзэмшүүлэх өрөөг тохижуулж, техник хэрэгслээр хангах	2012	2016	5	10	4	4	2	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг, төсөл хэрэгжүүлэгч
	88	3.2.2.6. Анги, бүлэг бүрийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайг шинэчлэх, нэмэгдүүлэх	2013	2018	6	15	5	8	2	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг, төсөл хэрэгжүүлэгч
Хөтөлбөр 3.2.3. Хөдөөгийн хүүхдийг СӨБ-д хамруулах	89	3.2.3.1. Хөдөөгийн багуудын гэр цэцэрлэгийг шинэчлэх	2014	2018	5	12	0	7	5	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг, хандив, төсөл хөтөлбөр
	90	3.2.3.2. Нүүдлийн болон гэр цэцэрлэгийн үйлчилгээний автомашинтай болох	2013	2015	3	25	0	25	0	ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг

Хөтөлбөр 3.3.1. Соёл, урлагийн үйлчилгээний байгууллагын хангамжийг сайжруулах	91	3.3.1.1. Соёл, урлагийн явуулын үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний зориулалтын автомашинтай болох	2013	2016	4	25	0	25	0	ИТХ, ЗДТГ, Соёлын төв
	92	3.3.1.2. Соёлын төвийг техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгээр бүрэн хангах	2013	2015	10	24	5	14	5	ИТХ, ЗДТГ, Соёлын төв, төсөл хэрэгжүүлэгч
	93	3.3.1.3. Уран сайханчдыг тоглолтын хувцас, хэрэглэлээр хангах	2012	2014	3	8	2	0	6	ИТХ, ЗДТГ, Соёлын төв
	94	3.3.1.4. Номын сангийн цахим үйлчилгээ нэвтрүүлэх	2012	2013	2	10	0	5	5	ИТХ, ЗДТГ, Соёлын төв
	95	3.3.1.5. Орон нутаг судлах кабинетыг байртай болгож, тохижуулах, үзмэрийг баяжуулах	2012	2015	4	100	20	50	30	ИТХ, ЗДТГ, Соёлын төв, ААНБ, иргэд
Хөтөлбөр 3.3.2. Соёл, урлагийн үйлчилгээний байрны нөхцөлийг сайжруулах	96	3.3.2.1. Номын сангийн уншлагын танхимыг тохижуулах	2013	2014	2	10	1	9	0	ИТХ, ЗДТГ, Соёлын төв, төсөл хэрэгжүүлэгч
	97	3.3.2.2. Соёлын төвийн байрны халаалтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх	2012	2013	2	80	0	80	0	ИТХ, ЗДТГ, Соёлын төв
	98	3.3.2.3. Соёлын төвийн барилгад их засвар хийж үйлчилгээний стандартад нийцүүлэх	2013	2015	3	100	0	100	0	ИТХ, ЗДТГ, Соёлын төв
Хөтөлбөр 3.3.3. Түүхэн уламжлалыг сэргээх, хамгаалах	99	3.3.3.1. Түүх, соёлын дурсгалт газар, зүйлүүдийг хамгаалалтанд авах, хэсэгчлэн хайсжуулах	2013	2018	6	8	4	0	4	ИТХ, ЗДТГ, Соёлын төв, иргэд
	100	3.3.3.2. Хүн амыг угийн бичгийг бүрэн хэмжээгээр хөтлүүлэх	2012	2014	3	4	2	0	2	ИТХ, ЗДТГ, Соёлын төв, иргэд
	101	3.3.3.3. Дарь эхийн сүмийг техник хэрэгслээр хангах, бурхан шашны уламжлалыг сэргээх	2013	2016	4	50	0	0	50	ИТХ, ЗДТГ, Соёлын төв, иргэд
Хөтөлбөр 3.4.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх	102	3.4.1.1. Суманд зонхилон тохиолдож буй өвчлөлийн судалгаа гаргаж өвчлөлийг бууруулах арга хэмжээ авах	2012	2021	10	8	4	4	0	ИТХ, ЗДТГ, Сумын ЭМТ
	103	3.4.1.2. Өвчлөлөөс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийн сургалтыг зохион байгуулах, сургалтын тусгайлсан танхим байгуулж тохижуулах	2012	2014	3	14	4	6	4	ИТХ, ЗДТГ, Сумын ЭМТ, иргэд
	104	3.4.1.3. "Эх, хүүхдийн эрүүл мэнд" төсөл хэрэгжүүлэх	2012	2018	6	10	0	5	5	ИТХ, ЗДТГ, Сумын ЭМТ, ААНБ, иргэд

Хөтөлбөр 3.4.2. Эмчилгээ, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, чанаржуулах	105	3.4.2.1. Мэргэшсэн хүүхдийн эмчтэй болох	2013	2015	3	5	5	0	0	ЭМЯ, Аймгийн ЭМГ, ИТХ, ЗДТГ, ЭМТ
	106	3.4.2.2. Сумын хүн эмнэлэгт рентген аппарат авах	2013	2018	6	200	0	200	0	ЭМЯ, Аймгийн ЭМГ, Сумын ИТХ, ЗДТГ, ЭМТ
	107	3.4.2.3. Зайн оношлогооны багажаар хангах	2013	2016	4	45	0	45	0	ЭМЯ, Аймгийн ЭМГ, Сумын ИТХ, ЗДТГ, ЭМТ
	108	3.4.2.4. Физик эмчилгээний багаж, тоног төхөөрөмжөөр хангах	2013	2014	2	20	0	10	10	ИТХ, ЗДТГ, Сумын ЭМТ
Хөтөлбөр 3.4.3. Эмчилгээ, үйлчилгээний байрны нөхцөлийг сайжруулах	109	3.4.3.1. Өдрийн эмчилгээний тасаг нээн ажиллуулах	2013	2015	3	20	0	20	0	Аймгийн ЭМГ, сумын ИТХ, ЗДТГ, ЭМТ
	110	3.4.3.2. Уламжлалт болон эмийн бус эмчилгээний сувилал байгуулах	2013	2015	3	20	3	0	17	ИТХ, ЗДТГ, ЭМТ, төсөл хэрэгжүүлэгч
	111	3.4.3.3. Эмийн сангийн байрыг шинээр бариулах	2013	2015	3	80	0	80	0	ИТХ, ЗДТГ, ЭМТ, гүйцэтгэгч компани
	112	3.4.3.4. Шинжилгээ оношлогооны лаборатори нээн ажиллуулах	2013	2018	7	200	0	200	0	Аймгийн ЭМГ, ИТХ, ЗДТГ, ЭМТ
	113	3.4.3.5. Эмнэлгийн барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, засварлах	2013	2016	4	180	0	180	0	ИТХ, ЗДТГ, ЭМТ, гүйцэтгэгч компани
Хөтөлбөр 3.5.1. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган хүртээмжийг нэмэгдүүлэх	114	3.5.1.1. Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх	2012	2013	10	20	0	20	0	ИТХ, ЗДТГ
	115	3.5.1.2. Эрх зүйн туслалцааны төв байгуулан ажиллуулах	2013	2021	10	10	2	3	5	ЗДТГ
	116	3.5.1.3. Төрийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн цахим болон явуулын сантай болж иргэдэд мэдээлэл түгээхэд ашиглаж байх	2013	2021	10	20	10	10	0	ИТХ, ЗДТГ, төсвийн байгууллагууд
	117	3.5.1.4. Дотоодын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах	2013	2015	3	15	5	10	0	ИТХ, ЗДТГ
	118	3.5.1.5. Сумын вэб сайт нээж ажиллуулах	2012	2021	10	5	1	0	4	ИТХ, ЗДТГ, хандивлагч
	119	3.5.1.6.Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудыг интернэтийн дотоод сүлжээнд холбох	2013	2015	10	10	3	0	7	ИТХ, ЗДТГаз төсөвт байгууллагууд
	120	3.5.1.7. Төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх	2013	2016	4	15	3	3	9	ИТХ, ЗДТГ, ТББ-ууд
Хөтөлбөр 3.5.2.	121	3.5.2.1. Хармагт багийн төвийг шинээр	2012	2013	10	20	0	20	0	ИТХ, ЗДТГ

Малчдад хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах		барих								
	122	3.5.2.2. Шар булаг багийн даргыг унаагаар хангах	2013	2015	4	2	0	1	1	ИТХ, ЗДТГ
	123	3.5.2.3. Хөдөөгийн багийн төвүүдийн гадна дотно орчныг тохижуулах	2013	2016	10	30	5	10	15	ИТХ, ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч
	124	3.5.2.4. Малгүй болон цөөн малтай өрхийг малжуулах	2013	2021	10	200	50	50	100	ИТХ, ЗДТГ, Төсөл хэрэгжүүлэгч, малчид
Хөтөлбөр 3.5.3. Төрийн үйлчилгээний орчинг сайжруулах	125	3.5.3.1. Нутгийн удирдлагын ордонтой болох	2013	2015	10	500	0	500	0	ИТХ, ЗДТГ
	126	3.5.3.2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах	2013	2021	10	250	50	200	0	ИТХ, ЗДТГ
	127	3.5.3.3. Сумын ёслол хүндэтгэлийн өргөө байгуулан ажиллуулах	2013	2021	10	500	100	300	100	ИТХ, ЗДТГ, гүйцэтгэгч
Хөтөлбөр 4.1.1. Байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалтын менежментийг сайжруулах	128	4.1.1.1. Сумын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэх	2013	2018	6	20	0	20	0	ИТХ, ЗДТГ, БОХ.
	129	4.1.1.2. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах	2012	2021	Байнга	150	50	90	10	ИТХ, ЗДТГ, БОХ, Цаг уурын өртөө, малчид
	130	4.1.1.3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд иргэдийн оролцоог хангаж, малчдын бүлэг, байгаль хамгаалах нөхөрлөлийн тоог нэмэгдүүлэх	2012	2021	Байнга	10	10	0	0	ИТХ, ЗДТГ, БОХ, малчид
	131	4.1.1.4. Баг бүр хадлан, тэжээлийн ургамлын 2-оос доошгүй талбайтай болох (20 га газар-Шар мод, Баян хошуу, Сайхан, Цайдам, Өвөр хулсны чиглэл)	2012	2017	5	200	20	80	100	ИТХ, ЗДТГ, МЭҮТ, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	132	4.1.1.5. "Мухарын хойд, урд булгийн эх"-ийг хашиж хамгаалах, мод тарьж тохижуулах	2012	2014	3	30	5	0	25	ИТХ, ЗДТГ, БОХ, Төсөл хэрэгжүүлэгч, малчид
	133	4.1.1.6. Гүний болон гадаргын усны нөөцийг тогтоох, хамгаалалтыг сайжруулах	2013	2015	3	50	10	30	10	ИТХ, ЗДТГ, БОХ, судалгааны байгууллага
	134	4.1.1.7. Сумын төвийн ундны усны эх үүсвэрүүдэд цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	2013	2015	3	100	0	80	20	ИТХ, ЗДТГ, БОХ

	135	4.1.1.8. Завхан голын хамгаалалтын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2013	2015	3	20	20	0	0	ИТХ, ЗДТГ, БОХ, малчид
	136	4.1.1.9. Хяргас, Айраг нуурын загасны судалгаа хийж, нөөцийг тогтоох, үржүүлэх	2013	2015	3	30	0	30	0	ИТХ, ЗДТГ, БОХ
	137	4.1.1.10. Биологийн төрөл зүйлийг иргэдийн оролцоотойгоор хамгаалах	2012	2021	10	13	13	0	0	ИТХ, ЗДТГ, БОХ, бүлэг, нөхөрлөл, иргэд
Хөтөлбөр 4.1.2. Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	138	4.1.2.1. Завхан голын дагууд 62 мянган метрт ойн зурвас байгуулах	2012	2021	10	1000	0	100	900	ИТХ, ЗДТГ, БОХ, Төсөл хэрэгжүүлэгч, Нөхөрлөл
	139	4.1.2.2. Суманд мод үржүүлгийн газар байгуулах.	2012	2013	2	60	0	60	0	ИТХ, ЗДТГ, БОХ, Төсөл хэрэгжүүлэгч
	140	4.1.2.3. Мод орлох хийн болон шахмал түлшийг ахуйн хэрэглээнд ашиглах	2013	2021	10	120	0	50	70	ИТХ, ЗДТГ, Төсөл хэрэгжүүлэгч, иргэд
Хөтөлбөр 4.2.1. Байгаль хамгаалах зориулалтын техник хэрэгслийн хангамжийг сайжруулах	141	4.2.1.1. "ЭКО КЛУБ" - ыг тоног төхөөрөмжөөр хангах	2012	2013	2	5	0	0	5	ИТХ, ЗТГ, БОХ, Сургууль, төсөл хэрэгжүүлэгч
	142	4.2.1.2. Сумын байгаль орчны хэсгийг шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангах, унаажуулах	2012	2016	5	30	0	5	25	ИТХ, ЗДТГ, БОХ, Төсөл хэрэгжүүлэгч
	143	4.2.1.3. Цаг уурын өртөөний байрыг засварлаж, тохижуулах	2014	2015	2	50	0	50	0	УЦУОШГ, ИТХ, ЗДТГ, Цаг уурын өртөө
	144	4.2.1.4. Цаг уурын шинжилгээ, ажиглалтын автомат станц суурилуулан техник хэрэгслээр хангаж цахим мэдээллийн сүлжээ нэвтрүүлэх	2012	2014	2	50	0	50	0	ИТХ, ЗДТГ, Цаг уурын өртөө
Хөтөлбөр 4.2.2. Байгаль орчны бохирдлыг бууруулах	145	4.2.2.1. Сумын төвийн хог зөөвөрлөх зориулалтын машинтай болох	2013	2014	2	25	0	0	25	ИТХ, ЗДТГ, БОХ, Төсөл хэрэгжүүлэгч
	146	4.2.2.2. Хуучин балгас, шороон хогийг овоолго болгон нөхөн сэргээх	2012	2013	2	40	0	20	20	ИТХ, ЗДТГ, БОХ, төсөл хэрэгжүүлэгч
	147	4.2.2.3. Сумын төвийн хогийн цэгт хязгаар тогтоон хашаажуулж тэмдэгжүүлэх, хамгаалалттай болгох	2012	2014	3	50	10	20	20	ИТХ, ЗДТГ, БОХ, Төсөл хэрэгжүүлэгч
	148	4.2.2.4. Сумын төвд нийтийн бие засах газар, стандартын бохир усны цооногтой болох	2013	2015	3	30	10	10	10	ИТХ, ЗДТГ, БОХ, төсөл хэрэгжүүлэгч

ЗАВХАН СУМЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ХОРОО, АЖЛЫН ХЭСЭГ

**УВС АЙМГИЙН ЗАВХАН СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2012-2021 он)-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ,
ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ**

<i>Хөтөлбөр</i>	<i>Д/Д</i>	<i>Төслийн хувийн дугаар, нэр</i>	<i>Хэрэгжилт, үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд</i>	<i>Ашиглах мэдээллийн эх үүсвэрүүд</i>	<i>Хяналт, үнэлгээ хийх хугацаа</i>
Хөтөлбөр 1.1.1. Малын үржлийн ажлын үр дүнг дээшлүүлж, үүлдэр угсааг сайжруулах	1	1.1.1.1. Шилмэл омгийн буур, ингийг бусад аймаг, сумаас худалдан авч сүргийн сайжруулагчаар ашиглах	Сайжруулсан үүлдэр, омог, угшлийн малын тоо толгой, хувийн жин тогтвортой өсөж малчдын амьдрал дээшилж байх	Гэрчилгээний баяжилт, мал тооллогын статистик мэдээ, сайжруулсан малын судалгаа	2016, 2019, 2022
	2	1.1.1.2. Адууны угшлийг сайжруулж хурдан удмын адуутай болох	Адууны чанар сайжирч, хурдлах чадвар,хурдан удмын адууны тоо өссөн байх.	Гэрчилгээний баяжилт, уяачдын сэтгэл ханамжийн судалгаа	2014, 2016, 2019, 2022
	3	1.1.1.3. Хуц, ухнын тусгай сууриуд бий болгох	Хуц, ухнын арчилгаа, маллагаа сайжирч, үржлийн ажил мэргэжилтний хяналтын дор явагддаг болсон байх	Хуц, ухнын суурийн үйл ажиллагааны үнэлгээ, үржлийн мэргэжилтний ажлын тэмдэглэл	2015, 2016, 2017, 2019, 2022
	4	1.1.1.4. Бод малын зохиомол хээлтүүлгийн цэг байгуулан ажиллуулах	Зохиомол хээлтүүлгийн цэг баригдаж, зохиомол хээлтүүлгийн хамрах хүрээ нэмэгдэж байх	Цэг байгуулсан тухай баримт бичиг, цэгийн ажлын тайлан, судалгаа, хээлтүүлгийн журнал	2016, 2017, 2019, 2022
	5	1.1.1.5. Хээлтүүлэгчийн өвөлжөөний хашаа барих	Хашаа баригдан ашиглагдаж, хээлтүүлэгчийн хорогдол гараагүй буюу тогтмол буурсан байх	Мал өвөлжүүлэлт, хорогдлын мэдээ, хашаа хорооны судалгаа, барьсан хашааны гэрэл зургууд	2015, 2016, 2018, 2022
	6	1.1.1.6. Цөм сүрэг бүрдүүлж, үржлийн мал бойжуулах, худалдах	Цөм сүргийн тоо, төрөл нэмэгдсэн, ашиг шим дээшилж, борлуулалт нь өсөж байх	Цөм сүргийн бүртгэл хөтлөлт, ашиг шим, борлуулалтын судалгаа	2014, 2016,2019, 2022
Хөтөлбөр 1.1.2. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах	7	1.1.2.1. Баг бүрт малын үзлэгийн хашаа барих	МЭҮН-ийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, мал эрүүлжиж байх	Малчдын сэтгэл ханамж, үзлэгийн хамралтын судалгаа, тайлан мэдээ	2016, 2019, 2022
	8	1.1.2.2. Баг бүрт малын угаалга, ариутгалын суурин цэг байгуулах	Багтаа угаалга, ариутгалд хамрагдсан малын тоо, хувь хэмжээ нэмэгдэж, мал эрүүлжиж байх	Уг цэгүүдэд угаалга, ариутгалд хамрагдсан өрх, малын судалгаа, эктопаразит өвчний мэдээ	2016, 2017, 2019, 2022
	9	1.1.2.3. Мал эмнэлэг, ариун цэврийн чанарын лабораторитой болох	Мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээ хийж, баталгаа, гэрчилгээ олгодог болох	Лабораторийн тайлан, баталгаа, гэрчилгээ олголтын бүртгэл	2016, 2019, 2020, 2022
Хөтөлбөр 1.1.3. МАА-н шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх	10	1.1.3.1. Ингэ, үнээ болон ямааны загвар фермер байгуулах	Сүү үйлдвэрлэл нэмэгдэж, хүнсний хангамж сайжирсан байна	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ, судалгаа	2016, 2019, 2022
	11	1.1.3.2. Тахиа, гахайны аж ахуйг хөгжүүлэх	Ажлын байр нэмэгдэж, гахай, тахианы гаралтай бүтээгдэхүүн өсөн нэмэгдэж байх	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ, судалгаа	2016, 2019, 2022
Хөтөлбөр 1.1.4. Газар	12	1.1.4.1. Бэлчээрийн ургамал, газрын хөрс, усны биогехимийн шинжилгээ	Шинжилгээний дүгнэлт гарч, үр дүнг сумын байгууллагууд үйл ажиллгандаа	Шинжилгээний тайлан, түүний үр дүнд үнлэсэн зохиосон ажлын	2014, 2016, 2019, 2022

тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх		хийлгэх	ашиглаж байх	мэдээ, судалгаа	
	13	1.1.4.2. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	Хүлэмжийн аж ахуйн бүтээгдэхүүн жилээс жилд өсөн нэмэгдэж байх	Газар тариалан эрхлэлтийн мэдээ, судалгаа	2014, 2016, 2019, 2022
	14	1.1.4.3. Усалгаатай талбайд жимс, жимсгэнэ тариалах	Жимс, жимсгэний ургац, борлуулалт жилээс жилд өсөн нэмэгдэж байх	Газар тариалан эрхлэлтийн мэдээ, судалгаа	2013, 2016, 2019, 2022
	15	1.1.4.4. Завхан голын дагуу усалгаатай талбайд царгас, согоовор, ерхөг зэрэг малын тэжээлийн ургамал тариалах	Усалгаатай талбай, тэндээс ашигласан хадлан, тэжээлийн ургамлын хэмжээ тогтвортой өсөж байх	Газар тариалан эрхлэлт, хадлангийн жил бүрийн мэдээ, судалгаа	2014, 2016, 2019, 2022
Хөтөлбөр 1.2.1. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	16	1.2.1.1. Малын тэжээлийн жижиг үйлдвэртэй болох	Өөрийн нөөцөд суурилсан тэжээлийн үйлдвэр ажиллаж, сумын малчдыг тэжээлээр бүрэн хангадаг болсон байх	Малын тэжээлийн борлуулалтын хэмжээ, хэрэглэгчдийн сэтгэл хангамжийн судалгаа, тайлан	2015, 2016, 2019, 2022
	17	1.2.1.2. Ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулах	Ингэний сүүгээр үйлдвэрлэсэн айраг, ааруул, аарц зэргийн хэмжээ жилээс жилд өсөж, борлуулалт нэмэгдэж байх.	Борлуулалтын орлого, нэр төрлийн тоо, тайлан, ажилчдын тоо	2014, 2016, 2017, 2019, 2022
	18	1.2.1.3. Тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах	Үйлдвэрлэл бий болж, үйл ажиллагаа нь тогтмолжж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт тогтвортой өсөж байх.	Бүтээгдэхүүний нэр төрлийн судалгаа, тайлан, хэрэглэгчийн тоо, орлого	2016, 2019, 2022
	19	1.2.1.4. Эсгийний үйлдвэр ажиллуулах	Үйлдвэрлэл бий болж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх	Бүтээгдэхүүний нэр төрлийн ба борлуулалтын мэдээ, судалгаа	2016, 2019, 2022
	20	1.2.1.5. Мал нядлах, мах хадгалах, боловсруулах цэгтэй болох	Махны ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангагдаж, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, зохих нөөц бүрддэг болсон байх	Борлуулалтын орлого, эрүүл ахуй, ариун цэврийн зөрчлийн судалгаа, цэгийн үйл ажиллагааны тайлан	2014, 2016, 2019, 2022
	21	1.2.1.6. Ноос, түүхий эд бэлтгэл, анхан шатны тордолтын цэгтэй болж, үйл ажиллагааг тогтворжуулах	Ноос түүхий эд бэлтгэх, анхан шатны тордолтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж ажлын байр бий болно.	Бүтээгдэхүүний нэр төрлийн судалгаа, тайлан	2016, 2017, 2019, 2022
Хөтөлбөр 1.2.2. Орон нутгийн байгалийн нөөцийг ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх	22	1.2.2.1. Загасны үйлдвэр байгуулах	Тухайн үйлдвэрлэл, борлуулалт өсөх буюу нөөцтэйгөө уялдан тогтворжсон байх	Загасны олборлолтын хэмжээ, борлуулалтын мэдээ, тайлан	2016, 2019, 2022
	23	1.2.2.2. Тоосго, блокны үйлдвэр байгуулах	Үйлдвэрлэл тогтмолжиж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж байх	Бүтээгдэхүүний нэр төрөл, борлуулалтын мэдээ, судалгаа	2016, 2017, 2019, 2022
	24	1.2.2.3. Сангийн далай ордыг түшиглэн давсны жижиг үйлдвэр байгуулах	Үйлдвэрлэл бий болж, үйл ажиллагаа нь тогтмолжиж, нутгийн хүн амд үр ашгаа өгч байх	Олборлолтын болон борлуулалтын хэмжээ, ажлын байрны мэдээ, судалгаа, тайлан	2016, 2019, 2022
	25	1.2.2.4. Шар толгой, Улаандэлийн газрын ховор элементийн ордыг орон нутагт үр ашигтай нөхцөлөөр ашиглах	Зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлж, орон нутгийн болон сумын иргэдийн орлого нэмэгдэхийн зэрэгцээ байгаль орчинд сөрөг нөлөө гараагүй байх.	Борлуулалтын орлого, үйл ажиллагааны болон ажлын байрны мэдээ, судалгаа, нөхөн сэргээлт хийсэн тухай тайлан, мэдээ	2016, 2019, 2022

	26	1.2.2.5. Барилгын өнгөлгөөний чулууны нөөцийг тогтоолгож үйлдвэрлэлийн зориулалтаар орон нутгийн түвшинд хязгаарлагдмал хүрээнд ашиглах	Зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлж, орон нутгийн болон сумын иргэдийн орлого нэмэгдэхийн зэрэгцээ байгаль орчинд сөрөг нөлөө гараагүй байх	Борлуулалтын орлого, үйл ажиллагааны болон ажлын байрны мэдээ, судалгаа, нөхөн сэргээлт хийсэн тухай тайлан, мэдээ	2016, 2018, 2019, 2022
Хөтөлбөр 1.2.3. Аялал жуулчлалын салбарыг бие даан хөгжүүлэх	27	1.2.3.1. Айраг, Хяргас нуурын хоолойд аялал жуулчлалын цогцолбор байгуулах	Стандарт хангасан цогцолбор баригдаж, цогцолбороор үйлчлүүлсэн аялагчид, жуулчдын тоо тогтвортой өсөж байх	Жуулчдын тоо, чанарын судалгаа, борлуулалтын орлогын мэдээ	2016, 2019, 2022
	28	1.2.3.2. Таваг чулуунд аялал жуулчлалын бааз байгуулах	Жуулчид, амрагчид ая тухтай амрах бааз байгуулагдаж жуулчдын тоо өссөн байх	Жуулчдын тоо, чанарын судалгаа, борлуулалтын орлогын мэдээ	2016, 2019, 2022
	29	1.2.3.3. Цахир хошуунд аялал жуулчлалын бааз байгуулах	Жуулчид, амрагчид ая тухтай амрах бааз байгуулагдаж жуулчдын тоо өссөн байх	Жуулчдын тоо, чанарын судалгаа, борлуулалтын орлогын мэдээ	2014, 2016, 2019, 2022
	30	1.2.3.4. Хос аралд аялал жуулчлалын бааз байгуулах	Жуулчид, амрагчид ая тухтай амрах бааз байгуулагдаж жуулчдын тоо өссөн байх	Жуулчдын тоо, чанарын судалгаа, борлуулалтын орлогын мэдээ	2016, 2019, 2022
